Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Хөтлөх үү, хөтлүүлэх үү

Шинэ нар мандаж эхэллээ

Хөгжлийн тасалбар

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 06 сар. №010 (020) www.mongolianeconomy.mn



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ АЯСЫН САЛХИ ҮЛЭЭВ ҮҮ

8 658000 679416

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2012 International Year of Cooperatives



“ХОРШОО- ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР-2012” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

Монгол Улсын Засгийн Газрын санаачилгаар НҮБ-аас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарласан, “Хөдөөг хоршоолох аян”-ыг эхлүүлсэн, “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд “Хоршоо- Жижиг, дунд үйлдвэр-2012” үзэсгэлэн худалдааг 2012 оны 05 сарын 31-ний өдрөөс 2012 оны 06 сарын 04-ний өдөр хүртэл Улаанбаатар хотноо Мишээл экспо төвд 3 дахь жилдээ зохион байгуулах гэж байна.

Энэхүү үзэсгэлэн худалдаа нь хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн болон бичил бизнес, эрхлэгчдийг дэмжих, тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилготой бөгөөд Улаанбаатар хот, 21 аймгийн иргэн, аж ахуйн нэгжүүд оролцож өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэдээ худалдаалах юм.

Мөн түүнчлэн тоног төхөөрөмжийн болон олон улсын төсөл хөтөлбөр, санхүүгийн байгууллагууд танилцуулга мэдээлэл, зөвлөгөө өгч оролцохоороо бусад үзэсгэлэнгүүдээс онцлог болно.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:
Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг
Жижиг, Дунд Үйлдвэрийн Газар

УТАС: 266413
99088073 99100568

РИО ТИНТО-МОНГОЛД ОРУУЛЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-7,8 ИХ НАЯД ТӨГРӨГ

Хөрөнгө оруулагчид 2013 онд Оюу Толгой уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө нийт 7,8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийнэ. Монгол улсын Засгийн газар ямар ч эрсдэлгүйгээр тус төслийн нийт мөнгөн урсгалын 70 хүртэлх хувийг хүртэхээс гадна Оюу Толгой уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө нийт 900 гаруй тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөрийг хүлээн авна.

Рио Тинто компани Монголын уул уурхайн салбарт зэс баяжуулах үйлдвэрийн дэлхийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологи, мэдлэг, туршлагыг нэвтрүүлж байна.

RioTinto



Shandong Equipment LLC

SEM

КАТЕРПИЛЛАРЫН 100% ХӨРӨНГӨ ОРУУЛӨЛТТАЙ БНХАУ-ИЙН SEM MACHINERY КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ДИЛЛЕР ШАНДОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК

ХАМГИЙН ӨРГӨН СОНГОЛТЫГ ХАМГИЙН УЯН ХАТАН НӨХЦӨЛӨӨР...



- Хүчирхэг Шанхай дизель SC11 хөдөлгүүртэй
- CAT Legacy хурдны хайрцаг болон гидр системтэй
- Уул уурхайн хүнд ажлын нөхцөлд зориулагдсан
- Бат бөх, дээд зэрэглэлийн чанар
- Хүнд даацын бат бөх 3.5 м³ хадны шанагаар тоноглогдсон
- Удирдлагын гидр рычаг нь операторын ажиллагааг хялбарчилсан
- Michelin дугуйгаар тоноглогдсон

НҮҮРСНИЙ АЖИЛД ТУСГАЙЛАН ЗОРИУЛСАН ЗАГВАРУУД



SEM660B

- Нүүрс ачилтын ажилд зориулагдсан
- Даац болон багтаамж ихтэй 5.5 м³ нүүрсний шанагаар тоноглогдсон
- Хүчтэй бөгөөд хурдан



SEM650B

- Нүүрс ачилтын ажилд зориулагдсан тусгайлан хийгдсэн УРТ ГАРТАЙ
- Даац болон багтаамж ихтэй 4.5 м³ нүүрсний шанагаар тоноглогдсон
- Хүчтэй бөгөөд хурдан
- Тоосжилттой орчинд ажиллахад зориулагдсан агаар шүүгч болон өвлийн цагт ашиглах хөдөлгүүр халаагчтай.



SEM639B

- Жижиг үйлдвэр болон барилгын ажилд зориулагдсан
- 1.7 м³ стандарт шанагаар тоноглогдсон
- Герман технологиор хийгдсэн Deutz хөдөлгүүртэй
- Түлш зарцуулалт болон ажиллагааны зардал бага хэмнэлттэй



SEM652B

- Үйлдвэр болон барилгын, зам засварын ажилд зориулагдсан
- 3.0 м³ стандарт шанагаар тоноглогдсон
- Түлш зарцуулалт бага бөгөөд хурдан, маневр сайтай



SEM650B

- Уул уурхай, барилга, зам засварын г.м төрөл бүрийн ажилд зориулагдсан
- Хүнд ажлын нөхцөлд зориулагдсан 3.0 м³ шанагатай
- Хүчтэй бөгөөд хурдан
- Операторчны ажиллагааг хялбарчилсан удирдлагын нэг гидр рычагтай



SEM658

- Уул уурхай, барилга, зам засварын г.м төрөл бүрийн ажилд зориулагдсан
- Удаан эдэлгээ, өндөр чанар
- 3.0 м³ стандарт шанагаар тоноглогдсон
- Шанхай дизель хөдөлгүүртэй, найдвартай зөөлөн ажиллагаатай
- Герман технологиор хийгдсэн ZF серийн тэнхлэг болон хурдны хайрцагтай


ЗӨЭЛИЙН ХҮҮГ БИД ТӨЛЬЕ.

Баянгол дүүрэг, Баруун Үйлдвэр-133, Вагнер Азийн байр, Улаанбаатар хот
Утас: 976-11-687588, 9900-7826, 9999-1586 web: www.shandongequipment.com

KOLARZ

Таны амьдралыг
өдөр бүр гэрэлтүүлнэ.









KOLARZ SHOWROOM 1
Наран Плаза, 2-р давхар
Чингисийн өргөн чөлөө 29
Утас: 70116918

KOLARZ SHOWROOM 2
Наран Молл, 2-р давхар
Сөүлийн гудамж 42/1
Утас: 328841

Design by KOLARZ

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:
Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч, Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор: Терэнс Эдвардс
Вэб редактор Б.Энхмарт
Орчуулагч: Б.Үүрийнтуяа
Сэтгүүлчид: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан

Дизайнер, Вэб мастер: Ш.Оюундарь

Олон нийттэй харилцах менежер:
Ж.Алтантуяа 99051914

Маркетингийн менежер: Д.Барианжав 88800825
Б.Энхцэцэг 99015476
Борлуулалтын менежер: С.Цэнд-Аюуш

“Economy” ТВ студи
Дэд захирал: Ц.Буянбат 88112885
Зураглаач: Ц.Бат-Отгон
График дизайн Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Монголд хамгийн сонирхолтой сэдэв өнөөдрийн байдлаар Парламентийн сонгууль юм. Сонгуулийн хугацаа ойртох тусам сонирхолтой асуудлууд хөвөрсөөр. Улс төрийн намуудын хувьд сонгуульд нэр дэвшигчдээ зарлаж, Сонгуулийн штабаа байгуулах гээд бөөн ажил ундраастай. Харин иргэд сонгогчдын хувьд аль нам уралдаанд ямар “морь” сойж байна вэ гэдгийг сониучрхах ч тэдний сэтгэлийн гүнд сонгуулиас чухал асуудлууд хургаастай. Тэр нь юу вэ гэвэл, сонгуулийн дараанаас 21 мянган төгрөгөө авч чадахгүй болно гэж бодохоор дунджаас доогуур амьжиргаатай иргэдийн хувьд нүднийх нь өмнүүр түмэн болохгүй бүтэхгүй асуудал жирэлзэнэ. Харин төрөөс сонгуулиас өмнө өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэг сая төгрөг өгч баярлуулж байгаа ч зуны халуунд банкны үүдэнд халамжийн мөнгөний урт дараалалд зогсоно гэдэг амаргүй. Тэд нэг удаа зогсоод болчихгүй нэг сая төгрөг авах гэж зуны халуунд гурван ч удаа банкны үүд сахина гэж бодохоор хэцүү. Хамгийн гол нь мөнгө горилж зогсож байгаад халуун нар төөнөхийн аяыг даалгүй унаж мэдэх өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шүү дээ, тэд. Түүнчлэн шинэ Засгийн газар бүрэлдэхээр огт мөнгө өгөхгүй болчихвол яана гэсэн болгоомжлол тээсэн хүн ч цөөнгүй бий.

Харин сонгууль хариугүй тулсан энэ үед дөрөв дэх засаглал гэгддэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн редакцийн болоод сэтгүүлчдийн утас тун завгүй буй нь мэдээж. Тухайлбал, намуудын нэр дэвшигчдийн нэрс тодорсон өдрөөс манай сэтгүүлийн редакцийн утас хангинаж, сонгуулийн сурталчилгааны үнэ сонирхох хүн олширлоо. Зүгээр сууж байхад аманд орж ирж байгаа сайхан боломжийг хэлээрээ түлхэх хэн байх билээ гэж үү. Харин “Mongolian Economy” сэтгүүлийн редакцийн хувьд дөрвөн жилд ганц олддог Парламентийн сонгуулийн боломжийг огт ашиглахгүй байхаар шийдлээ. Улс төрөөс хараат бус, бие даасан, цэвэр сэтгүүл зүйг хөгжүүлэх нь манай сэтгүүлийн эрхэм зорилго билээ. Тийм ч учраас сонгуулийн сурталчилгаа хийхээс татгалзаж буйгаа албан ёсоор мэдэгдэж байна. Сэтгүүл зүйн гал тогоо улстөрчдийн нөмөр нөөлгөнд орж, улам бүр бохирлогдож , бугшин өвдөж буй хүнд үед тус салбарт цагаан мөр гаргах нь бидний мөрөөдөл билээ. Сэтгүүлийнхээ үнэ цэнэтэй зай талбайг сонгуулийн сурталчилгаанд зориулахын оронд “утаагүй үйлдвэрлэл” гэгддэг аялал жуулчлалын салбарыг уул уурхайтай хэрхэн эн зэрэгцүүлж хөгжүүлэх вэ, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож байгаа нэг сая төгрөгийн үр дүнд эдийн засагт үүсэх сөрөг үр дагавар, монголчуудын 21 мянган төгрөггүй амьдрал гээд бидэнд бичих сэдэв, сэтгэл эмзэглүүлсэн асуудал бишгүй байгаа юм.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал

Түүх сайтайн хувьд өнөөдрийнхөөс арай л өөр байх ёстой



Монголын аялал жуулчлалын салбарт жилд ойролцоогоор 5-10 хувийн өсөлт гардаг. Зөвхөн тооны араас хөөцөлдөөд, сурталчилгаа сайн хийгээд сая жуулчин олох боломж бол бидэнд байгаа. Гэвч манайд тийм хэмжээний жуулчин хүлээж авах хүчин чадал байхгүй....12

Хөтлөх үү, хөтлүүлэх үү

Хөтөч бол зөвхөн орчуулагч биш юм. Тиймдээ ч тайлбарлагч гэдэг үг дагадаг биз.



Тэнцвэр



Нов ногоон, цав цагаан, цэв цэнхэр энэ бол “Дриймланд”. Үл үзэгдэх мөрөөдлийн орон мэт энэхүү жуулчны бааз голын захаар ургасан моддын дунд үзэмжээ нуун олны хараанаас ангид оршино....10

Өглөө үгүй хүнд амжилт, эрүүл мэндийн аль нь ч байхгүй

“Эртэч Монгол”-ын 48 дахь уулзалт хотоос 100 км орчим зайтай Төв аймгийн Борнуур сумын Далын ам гэдэг газар байрлалтай Бурханч лам Г.Пүрэвбатын “Аглаг” бүтээлийн хийдэд болсон юм...46



НОГООН ЭДИЙН ЗАСАГ

12 Аялал жуулчлалын салбарт аясын салхи үлээв үү

14 Түүх сайтайн хувьд Өнөөдрийнхөөс арай л өөр байх ёстой

17 Хөтлөх үү, хөтлүүлэх үү

20 Тэнцвэр

25 “Өнгөрсөн жил монгол аяллын өсөлтийн жил болсон”

27 Шинэ нар мандаж эхэллээ

32 Бид өсөлтийг хөгжил гэж андуураад байна. Хөгжил нь бидний өөрсдийн уг үндэс дээр цэцэглэхийг хэлдэг юм

Эдийн засаг

38 Хөгжлийн тасалбар

40 Хөдөө аж ахуйн хөрс шинэчлэгдэнэ

44 Амь наана, там цаана

46 Өглөө үгүй хүнд амжилт, эрүүл мэндийн аль нь ч байхгүй

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголын хөрөнгийн биржид өнгөрөгч сарын 15-нд тус бүр нь 105 мянган төгрөгийн үнэ бүхий Засгийн газрын таван ширхэг бондыг анх удаа арилжааллаа. Уг арилжаанд үнэт цаасны (ISIN) дугаар олгож, олон улсын жишигт нийцсэн зарчмын дагуу хийсэн анхны хоёрдогч зах зээлийн арилжаа хэмээн онцолж байна. Монголын хөрөнгийн биржийн мэргэжилтнүүд “Энэ төрлийн үнэт цаасны хоёрдогч зах зээл нээгдсэнээр арилжааны үнийн дүн, өгөөжийн муруй зэрэг үзүүлэлтийг ашиглаж, богино болон урт хугацааны зээлийн суурь индексийг тогтоох боломжтой болж байгаа аж.

УУЛУУРХАЙ

Төмрийн үйлдвэрлэлээрээ улсдаа тэдийгүй дэлхийд дээгүүрт жагсдаг Энэтхэгийн SAIL компани Монголд гангийн үйлдвэр барих санал тавьсан байна. Тус компанийнхан манай талд бизнесийн харилцан ашигтай байх зарчмаар санал тавьсан аж. Тэр нь энэтхэгчүүд манайд коксжих нүүрсний орд эзэмшиж, олборлосон нүүрсээ өөрийнхөө улс руу импортолно. Үүнийхээ хариуд манайд үйлдвэр барьж өгөх аж. Уг саналын дагуу энэ сард SAIL-ийн төмрийн хүдрийн мэргэжилтнүүд Монголд ирэхээр болжээ. Дархан, Сэлэнгийн бүсэд байгаа төмрийн хүдрийн ордууд, Тавантолгой болон бусад нүүрсний ордыг судалж, Монгол Улсад гангийн үйлдвэр барих эдийн засгийн урьдчилсан судалгааг боловсруулах аж.

ДЭД БҮТЭЦ

“Дэнжийн 1000” орчмын гэр хорооллыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг эхлүүллээ. Энэ ажлын хүрээнд дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлэхээр Чингэлтэй дүүргийн IX, X хороо, VII хороолол орчмыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг эхлүүлэв. “Улаанбаатар дулаан” компани уг ажлын гүйцэтгэгчээр ажиллах юм байна. Түүнчлэн Чингэлтэй дүүргийн 39-р сургууль, 124-р цэцэрлэг, шинээр баригдах спорт цогцолбор, амины орон сууц, аж ахуйн нэгжүүдийн барилга, VII хороолол, “Дэнжийн 1000”-ын ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах нийтийн орон сууцуудыг төвлөрсөн дулаанд холбохоор төлөвлөжээ.

Замын түгжрэлийг 20 хувиар багасгах гүүрэн гарцыг Япон улсын буцалтгүй тусламжаар барьж буй. Төмөр зам ба Нарны зам дээгүүр тавьж буй гүүрэн гарцын гол зам наадмаас өмнө ашиглалтад орох юм. Нийтдээ 895 м урт байгууламж бүхий уг гүүрэн гарцын ажлын явц өнөөдрийн байдлаар 80 хувьтай байгаа бөгөөд энэ оны аравдугаар сард бүрэн ашиглалтад орох юм.


Яармагийн гүүрнээс Нисэхийн товчоо, Сонсголонгийн уулзвараас Яармагийн товчоо хүртлэх 13.7 км автозамын ажил эхэллээ. Нэг сая гаруй хүн амтай нийслэл Улаанбаатар хотын автозамын сүлжээг нэмэгдүүлэх, хүчин чадлыг нь сайжруулахаар Яармагийн гүүрээс Нисэхийн товчоо хүрэх замд хийж буй зам барилгын ажил эрчимжсэн байна. Тус хоёр урсгалтай, зургаан эгнээтэй, 28-46 м өргөн далантай уг зам ирэх оны аравдугаар сард ашиглалтад орно. Замын ажлыг “Шинжаан Лу Тун”, “Эйч Кей Би интернэшнл холдинг” компаниуд гүйцэтгэх аж.

ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ энэ оны нэгдүгээр улирлын байдлаар 10.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 11 хувиар өсчээ. Гадаад өрийн 26 хувь буюу 2.8 тэрбум ам.доллар нь Засгийн газрын, үлдсэн 74 хувь буюу 8.1 тэрбум ам.доллар нь хувийн хэвшлийн салбарт хамааралтай аж. Өрийн өсөлтийн голлох шалтгааныг авч үзвэл, Засгийн газрын гадаад өр нь Хөгжлийн банкны бондын арилжаанаас үүдэлтэй бол хувийн хэвшлийнх нь уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулагчаас татсан зээлийн эх үүсвэрийн санхүүжилттэй шууд холбоотой хэмээн тайлбарлалаа.

ГАДААД ХУДАЛДАА

Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар манай улсын гадаад худалдааны эргэлтийг мөнгөн дүнгээр



тооцоход гурван тэрбум 373.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 23 хувиар буюу 626.2 сая ам.доллараар өсчээ. Үүнд графикт үзүүлсэн экспорт, импортын хэмжээ нөлөөлжээ. Жилийн өсөлтийн хурд нь өнгөрсөн оны мөн үеэс 54 нэгж хувиар буурчээ. Энэ оны эхний дөрвөн сарын импортын жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеэс гурав дахин, экспортын жилийн өсөлт 5.3 дахин буурсан нь худалдааны эргэлтийн жилийн өсөлт саарахад нөлөөлсөн байна. Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 49 хувь буюу 1.6 тэрбум ам.долларын худалдааг БНХАУ-тай, 18.9 хувиар буюу 637.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ.

ТЕХНОЛОГИ

Солонгосын Засгийн газрын буцалтгүй тусламжаар КОЙКА олон улсын байгууллага, Сангийн яамтай хамтарч цахим худалдааны үйлчилгээг манайд нэвтрүүлж эхэллээ. КОЙКА манайд тохируулан “Koneps” цахим худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсруулсан аж. Тус тогтолцоог

ашигласнаар тендерийн урилгыг зарлахаас эхлээд шалгаруулалт, үр дүнг нь нийтэд зарлах хүртэл бүхий л үйл ажиллагааг онлайн хэлбэрээр нээлттэй явуулах аж. Ингэхдээ тендерт оролцох компаниуд, тендерийн бүх бичиг баримтыг тус сайтаас үнэ төлбөргүй татаж авч, төрийн байгууллагууд, арилжааны банкууд, шүүхээс ямар нэгэн тодорхойлолт авах шаардлагагүй болох аж. Ирэх жил гэхэд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдаж авах нийт үйл ажиллагааныхаа 30 хувийг цахим хэлбэрээр явуулахаар төлөвлөж буй. 2014 он гэхэд дээрх худалдан авалтыг 100 хувьд хүргэх зорилт тавьжээ.

Өндөр хөгжилтэй орнууд гадаад худалдаагаа явуулахдаа гааль болон бусад холбогдох газруудаас нийт 2-3 төрлийн бичиг баримт цуглуулж, 3-4 хүнээр гарын үсэг зуруулдаг байхад 8-10 төрлийн бичиг баримт, 20-28 гарын үсэг цуглуулж байх жишээтэй. Гадаад худалдаагаа хөнгөвчлөх зорилгоор Засгийн газраас “Цахим нэг цонх” мастер төлөвлөгөөг баталж, бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэллээ. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Ази дахь интеграчлал хөтөлбөр хамтран таван сая еврогийн хөрөнгө гаргаж, ирэх гурван жилд хөл дээр нь босгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэхээр зорьж буй аж.

ХУУЛЬ


Манай улс мэдлэгт суурилсан эдийн засгийг түлхүү хөгжүүлж, шинэ санаачлага, шинэ бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлага тулгарч буй тухай хүмүүс ярьдаг. Тэгвэл үүнийг хэрэгжүүлэх гол хууль болох Инновацийн тухай хууль таван жил дуншсаны эцэст өнгөрсөн сарын 22-нд батлагдан гарлаа. Тус хууль нь эдийн засгийн төрөлжилт, экспортод чиглэсэн үйлдвэрлэл явуулдаг техник, технологи, инновацийн компаниудыг олноор бий болгох хууль эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж өгөх онцлоготой аж. Түүнчлэн инновацийн удирдлагын тогтолцоо буюу хаанаа хэн нь юу юу хариуцах, Шинжлэх ухааны парк байгуулж дэд бүтцийг хөгжүүлэх, инновацийн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүгээр дэмжих сангийн тогтолцоог ч шийдэж өгчээ.

ХЯТАД

Азийн хоёр том эдийн засаг болох Хятад, Япон улс иен, юанын шууд худалдаа хийхээр болжээ. Улмаар улс хоорондын гадаад худалдаг ам.доллараар тооцохгүй болж байгааг CNN агентлэг мэдээллээ. Арлын улсын хувьд урд хөрш эдийн засгийн хамгийн том түнш бөгөөд ирэх сард дотоодын валют худалдааны системийг ашиглан гадаад худалдааны шинэ бодлогыг хэрэгжүүлэх болсноо Хятадын Төвбанк онцолсон. Credit Agricole CIB хөрөнгө оруулалтын банкны ажилтан Дариус Ковалцик хэлэхдээ “Энэхүү алхам нь Хятад улс долларааас хараат бус болох гэсэн стратегийн зөвхөн нэг хэсэг нь” гэв. Түүний үзэж буйгаар урд хөрш иенээр гадаад худалдаа явуулах болсон нь тус улсын Японтой хийх гадаад худалдааны цар хүрээг өргөжүүлэх, мөн худалдааг бусад орны валютаар хийх боломжийг бүрдүүлж байгаа аж.

Хятадын Төвбанкнаас гаргасан мэдэгдэлд дээрх хэлэлцээр хэрэгжих нь валютын зөрүүг багасган, хоёр талын худалдаа болон хөрөнгө оруулалтын үйл явцыг хялбаршуулна гэж тэмдэглэсэн байна.

Японы улсын Сангийн сайд Жун Азуми сэтгүүлчдэд хандахдаа “Гуравдагч орны валютыг үл харгалзан худалдаа явуулах нь шилжүүлгийн зардал болон эрсдлийг бууруулах ач холбогдолтой” гэсэн бөгөөд энэ сарын 1-ний өдрөөс хоёр улсын гадаад худалдааг шинэ бодлогоор зохицуулах болсон тухай Ройтерс агентлаг мэдээлсэн.





СЭТГЭЛГЭЭНИЙ ЯДУУРАЛ БА СОНГУУЛЬ

Д.БЭХБАЯР

Монгол Улсад ядуурал буурсан уу? Энэ асуултад буурсан, буураагүй гээд л баахан маргадаг байсан. Гэтэл Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкны хамтарсан судалгаагаар манай улсын ядуурлын түвшин 29,8 хувь болж буурсан тухай "хачирхалтай" мэдээг өнгөрсөн дөрөвдүгээр сарын эхэнд дуулгаж, олон нийтийг гайхшруулсан.

Хэдийгээр Хүний хөгжлийн мөнгө авч байгаа ч ажилгүй, орлогогүй иргэдийн тоо хумигдаагүй байгаа болохоор олон нийтэд дээрх ядуурал огцом буурсан мэдээ үнэмшил муутай байгаа хэрэг. Үнэндээ манай улс ядуурлын судалгааг үнэн зөв гаргаж чадахгүй өнөөг хүрсэн нь өрөвдөлтэй асуудал. Ядуурал гэж юуг хэлдэг талаар нэгдсэн ойлголт өгч, ядуурлын судалгааг үнэн зөв хийж байж асуудалтай эрс шийдэмгий, бодитой тэмцэж чадах тухай энэ жилийн Монголын эдийн засгийн чуулганы үеэр багагүй ярьсан. Үр дүнд нь энэ чиглэлээр судлах ажлын захиалгыг нэгэн судалгааны хүрээлэн авсан тухай сонсогдсон. Бодитой л судалгаа хийгээсэй билээ.

Ер нь Монголд олон янзын ядуурал цэцэглэн хөгжиж байна. Боловсролын, эрүүл мэндийн, сэтгэлгээний, эрчим хүчний, халамжийн гэх мэт. Эдгээрээс сэтгэлгээний ядуурал манайд газар авчээ. Ийм төрлийн ядуурал цаашид хурдацтай хөгжвөл улс орон сүйрэн мөхдөг тухай түүхийн олон том сургамж бий. Бид эдийн засгийн бодитой өсөлт хөгжлийн өөд бус, эдийн засгийн сэтгэлгээний ядуурал руу хурдтай өнхөрч буй талаар эрдэмтэн судлаачид олонтаа хэлж ярьсаар байгааг бид мэднэ.

Саяхан Шведийн хэдэн судлаач манайд

судалгаа хийгээд буцжээ. Тэдний судалгаа манай ихэнх залуучууд шударга зан, үндэсний соёл, ажил хөдөлмөрийн талаар нэгдсэн ойлголтгүй, харин том дарга таньдаг эсэх, ганган хувцас, унасан машинаараа өрсөлдсөн байдалтай, харин үзэл бодлоороо хуваагдсан нь цөөхөн байна гэсэн дүр зургийг харуулжээ. Энэ бол өөр хоорондоо хэрэглээгээрээ л ялгараад байгаа болохоос биш хүн чанараараа ялгарч чадахгүй байгаагийн илрэл юм гэж УИХ-ын гишүүн Д.Энхбат ярьсан юм.

Мөн тус судалгаанд манай залуусын хувьд секс нь хайр дурлал, харилцаа огт биш, зүгээр л хэрэглээ болсон гэжээ. Ийм сэтгэлгээг дагаад улс төрийн намууд ч үзэл бодлоороо бус хэрэглээгээрээ л сэтгэж, хуваагдаж байна. Аль намыг дагавал дарга болох боломжтой бол гэж л бодохоос өөрийн, хувь хүний ертөнцийг үзэх үзэл баримтлал, ойлголт байхгүй болсон байна гэнэ. Үүнийг Шведийн судлаачид “Энэ бол танай улсын сүйрэл” гэж дүгнэжээ.

Сэтгэлгээний ядуурал бол хамгийн аюултай, хортой аж. Цунами шиг хоромхон зуур алив зүйлийг хамаад аваад явахгүй ч аажмаар сэтгэхүйд нөлөөлөн утсгадаг “бодис” аж.

Яагаад сэтгэлгээний ядуурал руу хурдтай яваад байна вэ?

Уг нь төр, засгийн бодлогыг тодорхойлогчид ард иргэдээ ямар ч төрлийн байсан ядуурлаас гаргахын төлөө толгой тархиа гашилгах учиртай. Харин манай төрийн эрхийг баригчид иргэдээ сэтгэлгээний ядуурлаас аврахын төлөө бус харин ч улам л гүнзгий оруулахын төлөө ажиллаад байна уу гэлтэй. Өөрсдөө ч улсын мөнгийг завших, төрийн суудалд сууж, эрх ямба эдлэхийн төлөөх сэтгэлгээний ядууралд автчихсан хүмүүс. Яавал ард түмнийг хууран мэхлэх үү, яавал тэднийг аргандаа оруулах уу, иргэдийн хүсэл сонирхол дээр хэрхэн тогловол гарт ороод ирэх үү. Ийм л юм бодож, суудалдаа үлдэхийн төлөө юу ч хийхээс буцахгүй яваа хүмүүс бол өнөөдрийн төрийн бодлого тодорхойлогчид буюу улстөрчид шүү дээ. Харамсалтай нь тэд бүгд УИХ-ын сонгуульд нэр дэвшжээ.

Бид УИХ-ын сонгуульд хариуцлагатай хандах цаг болсон. Улс орны хөгжлийг ирэх дөрвөн жилд тодорхойлох, төрийн эрх барих дээд байгууллага. Монголчууд 2012 оныг тэсвэртэйгээр хүлээсэн. Хүлээсэн цаг хугацаа дэргэд ирлээ. Ахиж алдахгүйн төлөө сонголтоо зөв хийнэ гэж хүлээсэн мөч 20 гаруйхан хоногийн дараа тохиох нь. Эх орноо гэсэн сэтгэлээр хандаж, зүг чигийг зөв залаад явчих, ард иргэдээ сэтгэлгээний ядуурлаас аврах, өөрсдөө ч зөв сэтгэлгээтэй байх тийм нам, улс төрийн хүчин гарч ирэх болов уу.

Намуудын УИХ-ын сонгуульд сойсон нэр дэвшигчдийг харвал дээрх итгэл найдвар талаар болох нь харагдаж байх шиг. Аргагүйн эрхэнд хийсэн шинэчлэл гэвэл эмэгтэйчүүдэд тодорхой хэмжээнд боломж олгосон явдал. Өөр шинэчлэлийн салхи сэвэлзсэн зүйл алга аа.

Хүмүүсийн эрүүл энхийн төлөө яваа нэг эмч надад ингэж ярьсан юм. “УИХ, Засгийн газар дотор миний олон найз бий. Тэдэнтэй уулзаад та нар яагаад ард түмнийхээ төлөө ажиллахгүй байна вэ гэж асуухаар үнэндээ улстөрчид дотор тэдний төлөө, эх орныхоо төлөө үнэн сэтгэлээр ажиллах хүн ховор гэж хариулсан. Тэгэхээр эд нар чинь иргэд нь өвчинд улам л нэрвэгдэж, боловсрол мэдлэггүй, сэтгэлгээ нь ядуураасай л гэж хүсдэг юм билээ. Тийм тохиолдолд л суудлаа хамгаалж үлдэнэ гэж боддог бололтой. Өнөөдөр дундаж давхаргаас доош түвшний хүмүүс л эмнэлэгт хандаж байна. Түүнээс дунджаас дээш давхаргынхан найтаалгах, тархиар нь хатгах төдийд л гадагшаа явдаг. Тэдэнд зовлон жаргал яриад ойлгодоггүй, ойлгохыг ч хүсдэггүй юм” гэж ярьсан. Ийм яриаг зүрх сэтгэлээсээ сонирхуулсан тэр эмчийг Монголын цагаан халаатнуудын төлөөлөл гэж ойлгож болно. Нэр, албан тушаалыг нь бичихийг их хүссэн ч маргааш хөөрхий эмч ажлаас халагдана шүү дээ. Манай улстөрчдийн үнэн нүүр царай ийм л байгаа юм.

Том намуудын төлөөлөл энэ удаагийн сонгуульд залуучуудаа дэмжихийг хичээсэн гэж тайлбарлаж байна. Яг үнэндээ гадаад, дотоодод төгссөн боловсрол мэдлэгтэй, туршлагатайг нь сонгож нэр дэвшүүлсэн нь ховор байна. Ихэнхдээ л мэдлэг боловсрол нимгэн мөртлөө бэл бэнчинтэй, албан тушаалын төлөө нүдээ ч өгөхөөс буцахааргүй залуусын эгнээ УИХ-ын суудал горилогсдын жагсаалтыг зузаатгажээ. УИХ-д суувал зохистой хүмүүс харин хөрөнгө мөнгөгүйн улмаас жагсаалтын гадна үлджээ. Нөгөө талаар цус шингэн залуус хууль тодорхойлохоос илүүтэй эхлээд амьдралд нухлагдаж бодитой, үр дүнтэй ажил хийж, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах нь дээр баймаар. Галзуу барын аманд гараа хийхээс ч буцахгүй насан дээрээ тэд Саарал ордонд залрахаар эрч хүч нь суларч, бусдад уруу татагдаж, улмаар нөгөө л хуучны 76 мангуугийн нэг болж хувирах нь ойлгомжтой бус уу.

Хэтэвчний нимгэн, зузаанаас гадна нийгмийн нэр хүндийг нь ашиглах зорилго бүхий сонголтууд бас хийжээ. Өөрийн намын суудлыг л баталгаатай нэгээр нэмж байвал бусад нь хамаагүй гэсэн байдлаар, нөгөө талаар өөрсдөд нь дуулгасан уу үгүй юу гэж эргэлзэхээр нэр дэвшигчид ч харагдана. Энэ бол урлаг соёлын, спортын хүмүүс л дээ, хөөрхийс. Урлагаар ард иргэдийг ухааруулж, спортоор хөгжөөн дэмжиж явах хүмүүс улс төрийн тогоон дотор орж ирээд юу хийх юм бол. Ингэж зовж олсон нэр хүндээ улстөрийн бохир шийдвэрээр солих хэрэг юунд байсан юм бол. Мөнгө үү, албан тушаал уу.

Дараа нь сэтгүүлчид. Үзэг нэгт нөхөд маань 76 суудлын төлөөх тулаанд орохоор шийджээ. Уг нь сэтгүүлчид Төрийн ордны гадна талаас үзгээ хурцлаад, үгээр алдаа оноог нь хэлж, дөрөв дэх засаглалын үүргээ гүйцэтгээд явбал илүү чухал юм шиг санагдах. Харин нэг бус сэтгүүлч Саарал ордны дотроос нь өнгийхийг илүүд үзсэн нь бас л ямар сонирхол нь дийлсэн гэж үзэх вэ.

Одоогийн УИХ-аас ч дор шинэ Парламент бүрэлдэнэ гэж УИХ-ын гишүүн Лу.Гантөмөр телевизээр ярихыг сонслоо. Жагсаалтыг харвал нээрээ л эрээвэр хураавар бүхий намуудын төлөөлөл болсон 76 бүрэлдэх магадлалтай байж болзошгүй нь. Нам гэхээсээ илүүтэй тухайн хүнд чиглэсэн сонголт хийх яриа олны дунд байна. Иргэдэд сонголт бий. Сонголт хийх тэр л торгон агшинд ард түмэн сэтгэлгээний ядууралд бүү автаасай. ■



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ АЯСЫН САЛХИ ҮЛЭЭВ ҮҮ

И.ОТГОНЖАРГАЛ

Булган аймгийн Баяннуурын Улаан хэрэм гэх газар Төв Азид өмнө нь олдож байгаагүй маш ховор олдвор олдсон тухай өнгөрсөн хавар монголчууд шуугисан. Шуугиад зогсоогүй 35 метр урттай өнгөт зурагтай хана гарсан тул хэрхэн хадгалах талаар Соёлын өвийн төвийнхөн БСШУ-ы сайдтай аминчлан ярилцсан удаатай. Түүнчлэн уг олдворын бунханг манай судлаачид Түрэгийн үеийн уйгур ноёны булш гэж таамаглаж хүртэл амжсан. Энэ гэхдээ Монголын өргөн уудам нутгаас олдож байгаа эхний бөгөөд эцсийн олдвор биш юм. Эрт дээр үеэс манай газар нутгаас энэ мэтийн ховор олдвор олддог байсан цаашид ч олдсоор байх болно гэдэгт монголчууд итгэлтэй байдаг. Харин сүүлийн үед олдож буй олдворууд урьд өмнө нь байгаагүй шинэ содон байгаа нь Монголын газрын хэвлий алт, зэс, жонш, хүдэр зэрэг 80 төрлийн байгалийн баялаг агуулахаас гадна түүх шастир өгүүлэх үлэмж баян эд өлгийн зүйлс хэмжээлшгүй ихээр нуусан гэдэг нь харагдаж байна.

Нөгөө талаас энэ нь Монгол эх орон минь зөвхөн уул уурхай гэж хөөрцөглөж, газар шороогоо битгий сэндийчээч ээ, “утаагүй үйлдвэрлэл” болох аялал жуулчлалын салбартаа ашигт малтмалаас дутахгүй анхаарал хандуулж, хөгжүүлэх аваас Монгол Улсад өөдрөг ирээдүй байгаа шүү гэдгийг илэрхийлж байна гэж үзэж болох юм.

“Mongolian Economy” сэтгүүл одоогоос яг нэг жилийн өмнө шинэхэн гарсан сэтгүүлийнхээ тав дахь дугаарыг аялал жуулчлалын хөгжилд хандуулж, тус салбарын асуудлыг олон талаас нь хөндөж байсан бол өнөөдөр хорь дахь дугаарынхаа голлох нийтлэл, сурвалжлагыг мөн энэ чиглэлээр бичиж, онцлон хүргэж байна. Манай түрүү жилийн энэ сэдвээр гаргаж байсан “Монголын элсэнд зөвхөн ашигт малтмал бий гэж үү” гэсэн ерөнхий гарчигтай дугаарыг маань өдгөө аялал жуулчлалын салбарын зарим компанийн захирал, мэргэжилтнүүд ширээний номоо мэт нандигнан хадгалж, байн байн



эргүүлж үзэж байгаатай тааралд бид хувьдаа баяртай байдаг. Энэ удаа ч гэсэн манайх “утаагүй үйлдвэрлэл”-д олон ургальч үзлээр хандахдаа өмнө нь сэтгүүлдээ бичиж байсан өргөн дэлгэр мэдээллээ аль болох давтахгүй, шинэлэг байдлаар хүргэхийг хичээнгүйллээ.

Аялал жуулчлалын салбарт сүүлийн нэг хоёрхон жилийн дотор том ахиц дэвшил гарсан нь анзаарагдаж байна. Нэг үгээр хэлбэл, аялал жуулчлалыг төрийн бодлогоор дэмжээд, түлхээд өгөх юм бол уул уурхайтай өрсөлдөх чадавхтай гэдгээ харуулж байна уу гэлтэй. Үүнийг гэрчлэх баримт материалыг уншигч Та манай сэтгүүлчдийн бэлтгэсэн нэг бус нийтлэл материалаас тодорхой харах болно. Тухайлбал, “Шинэ нар мандлаа” гарчигтай нийтлэлээс дотоод, гадаадын жуулчдын аялж зугаалах оргилсон сэтгэл рүү цөөнгүй жил ус цацаж ирсэн агаарын тээвэрт ганцхан жилийн дотор шинэ нар мандсаныг харж болно.


Монголын аялал жуулчлалын холбооны тэргүүн Н.Эрдэнэбатын хэлснээр ганцхан жилийн дотор иргэний агаарын тээвэрт даруй 1000 суудал нэмэгдэж, нислэгийн давтамж өсөж, үнэ буурах боломж нөхцөл бүрджээ. Түүнчлэн “Нью жуулчин” компанийн захирал Ш.Нэргүй зөвхөн гадаадын жуулчдаас гадна монголчууд маань аялж сурч байна. Энэ үнэхээр том соёл гэдгийг онцоллоо. Мөн БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газрын дарга Ц.Оргодол манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа Монгол Улс дэлхийн түүхийг бүтээлцсэн үндэстний хувьд аялал жуулчлалын салбарын өнөөгийн хөгжилд шинэ өнгө, шинэлэг санаачилгыг бий болгомоор байна гэдгийг учирласан. Тэрбээр энэ салбарыг уул уурхайтай эн зэрэгцүүлж хөгжүүлье гэвэл төрөөс томоохон хөрөнгө оруулалт хийх шаардлагатайг хэлсэн.

Түүнчлэн сүүлийн үед олдож байгаа болон өнгөрсөн хугацаанд олоод, буцаагаад газарт булж хадгалж буй түүхийн үнэт олдворуудаа эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлагатайг ч тэрбээр дурдсан. Мөн Монгол орныг аялал жуулчлалыг хөгжүүлэх зургаан бүс болгож хуваж буй хөгжлийн бодлого сайн үр дүн авчирна гэдэгт Оргодол дарга илтгэлтэй байна.

Сайны хажуугаар саар зүйл бас бий. Ялангуяа уул уурхайн салбар байгальд ээлтэй бизнесийг хүний нөөцийн хувьд тун хүнд байдалд оруулж, бараг дампуурууллах хэмжээнд хүргээд байгаа нь харамсалтай. Аялал жуулчлалын салбарын чадварлаг хөтөч-орчуулагч, гадаад хэл сайтай, сэргэлэн цовоо менежерүүдийг нь уул уурхайн салбар өндөр цалингаар урвуулж аваад бараг дууслаа. Энд гэхдээ дан ганц уул уурхайн буруу байхгүй. Аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургуулиуд чанаргүй, гадаад хэлний мэдлэггүй оюутнууд олноор гаргаж байгаатай холбоотой юм. Түүнчлэн Монголд өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй учраас аялал жуулчлалын компаниудын хувьд зун ажиллуулсан чадварлаг орчуулагч -хөтөч нараа өвөл бусдад алдах нь элбэг. Энэ тухай Та манай сэтгүүлчийн бичсэн “Хөтлөх үү, хөтлүүлэх үү” гэсэн гарчигтай нийтлэлээс илүү дэлгэрэнгүй унших болно.

Улс даяараа сонгуулийн шоугаар амьсгалж буй энэ үед “Mongolian Economy” сэтгүүл “утаагүй үйлдвэрлэл”-ийг уул уурхайтай өрсөлдүүлэн хөгжүүлж, байгалийн баялаг шавхагдахын цагт барьцтай хөрөнгөтэй үлдэхийг уриаллаа. Ингэсэн цагт монголчууд үзэмж төгс байгальтайгаа үлдэж, жинхэнэ утгаар баяжиж чадах билээ.

Монголд ирсэн жуулчдын тоо



Эх сурвалж: БОАЖЯ

Монгол Улсад ирсэн нийт гадаадын иргэд	2010 он	2011 он	Өөрчлөлт тоогоор	Өөрчлөлт хувиар
БНХАУ	194.069	198.191	4.122	2.1
ОХУ	121.647	102733	-18.914	-15.5
БНСУ	42.231	43994	1.763	4.1
Япон	14140	14988	848	5.9
АНУ	12.808	15423	2.615	20.4
Герман	8.095	8545	450	5.5
Франц	7.527	7570	43	0.5
Их Британы	6209	7120	911	14.6
Казахстан	5757	7913	2.156	37.4
Австрали	5453	7093	1.640	30.0

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

ТҮҮХ САЙТАЙН ХУВЬД ӨНӨӨДРИЙНХӨӨС АРАЙ Л ӨӨР БАЙХ ЁСТОЙ

Монголын аялал жуулчлалын салбарт жилд ойролцоогоор 5-10 хувийн өсөлт гардаг. Зөвхөн тооны араас хөөцөлдөөд, сурталчилгаа сайн хийгээд сая жуулчин олох боломж бол бидэнд байгаа. Гэвч манайд тийм хэмжээний жуулчин хүлээж авах хүчин чадал байхгүй.

Б.САНЖААХАНД

Аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжиж буй уул уурхайн салбартай хэрхэн эн зэрэгцүүлж авч явах вэ гэдэг асуудал Монгол Улсын хувьд чухлаар тавигдаж буй юм. Тиймээс аялал жуулчлалын улирал айлчилж буйтай холбоотойгоор тус салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газрын дарга Ц.Оргодолтой ярилцлаа.

-“Утаагүй үйлдвэрлэл”-ийг уул уурхайтай өрсөлдөхүйцээр хөгжүүлэхэд төр, засгийн зүгээс юунд анхаарах шаардлагатай вэ?

-Аялал жуулчлалын бүтээгдэхүүн шинээр бий болгоход хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Монгол орон дэндүү том газар нутагтай учраас тэр бүрт хүрч ажиллаж, үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй тал байдаг. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийн тулд төрөөс бодлоготойгоор хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Энэ салбарыг зуун хувь хувийн хэвшлийнхэн нуруун дээрээ авч явдаг. Аялал жуулчлалын хувийн компаниуд дотор цогцолбор байгуулах хэмжээний хөрөнгө оруулалт хийх чадалтай компани бараг байхгүй. Тэд жуулчны бааз, зочид буудал гэх мэтийн жижигхэн зүйлд хэр чадлаараа хөрөнгө оруулаад л явж байна. Олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулна гэдэг том хөрөнгө оруулалт шаардана.

-Онгон байгаль, нүүдэлчин соёл иргэншил гэх улиг болсон нэр томьёоллоор бид жуулчдыг татах гэж мэрийх нь амжилтавчрахааргүй болжээ. Улаанбаатарт ирсэн жуулчин хотоос гармагц л энэ бүхнийг үзчихэж болохоор байгаа. Тэгвэл хөгжлийн ямар шинэ гарц байж болох вэ?

-Монгол Улс дэлхийн түүхийг бүтээсэн үндэстэн шүү дээ. Монгол, Энэтхэг, Эртний Грек, Ром, Хятад гээд дэлхийн түүхийг бүтээлцсэн цөөхөн орон бий. Гэтэл өнөөдөр бид жуулчдад тэрхүү арвин баялаг түүхээ ярьж, холбогдох үзмэрүүдийг үзүүлье гэхээр юу ч үгүй сууна. Тийм болохоор аялал жуулчлалыг Монголын түүхэнд тулгуурлаж л хөгжүүлэх ёстой. Нэг үгээр, түүхэнд байсан зүйлээ шинээр сэргээн байгуулах нь чухал.

-Хархориныгаялалжуулчлалын цогцолбор болгон хөгжүүлэх талаар ярьж байсан. Энэ ажил ямар шатандаа яваа вэ?

-Төслийн эхний шатны шинжилгээний ажлууд явагдаж байна. Өнөөдөр XIII зууны үед Хархорин хот ямар байсныг хэлж мэдэх хүнгүй учраас түүх номыг нь уншиж судлаад аль болох тухайн үеийнхтэй нь ойролцоо аятайхан цогцолбор босгох хэрэгтэй. Ажлын явцын хувьд өнөөдөр хүн бүр л нэг нэг юм ярьж байгаа. Шийдсэн зүйл байхгүй байна. Хүмүүс ийм байвал ямар вэ, тийм байвал ямар вэ гээд оюун бодлоо уралдуулж байгаа учраас тэр дундаас л нэг шийдэл олно. Ерөнхийдөө цогцолборын барилгын хийц загварын хувьд фантаазаар босно л доо. Эрдэнэ зуугийн хийд гэхэд л XVI зуунд байгуулагдсан. Мөн л сэргээн засварлах шаардлагатай байгаа.

-Одоо манайханд жуулчдад морь, тэмээ унуулах, ардын урлагийн ганц нэг тоглолтоос өөр сонирхуулах зүйл ховор байна шүү дээ.

-Хархоринд бол түүхийн олдвор зөндөө бий. Шинжлэх ухааны салбарынхан олж илрүүлчихээд, буцаагаад булчихдаг. Орхоны хөндийд эрт үеэс олон үндэстэн амьдарч байсан. Зөвхөн монголчууд ч биш. Тийм учраас төрөл бүрийн олдвор олддог. Дахин хэлэхэд, энэ бүхэнд л тулгуурлаж жуулчдыг татах зүйлийг хийх ёстой л доо. Хэрвээ бид Хархорин цогцолборыг байгуулчихвал тэр хавьд буй үнэт олдвор, үзмэрүүдээ бүгдийг нь дэлгэн тавьж, эдийн засгийн ››



Фотог Э.Зоригт

эргэлтэд оруулна. Манайд Түрэгийн хааны хөшөө хүртэл байгаа. Мөн Булган аймгийн Баяннууранс саяхан бас нэг олдвор олдлоо. Цаашлаад Орхоны Хүрхрээ, Найман нуур зэрэг байгалийн үзэмжит газрууд үргэлжлэх жишээтэй.

Ер нь төрөөс авч хэрэгжүүлэх бодлогын хүрээнд аялал жуулчлалыг зургаан бүс болгож хуваасан. Баруун, Хөвсгөлийн, Хархорин төвтэй төвийн, Хэнтий, Дорнод, Сүхбаатар буюу зүүн, говийн, Улаанбаатарын орчмын бүс гэж авч үзсэн. Монголын говь гайхамшигтай. Тэндээс зөвхөн нүүрс, алт ухаад зогсохгүй. Хөвсгөл гэхэд манай хувьд далайн эрэг л гэсэн үг. Гэтэл тэнд хаягаа модоор хашиж тусгаарласан, хог новшоо нэгдсэн журмаар хаядаггүй, мотор асаачихсан, ямар ч эмх цэгц замбараа байхгүй 40-өөд жуулчны бааз байх жишээтэй. Үүнийг цэгцэлж, гадаад оронд далайн эргийг аялал жуулчлалын бүс болгож яаж хөгжүүлсэн байдаг билээ яг тийм болгож хөгжүүлэх ёстой. Говийг яаж л бол яаж хөгжүүлж болж байна. Гэхдээ динозаврын яс, палеонтологийн музей, судалгааны төв чиглэлд нь түлхүү тулгуурлаж хөгжүүлэх нь зөв болов уу.

Баруун аймаг Монголын олон ястан үндэстний нутаг, өөр өөрийн соёлтой. Зүүн бүс эзэн Чингисийн төрсөн нутаг гэдгээрээ алдартай.

Жуулчдад сонирхуулдаг ардын урлагийн тухай би тусгайд нь ярина.

-Бүсчлэлийн дагуу хэзээнээс хөгжүүлж эхлэх вэ?

-Мэдээж маш их хөрөнгө гарна. Засмал зам, онгоцны буудал байх хэрэгтэй болно. Халуун, хүйтэн устай 24 цагаар ажилладаг зочид буудал, интернэт, холбоо харилцаа, баар ресторан, театр урлаг, хурлын зориулалттай саруулхан танхим хүртэл байх шаардлагатай. Сүүлийн үед олон улсын томоохон хурал их болж байна. Жишээ нь, Уур амьсгалын өөрчлөлтийн хурал хагас сар үргэлжиллээ. Ийм том хурлыг тэнд хийж яагаад болохгүй гэж.

-Аялал жуулчлалын салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилсан байдлаар гаргасан байдаг бол сонирхуулахгүй юу?

-Хархорины цогцолборт урьдчилсан байдлаар хагас тэрбум ам.долларын санхүүжилт шаардлагатай. Одоо чинь Монгол Улс уул уурхайгаас их мөнгө олж байгаа болохоор нэг тэрбум ам.долларт манайхан цочирдохоо больсон байна.

-Таны ярьж буй аялал жуулчлалыг бүсчилж хөгжүүлэх асуудал төрийн бодлогод хэрхэн туссан байгаа вэ?

-Ямар ч байсан Засгийн газрын заавал хэрэгжүүлэх ётой төслүүдийн тоонд орчихсон. Бид удахгүй Засгийн газраар Үндэсний хөтөлбөрөө батлуулна. Үндэсний хөтөлбөрт миний ярьсан зургаан бүсийн асуудал гол нь байгаа юм. Яаж хийх вэ, хөрөнгө яаж босгох вэ гэх мэт.

-Тэгээд яаж хөрөнгө босгоё гэж бодож байна вэ?

-Концессын хуулиар гадна, дотнын хүмүүсийг татаж болох юм гэсэн санаа байна. Хамгийн гол нь эхлээд бид төслөө хийчих хэрэгтэй. Хүнд үзүүлэх юмтай байхад учиртай шүү дээ.

-2004 оноос санагдаж байна Мянганы хөгжлийн зорилтод суурилсан "Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д Монголд ирэх жуулчдын тоог 2015 он гэхэд нэг саяд хүргэнэ гэсэн том зорилт дэвшүүлж байсан. Гэтэл өнгөрсөн жилийн байдлаар 457,5 мянган жуулчин авчээ. Одоогоос бараг арваад жилийн өмнө дэвшүүлсэн зорилт яагаад хэрэгжихгүй байна вэ?

-Монголын аялал жуулчлалын салбарт жилд ойролцоогоор 5-10 хувийн өсөлт гардаг. Зөвхөн тооны араас хөөцөлдөөд, сурталчилгаа



сайн хийгээд, сая жуулчин олох боломж бол бидэнд байгаа. Гэвч манайд тийм хэмжээний жуулчин хүлээж авах хүчин чадал байхгүй байна шүү дээ. Удахгүй болох Улсын баяраар л гэхэд Улаанбаатар хотын бүх зочид буудал пиг дүүрчих жишээтэй. За тэгээд онгоц хэд нисдэг билээ гэх мэтчлэн дотоодын дэд бүтцийн хүчин чадлаас хамаараад тооны араас эрчимтэй хөөцөлдөхгүй байгаа л даа.

-Жуулчдын статистикийг харахад, Монгол Улсад хөл тавьсан бүх гадаад иргэний тоог оруулж тооцож гаргасан байх юм. Манайд сүүлийн жилүүдэд ашигт малтмалын орд-уудын бүтээн байгуулалт, зам гүүрийн ажил гээд гадаадаас ажиллах хүч их хэмжээгээр авч байгаа. Тэд нарыг бас жуулчдын тоонд оруулж тооцдог гэсэн үг үү. Энэ нь ямар учиртай вэ?

-Зам барилгын ажилчдын виз цаанаасаа жуулчны ангиллаар олгогдсон бол тооцогдоод л явна. Нөгөө талаас Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан категориор “Гэр орноосоо гурваас дээш хоногоор явж байгаа бол жуулчин гэнэ” гэсэн тодорхойлолтыг дэлхий даяараа мөрддөг. Манайх энэ л зарчмаар явж байгаа.

-Би жишээ нь албан ажлаар гадаадад гурав хоногийн хугацаатай явбал жуулчиндтооцогдоно гэсэн үг үү?

-Тэгнэ. Байнга оршин суух, сургуульд сурах зэрэг жуулчинд тооцохгүйг нь дээрх журмаар тодорхой заасан. Түүнээс биш, ирж байгаа гадаад хүн бүрийг чи жуулчин мөн үү, биш үү гэж хэн ч байцаахгүй шүү дээ. Манайхан жуулчин гэхээр зөвхөн гадаад хүн гээд ойлгочих юм. Чи ч эх орондоо жуулчны тоонд орж болно. Жишээ нь, чи Өмнөговь юм уу, Хархоринд очоод байгалийн сайхантай танилцаад, юм үзээд явж байвал жуулчин болно.

-Өнгөрсөн оны аялал жуулчлалын салбарын нийт орлогыг өмнөх онтой нь харьцуулахад 0,3 хувиар буурсан дүнтэй гарчээ. Гэтэл Та болохоор жилд 5-10 хувийн өсөлттэй гэж ярьж байна. Яагаад ийм зөрүүтэй мэдээлэл байна вэ?

-Бууралт бол байхгүй л дээ, хүний тоо өснө гэдэг чинь орлого өсөж л байгаа гэсэн үг. Өмнө нь 2004 оны үед Сангийн яамнаас гаргасан эдийн засгийн тооцоогоор ДНБ-ий арав орчим хувийг аялал жуулчлалын салбараас оржээ гэж тооцож байсан. Одоо болохоор уул уурхайн салбараас олох орлого огцом өсөөд ирэхээр аялал жуулчлалын салбарын орлого автоматаар буурчихаж байна. Цаашид ч томоохон уурхайнууд ашиглалтад орохоор манай салбарын орлого улам л уруудах хандлагатай байна. ДНБ-тэй харьцуулахад шүү дээ.

-Утаагүй үйлдвэрлэлийн өсөлтийг уул уурхайн салбар нухчин дарж байгаагийн тод жишээ энэ байна л даа. Ингээд зогсохгүй уул уурхайн салбар аялал жуулчлалыг хүний нөөцийн хомсдолд оруулж байгаа нь нэлээд том асуудал юм. Үүнийг хэрхэн шийдвэрлэх ёстой вэ?

-Энэ бол манай салбарынхны үнэхээр санаа зовоосон, толгой өвтгөсөн асуудал болсон. Аялал жуулчлалын салбар хамаг гайгүй хөтөч оруулагч, менежер, санхүүгийн ажилтнаа уул уурхайн салбарт алдаад, хүний нөөцийн хувьд үнэхээр хүнд байдал орж байна. Үүнийг яах ч аргагүй. Аялал жуулчлалын салбар хөгжөөд уул уурхайн салбарын өгдөг цалинг ажилтнууддаа өгдөг болж байж л зохицуулагдана байх.

-Аялал жуулчлалыг тэргүүлэх салбар болголоо гээд яриад байгаа. Албан ёсоор төрийн бодлогод тэргүүлэх чиглэл болгосон учраас ингэж хөгжүүлж, дэмжинэ гэсэн зүйл төдийлэн дуулдахгүй юм. Та энэ талаар юу хэлэх вэ?

-Төрийн бодлогод тэргүүлэх салбарын нэг болгож хөгжүүлнэ

гэж заасан. Аялал жуулчлал өөрөө байгальд ээлтэй үйлдвэрлэл учраас анхаарал тавьж хөгжүүлэхээс ч аргагүй салбар. “Нүдэнд харагддаггүй” экспорт гэдэг шүү дээ. Зуун хувь хувийн хэвшлийн нуруун дээр явдаг, төрөөс нэг ч төгрөг авдаггүй салбар л даа. Цаашдаа энэ салбарт хөнгөлөлттэй зээл, сайхан төсөл хөтөлбөрүүд байвал түүнд нь Засгийн газраас дэмжлэг үзүүлдэг л байх хэрэгтэй. Жижиг, дунд үйлдвэрлэлийг төрийн бодлогоор дэмжиж байгаа шиг тиймэрхүү байдлаар эдийн засгийн дэмжлэг хэрэгтэй.

-2022 онд дэлхийн аялал жуулчлалын салбар нийт 328 сая ажлын байр бий болгоно. 10 ажлын байрны нэг нь тус салбараас бий болно гэсэн тооцоо гарчээ. Тэгвэл Монголын аялал жуулчлалын салбарын хувьд үүнтэй адил ойрын жилүүдэд өгөх эдийн засгийн үр ашиг юу байх бол гэдэг бодохоор арваад жилийн өмнө дэвшүүлсэн сая жуулчин авах зорилтоо ч биелүүлээгүй яваа тул хэцүү юм даа.

-2015 он болоогүй л байна шүү дээ.

-Тийм л дээ, гэхдээ Та бод л доо. Бараг арваад жил өнгөрчихөөд байхад дэвшүүлсэн зорилт нь хэрэгжээгүй байна. Үлдсэн 2-3 жилд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарна гэж найдахад хэт оройтсон юм биш үү?

-Одоо байдал нэлээд өөр болж байгаа учраас зорилтоо биелүүлэх гэж нэлээд үзнэ л дээ.

-Тэгвэл аль аль талдаа яриад суух биш, хийж хэрэгжүүлж харуулах хэрэгтэй байх л даа. Ялангуяа төр, засгийн зүгээс их л мэрийх хэрэгтэй болох байх.

-Би дээр хэлсэн. Төр аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа хувийн хэвшилд аль болох таатай орчныг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ийм учраас БОАЖЯ шаардлагатай хууль тогтоомж юу байна, юуг нь өөрчилмөөр байна гээд төрийн бодлогыг зохицуулах ётой болохоос биш, хувийн хэвшилд чи үүнийгээ тэг ингэ гээд заах боломжгүй. Хэн сайн менежмент хийсэн, хэн сайн ажиллаж байгаа нь сайн яваа.

-Орон нутгийн Засаг захиргааныхан эрх мэдлээ ашиглаад үзэсгэлэнт газруудын аман дээр өөрийн дураар жуулчны бааз барих асуудал нэлээд түгээмэл байдаг бололтой. Гэтэл олон улсын стандартад үзмэрийн аманд тулгаж үйл ажиллагаа явуулах нь буруу гэж үздэг байна. Үүнд төрийн зохицуулалт хэрэгтэй юу?

-Миний ойлгож байгаагаар бидний боловсруулж байгаа бодлогоор л хийх ёстой. Монгол хүний нэг онцлог юм уу даа. “Манай нутгийн тэр хад мөн гоё шүү гэж” сайрхдаг. Тийм хад дэлхийгээр дүүрэн л байгаа шүү дээ. Тэрийг үзэх гээд л 500 км явах юм гэнэ. Ийм байж болохгүй. Яагаад хэсэг хэсэг болгож бүсчлэв. Энэ чинь утгатай. Говийн хэсэгт үзсэн зүйл хангайд очиход давтагдахгүй. Жишээлбэл, говьд морь, тэмээ үзүүлсэн бол хангайд очиход бас л морь, тэмээ байвал утгагүй. Бүсүүдэд дандаа өөр өөр юм үзвэл жуулчдад сонирхолтой санагдана биз дээ. Одоо манайд нийтлэг байдаг таагүй зүйл бишгүй бий. Ялангуяа ардын урлаг гэдэг зүйлийн нэр хүнд унаж дууслаа. Өмнөговьд яваад очихоор нэг нөхөр морин хуур тэвэрчихсэн ирээд, би дуулъя, мөнгө өг гэнэ. Жуулчны баазууд цаг нөхчөөхийн тулд дуулуулдаг. Хархоринд яваад очихоор бас л морин хууртай хүү сууж байх жишээтэй. Одоо ч тэгээд монгол хүн бүр хөөмийчин болсон юм биш үү. Дуулдаг хуурддаг болгон нь CD гаргаад жуулчдад зарна гээд л. Ерөнхий утгаараа ардын урлагийн нэр хүнд унах хандлагатай байна. Үүнийг жаахан цэгцлэх шаардлагатай байна. Хэн нь мэргэжлийн хүн юм. Энэ хүн дуулж болно гэсэн эрх олгосон ч яах вэ. Тэгэхгүй бол 100 грамм татсан хүн бүр дуулж, хөөмийлөх гээд байна шүү дээ. Зарим жуулчин толгой сэгсрээд л явж байгаа. ■

АСУУДАЛ

ХӨТЛӨХ ҮҮ, ХӨТЛҮҮЛЭХ ҮҮ

Хөтөч бол зөвхөн орчуулагч биш юм. Тиймдээ ч тайлбарлагч гэдэг үг дагадаг биз.

Б.ЭНХЦЭЦЭГ

Хэдхэн жилийн өмнө жуулчдын өмнө хэний ч гар, хөл хүрээгүй онгон дагшин байгальтай, мөн суурин болон нүүдэлчин соёл эн зэрэгцэн эв найртай оршдог талаар ам бардам эх оронч үгсийг урсгадаг байлаа. Гэтэл өнөөдөр уул уурхай цэцэглэж, байгаль ижий энгэрээ сийчүүлж, хотыг чиглэсэн их нүүдэл үргэлжилж, хөдөөгийн ард түмэн соёлжсон болохоор дээрх үгсээр жуулчдад сайрхахаас санаа зовоход хүрч байна. Тухайлбал, захын нэг малчныд жуулчид дагуулан айлчиллаа гэж бодъё. Мундаг ёс жудаг яриад л босго давуулна. Тэгсэн харин банзал өмсөж, нүд, нүүрээ гоодож гангалсан бас болоогүй дээр нь үсээ улаанаар будчихсан эхнэр сууж байх жишээтэй. Хажуугаар нь гар утас дуугарч, зураг “хашгирч”, /радио мооднооос гарсан/ хөргөгч хүнгэнэнэ. Зочлохоосоо өмнө золтой л утас ▸▸



Шог зургийг А.Амарсайхан

цохиж, монгол дээлээ өмс, утсаа далд хий, зурагтаа бүтээ гээд хөтөч нь хэлчихгүй юм даа. Үүнийг тухайн айлтай гэрээ байгуулсан жуулчны баазын менежер зохицуулна. Тэгсэн сүүлийн үед үнэн санаа зовмоор нь морио мотоциклиор сольсон малчид мал хуй хариулах нь хөдөөгийн замд олонтаа таарах боллоо.

Хэдэн жилийн өмнө малаа хариулан яваа малч ухааныг эмээл хазаар, хүчит хүлэгтэй нь тайлбарладаг байсан бол өнөөдөр эгээтэй л "Энэ бол Хятадаас орж ирдэг мотоцикль, хөдөөгийнхөн мал хариулахдаа мориноос илүү хэрэглэдэг мood дэлгэрээд байгаа" гэхгүй юм даа. Бүр сүүлдээ аргаа бараад гавьяа ихтэй үүх түүх рүүгээ гүнзгий орно. Гэхдээ бас хэтрүүлж болохгүй. Учир нь хөтчийн өгсөн тайлбарыг доош унагасан үзмэр олонтой. Олонтой ч гэж үзээд байх барьцтай үзмэр угаасаа ховор. Жишээ татахад, нэгэн цагт Монголын эзэнт гүрний нийслэл байсан гэгддэг Хархорум хотын туурь, одоогийн Эрдэнэ зуу хийдийг зорин ирсэн хөгшин жуулчин "Там шиг замаар энэ хүртэл явчихаад ийм ч юм үзэх гэж дээ" хэмээн уйлж байсан юм гэдэг. Хөтчийн нүдээр аялал жуулчлал нэг иймэрхүү.

Энэ бүх асуудалд нүүрээ ширлэж, нүдээ бүлтийлгэн учрыг нь олж хужрыг нь тунгаадаг хүмүүс бол хөтөч орчуулагч нар билээ. Мэдээж хэрэг тэдний хоёр дахь гэр бүл болох ажил олгогч жуулчны компаниуд тэр дундаа тухайн аялал ба хөтчийг хариуцсан менежерүүд их үүрэг гүйцэтгэдэг. Гэвч эцсийн эцэст компанийн бэлдсэн хоолыг эзэнд нь хүргээд, аманд нь халбагадаж өгч байгаа хүмүүс хэн бэ гэвэл хөтөч тайлбарлагчид. "Номадик Экспедишн" компанийн гэрээт хөтөч-орчуулагч Л.Соёлмаа "Би хөтөч-орчуулагч болон жолоочийг гадаадын жуулчны өмнө өөрийн орныг төлөөлж байгаагийн хувьд Элчин сайдтай адилтгадаг. Бид ямар байна жуулчид тэр хэмжээнд л Монголын тухай сэтгэгдэл өвөртлөөд буцна шүү дээ" гэв. Хөтөч бол зөвхөн орчуулагч биш юм. Тиймдээ ч тайлбарлагч гэдэг үг дагадаг биз.

Нас, зүс, туршлагын хувьд аялал жуулчлалын салбар хөтөч-орчуулагч нарт ажил олгогчийн зүгээс тийм ч өндөр шаардлага, шалгуур тавиад байхгүй нь сайхан. Учир нь, энэ салбарын компаниуд зуны гурван сар л тэднийг ажлаар хангах боломжтой учир нэг их үнэд ороод байдаггүй гэсэн үг. Харин ч олдож байгаа хөтөч орчуулагч нараа цаашаа гэж их зан гаргавал жуулчны оргил үе болох баяр наадмаар амаа барих нь энүүхэнд. Ёстой л "Голсон юм голд, шилсэн юм шилд" гэгч болж хөтчийн эрэлд хатах нь тэр. Зарим үед менежер нь хөтөч болчихсон гүйж явах нь бий.

Хөтөч-орчуулагчдын ихэнх хувийг багш, оюутнууд гэсэн зун урт хугацаанд амрагсад эзэлнэ. Оюутнууд жуулчлалын салбартай түр "ханилж", сургуулиа дүүргэсэн даруй усны шувууд адил зүг зүг нисэн одно. Зарим хөтөч-орчуулагчийн хувьд сэтгэл зүрхээрээ соронзон мэт татагдан энэ салбараас хэчнээн зүүгдэж үлдэхийг хүсэвч өвлийг өнтэй давахын эрхэнд өөр ажил хийхээс аргагүйд хүрдэг. Иймээс аялал жуулчлалын салбарт боловсон хүчин тун ч тогтворгүй. Аялал жуулчлалын компаниуд дээд тал нь таваас зургаан үндсэн хөтөч-орчуулагчтай байх бөгөөд бусдыг нь

улирлын чанартай гэрээгээр авдаг. Тэдний хувьд хөтөч орчуулагчдын ийм цомхон бүтэцтэй байхад болоо гэж үзэх нь ч аргагүй. Манайд өвлийн аялал жуулчлал төдийлэн хөгжөөгүй учраас хөтөч нарт сул цалин өгөөд суух баян газар гэж хаа байхав. Олон жилийн туршлагатай хүнээ нэг л мэдэхэд алдаж, дахин нэг шинэ хүнтэй ноцолдож араас нь зовон суудаг нь тэдний бэрхшээл. Зарим туршлага мэдлэг нимгэнтэй тайлбарлагчийн хувьд ертөнцөөр хэрэн хэссэн туршлагатай жуулчдыг хөтлөхийн оронд ажлаа заалгаж, хөтлүүлчихсэн явах нь ч энүүхэнд. Уулын мод урттай богинотой гэдгээр орхиж одох нэг нь байхад тунаж үлдэх нөгөө нь бас бий.

Уг нь аялал жуулчлалын салбар цалин пүнлүүний хувьд тийм ч бусдад дээрэлхүүлж хүнээ алдаад байх хэмжээнд биш. Хөтөч тайлбарлагчдын хувьд бас ч гэж гарын мөнгө хэмээх цалингаас гадуурх орлоготой. Гэхдээ хэчнээн өндөр цалин амласан ч өвлийн гурван сар гэртээ ажилгүй, цалингүй гиюүрч суухыг хэн хүсэх билээ. Иймээс улирлын шинжтэй байдаг сул талаас нь үүдэн тэдний итгэл сэтгэл өөр зүгт урвах нь элбэг.

Сүүлийн жилүүдэд тус салбар уул уурхай руу чадвартай хөтөч -орчуулагчдаа алдах нь ихэссэн билээ. “Номадик Экспедишн” компанийн хөтөч-орчуулагч М.Ананд “Хөтөч хүний хувьд өндөр цалин гэхээсээ илүү тогтмол ажлын байртай байх нь хамгийн чухал. Санаагаар болдог бол жуулчны компаниуд ямар нэг компанитай гэрээ хийгээд өвлийн улиралд орчуулагчдаа өгчихдөг, зундаа авчихдаг байгаасай” гэж ярьсан.

Мэргэшсэн нь үү, мэргэжилтэй нь үү

Монголын аялал жуулчлалын холбооны тэргүүн Н.Эрдэнэбатын бидэнд мэдээлснээр өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 50 орчим их, дээд сургууль жил болгон аялал жуулчлалын мэргэжлээр 400 гаруй боловсон хүчин бэлтгэж байна. Гэвч тус салбарын хүний нөөцийн шингээх чадвар нь дөнгөж 120 мэргэжилтэн байдаг гэнэ. Аялал жуулчлалын салбарт гадаад хэлний мэдлэггүй ажилтан хэр хол явах вэ. Нэг ч алхахгүй. Тэгвэл дээрх 400 гаруй төгсөгчийн хэд нь гадаад хэлийг өндөр түвшинд биш юмаа гэхэд хүнтэй харьцах хэмжээнд эзэмшдэг вэ гэдэг бүрхэг асуудал.

Жишээ нь, ХАААИС-ийг 2007-2011 онд Байгалийн аялал жуулчлалын менежер мэргэжлээр 62 оюутан төгсчээ. Гэвч тэднээс өнөөдөр мэргэжлээрээ ажиллаж байгаа нь нэг ч үгүй тухай тус ангийн нэгэн төгсөгчөөс сонссон юм. Эх сурвалж болох эмэгтэй маань өөрөө ч өнөөдөр ажилгүй сууна. Тэд харин зэрэглэл өндөртэй буудалд хүлээн авахын ажилтан эсвэл хөтөч орчуулагч хийж яваа нэгнээ дөнгүүрт тооцно. Ингэхээр тус ангийнханд их сургуулийн боловсролын хөтөлбөрөөс олж авсан хэлний мэдлэг бараг алга гээд хэлчихэд буруудахгүй нь. Мэргэжлийн ангийн оюутнууд яагаад гараад хоолоо олж идэх гол чадвараа эзэмшиж чадахгүй байна вэ. ХАААИС-ийн аялал жуулчлалын ангийг дүүргэсэн оюутнуудын хэлснээр оюутан болсон эхний хоёр жил нь долоо хоногт хоёр цагаар англи хэлний хичээл орж байгаад гурав дахь жил нь хаажээ. Бие физиологийн хувьд эрүүл чийрэг, хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй, аялал жуулчлалын мэргэжилтэн залууст гадаад хэлгүй ч гэсэн ажил олдолгүй дээ. Гэхдээ аль нэгэн жуулчны баазын гэрийн үйлчлэгч, зөөгч их дээрдлээ гэхэд үнэтэй зоогийн газарт эсвэл буудалд хүлээн авахын ажилтан болно. Их сургуулийн дөрвөн жилийн хөлс хүч, хөрөнгө мөнгө үүнээс илүү гавих гавьяагүй гэж үү. Чанартай аялал жуулчлалыг хөгжүүлье гэж дээр дооргүй яриад л байдаг. Гэтэл чанартай боловсон хүчингүйгээр гадаадынхан манайхыг тоох уу.

Монголд мэргэшсэн хөтөч орчуулагч байна уу гэвэл бас л хэцүү. Аялал жуулчлал өндөр хөгжсөн бусад орны адил загас, шувууны гэх мэт аялалуудыг зохион байгуулъя гэхээр мэргэшсэн хөтөч олддоггүй учир гаднаас мэргэжлийн хөтөч урьж авчирдаг байна. Тухайлбал, мэргэжлийн загасны хөтөч усан дээр найм, есөн сар бэлтгэл хийх ёстой байх жишээтэй. “Номадик Экспедишн” компанийн дэд ерөнхийлөгч Я.Бадрал хэлэхдээ “Манайд мэргэжлийн хөтөч нэн хэрэгтэй байна. Сайн хөтөч орчуулагч дутмаг учир бид ганцаарчилсан эсвэл цөөн хүнтэй аяллаас татгалздаг” гэв.

Мэдээлэл хүргэх ур чадвар, үйлчилгээ үзүүлэх соёлын асуудал өнөөдөр нэн тэргүүнд тулгамдаж байна. “Хөтөч орчуулагч, тогооч гэх мэт нарийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулах шаардлагатай” хэмээн БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газрын дарга Ц.Оргодол хэлсэн. Харин “Нью жуулчин” компанийн захирал Ш.Нэргүй “Хөтөч-орчуулагч нарыг бүсчилж төрөлжүүлэх хэрэгтэй байна. Тухайн хариуцсан орон нутгаа маш сайн мэддэг мэргэшсэн тийм л хөтөч-орчуулагч шаардлагатай. Энэ бол олон улсын аялал жуулчлалын жишиг” гэж онцолсон.

Наад захын жишээ дурдахад манай урд хөршид хөтөч-тайлбарлагч болохын тулд тухайн хүн хоёроос гурван сарын хөтөч-орчуулагчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, шалгалт өгч, мэргэжлийн үнэмлэх гардсаны дараа сая нэг жуулчны гараас хөтлөх журамтай. Харин манайд болохоор хоёроос гурван долоон хоногийн сургалтад сууна. Тэгээд л хөтөч болчих нь.

Саяхан “Нью Жуулчин” компанитай хамтран ажиллахаар гэрээ байгуулаад буй Америкийн ОАТ компанийн төлөөлөгчид Монголд ирж хөтөч- орчуулагч нарын дунд мэргэжлийн чиг баримжаа олгох долоо хоногийн сургалт зохион байгуулсан юм. Ганцаарчилсан болон багийн ажил, жүжигчилсэн тоглолт мөн төрөл бүрийн хөгжилтэй атлаа үр өгөөжтэй тоглоомыг зохион байгуулж байсан нь тун ч шинэлэг, өгөөжтэй санагдав.

Дээрх сургалтын үр дүн энэ зун гарна. Аялагчдаа хаанд өргөмжилдөг ОАТ компанийг сонгон үйлчлүүлж буй Америкийн жуулчид Монголд аялаад буцахдаа “Маш сайн” гэдэг үнэлгээг өгөх ёстой. Монголын аялал жуулчлалын багш, мэргэжилтнүүд хичээлээ заахдаа ганцаар ярьдаг, бусад нь сонссон болдог арга барилаа халах цаг болжээ. ■

ТЕХНОЛОГИ

ТЭНЦВЭР

Сүүлийн жилүүдэд Монголын аялал жуулчлалын онцлог болсон гэр жуулчны баазууд бороонy дараах мөөг адил олширч байгаа билээ. Тэдний дотор сайн нь ч, саар нь ч бий. Манай сэтгүүл энэ удаа жуулчдыг аль болох ая тухтай байлгах үүднээс мөн экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах зорилгоор дэвшилт технологи нэвтрүүлж, амжилттай үйл ажиллагаа явуулж буй зарим жуулчны баазыг “Технологи” буландаа орууллаа.

Б.ЦЭЦЭЭ

Талд сүндэрлэх тансаг харш /Three Camel Lodge/

Тээр жил, зуны дунд сар байсан юмдаг. Өөрөө ч очиж үзээгүй Өмнийн говиор зам мэдэхгүй жолооч, зан нь олдохгүй хоёр эмэгтэйтэй аялж билээ. Тэр нэгэн өдөр төөрч будилсандаа ч тэр үү, машинтай онхолдохоо



шахсан. Харуй бүрий болсон хойно талд сүндэрлэх тансаг харшид ойртон ирэх тэр мөчид сэтгэлд хургасан айдас жаргаж буй нар, үлээж буй салхитай хамт замхран алга болох мэт санагдаж билээ.

“Гурван тэмээт” буюу “Говийн гурван тэмээ” хэмээх содон нэртэй сонирхолтой жуулчны бааз нэгэн цагт үлэг гүрвэлийн өлгий нутаг гэгддэг байсан Өмнөговь аймгийн Булган суманд байдаг. Эртний сүм хийдийн загвар хийцийг санагдуулам өвөрмөц төрхтэй тус баазын барилга байшин тэр чигтээ чулуу, модноос бүтнэ. Байгалийн чулууг эвлүүлж барьснаас гадна чулуугаар хүрээлснээс өөр хашаа хороогүй нь говь нутгийн унаган төрхтэй нэгэн бие мэт уусан зохицоно.

Бүтээн байгуулалтын ажилд нь бүтэн хоёр жилийн хөлс хүч орсон тус бааз 2002 оноос жуулчдад үйлчилж эхэлсэн бөгөөд нэг ээлжиндээ 50-60 хүн хүлээн авах боломжтой. “National Geographic” аяллын сэтгүүл “Гурван тэмээт” баазыг 2009 онд /50 Top Ecolodges/ байгаль орчинд ээлтэй шилдэг 50 амралтын газрын нэгээр онцолсон удаатай. Нар, салхины орон Монголын говьд “Гурван тэмээт”-ийнхэн ногоон технологийг бүрэн нэвтрүүлжээ. Эднийх нарны 50 орчим толь, хоёр салхин сэнс ашиглан эрчим хүчний хэрэглээгээ хангадаг. Өмнө нь нар болон нүүрс ашиглан шүршүүр, угаалтуурын усаа халаадаг байсан бол энэ жилээс нүүрснээс татгалзаж, дан нарны энергиэр халаах болжээ.

Тус баазад анх оччихоод гэрлийн унтраалгыг нь хайж будилж билээ. Ихэнх баазын гэрүүдийн баганан дээр эсвэл хойморт байрладаг гэрлийн унтраалгыг хаалганы дээд талд буюу тотгонд байна гэж хэн санах билээ. Харанхуйд унтраалгандаа хүрэх гэж сандал ширээ, зуух тэмтчин, тээглэж унах дөхдөг гадаадын төдийгүй дотоодын гийчдэд энэ нь тун ч тохиромжтой шийдэл болж чаджээ. Үүдээр шагайхдаа л гэрлээ асаагаад орно гэсэн үг. “Гурван тэмээт” баазын эзэмшигч Монголын тэргүүлэгч аяллын компаниудын нэг “Номадик Экспедишн” АНУ-ын зах зээлд голчлон анхаарлаа хандуулж, америк аялагчдыг түлхүү хүлээн авдаг. Тиймдээ ч жуулчдын тухлах гэрийн дотоод төлөвлөлтөд энэ онцлогоо ч тусгаж өгөхийг оролджээ. Тухайлбал, унтлагын ор нь харьцангуй том байдаг нь дундаж америк хүний нурууны өндрөөр бодолцон хоёр метр 20 см-ын хэмжээтэй хийжээ. Аюулгүй байдлын



хувьд монгол гэрийн шатамхай байдлыг тооцон галын хорыг гэр бүрт байрлуулсан байх юм. Баазаас 400 метрийн зайтай жижиг сүм хэлбэрийн байшин бий. Энэ бол худаг. Худагт генератор суурилуулж 130 метрийн гүнээс ус гаргасан нь өнөөдөр тус баазын төдийгүй тэр хавын хүн малын усны ундарга болжээ. Гэвч ундарга нь тийм ч сайн биш гэнэ лээ. Хангайд хар гэгддэг ус Говьд чандмань эрдэнэ юм. Иймд тэд цаашид усаа хэмнэх олон төрлийн санаачилга гаргаж, хэрэгжүүлэхээр зорьж байгаагийн дотор саарал усаа цэвэршүүлж мод услах, шүршүүр, суултуур гэх мэт ундны бус хэрэглээнд ашиглах явдал аж. Энэ жилээс усаа хар, саарлаар нь ялгаж ашиглахаар шинээр хоолой тавьж байгаа бөгөөд ирэх жил саарал усны хэрэглээг нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа юм байна. Түүнчлэн үйлчилгээгээ илүү чанаржуулах үүднээс энгийн гэрүүдээ цөөлж, бүх гэрээ дотроо угаалгын өрөөтэй люкс ангиллын болгохоор бэлдэж байна. Мөн зарим гэрт угаалгын өрөөнөөс гадна хүүхэд болон эцэг эхийн гэсэн тасалгаа бий болгох мэргэн санаа олжээ. Мөн гэрүүд нь нарны хавтангаар цэнэглэгддэг гэрэлтүүлэг болон түлш зарцуулалт бага авч халууныа удаан барьдаг зуухтайгаараа давуу байх гэнэ. Цаашид ч энэ мэт олон шинэ санаа “Гурван тэмээт” баазынханд төрсөөр байх биз ээ.

Мөрөөдлийн орон /Dreamland Resort/

Нов ногоон, цав цагаан, цэв цэнхэр энэ бол “Дриймланд”. Үл үзэгдэх мөрөөдлийн орон мэт энэхүү жуулчны бааз голын захаар ургасан моддын дунд үзэмжээ нуун олны хараанаас ангид оршино. Догшин арслан сахисан хаалгаар нь орж, гүүрээр давахад яг л үлгэрт гардаг ордны үүдээр нэвтэр ч байгаа мэт сүртэй. Машины зогсоолоос цааш модон дундуур алхаж очдог. Эндээс хүртэл баазын бараа сураг харагддаггүй нь улам ч сонирхол татна. Хэдхэн алхаад дахин нэг томоо гэгч нь модон гүүртэй таарна. Бороо их орсон тэр өдөр жижигхэн горхи урсаж байсан юм. Алт эрдэнэс дүүрэн авдар онгойлгох гэж буй мэт гүүрээр алхах хэсэгхэн хугацаанд шигүү ургасан моддын цаана юу хүлээж байгаа бол хэмээх бодолд хөтлөгдөн яарна. Гэтэл өмнөөс минь улаан, цагаан өнгийн туг мандуулсан донжтой байшин, цав цагаан өнгийн том, жижиг гэрүүд, өвдөг шүргэм цэцэг ногоо, цэнхэр тэнгэр, хадаг мэт намилзах голын чимээ угтдаг.

Хорих ангийн мэдэлд байсан гэгддэг энэхүү газрыг “Мөрөөдлийн орон” болгон хувиргасан эзэн нь “Аса Травел” компани юм. Тус бааз нь Монголын эзэнт гүрний нийслэл байсан Орхон голын эрэг дээр буюу одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт 2005 оны долдугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Байгалийн чулуу модоор бүтсэн тус баазын зохион байгуулалт бусдаас өвөрмөц. Орчин үеийн тохижилт бүхий угаалгын өрөөтэй хоёр давхар зочид буудал санал болгохын зэрэгцээ XIII зууны үеийн тохижилттой гэрүүд бас бий. Хэдий зун цаг ч гэлээ үүр шөнийн цагаар жиндэж, нойр нь хулжсан жуулчид хувцсаа давхарлаж өмслөө гэдэг. Тэгвэл энэ асуудлыг тус баазынхан халуун, хүйтнээр үлээдэг агааржуулагчаар шийджээ. Бүгчим үед хаалгаа дэлгээд байх ч шаардлагагүй



сэрүүцчихнэ. Хотоос 360 км-ын зайд ирчихсэн атал телевизийн суваг сольж, интернэтээр найз нөхөдтэйгээ сэтгэгдлээ хуваалцах нь сонин. Өвөл, зунгүй ажиллах бүрэн боломжтой “Дриймланд” бааз нь 120 орчим хүнд хүртээмжтэй 35 гэр, 10 өрөө бүхий байшин буудалтай. Орхон голын тусгай хамгаалалттай газарт байрладаг тус бааз орчноо цэвэрхэн байлгах тал дээр ихээхэн идэвх санаачилгатай ажилладгийн нэг илрэл нь тэдний таван дамжлага бүхий 95 хувийн ус цэвэршүүлэх байгууламж юм. Тэдний зүгээс голын бургасыг хайрлаж хамгаалахын хажуугаар жил болгон улиас тарьдаг. Мөрөөдлийн орны модод өтгөн шигүү ургасаар.



“I love Gobi” /Онгийн нууц/

Халуу шатам үдийн нар, энхэл донхол шороон замаар хэдэн зуун км нүдүүлсээр арайхийж зорьсон газраа хүрлээ. Тэртээ 300 гаруй жилийн өмнө хадан хавцлыг өвөрмөц аргаар шатлан тэгшилж, өндөр довжоот суурь засан өөр өөрийн онцлог бүхий уран барилгыг цогцлоон барьсан хэмээн түүхэнд алдаршсан хотын дайтай энэхүү хийдийг “Онгийн гурван хийд” гэнэ. Их хэлмэгдүүлэлтийн үеийн түүхэн золиос уг хийдээс бүтэн сүм, бүрэн хүн үлдээгүй гэдэг бөгөөд 1994 онд сэргээн засварласан авч өдийг хүртэл түүхэн гашуун үнэнийг дүнсгэр төрхөөрөө өгүүлсээр. Хийдийн цаахна талын толгодыг тойрмогц Онгийн хийд амилаад ирэв үү гэмээр өндөр хана, гурван шовгор сүмийн оройтой сүрлэг барилга нүднээ тусна.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутагт Онгийн голын ус ургамал жигдэрсэн үзэсгэлэнт тохойн дэргэд орших “Онгийн нууц” компанийн “Онгийн нууц” хэмээх жуулчны бааз бий. Онгийн хийдийн тууриас тун ч холгүй. Говь, Хангай хосолсон мэт энэхүү үзэсгэлэнт хэсэгт байрлах тус бааз хөл хөдөлгөөн ихтэй. Үүдээр нь ороход л уяан дээр сойсон уралдааны морьд шиг холоос ирсэн зочид гийчдийн төмөр хүлгүүд хурд хүчээ тэнцүүлэн эгнэн харагдана. Тус баазыг жолооч нар тос тосолгооны материал, дугуй засвар, машин угаалга гэх мэт үйлчилгээ үзүүлдэгт нь ихэд олзуурхана. 2010 оны шилдэг жуулчны бааз “Онгийн нууц”-ын ерөнхий төрхөнд эртний сүм хийдийн архитектурыг гүн шингээж өгөхийг зорьжээ. Нийтлэлч Ж.Гангаа “Онгийн нууц дахь Хүннү гэр” нийтлэлдээ “Онгийн нууц” шиг сайтар тохижуулсан газрууд хаа сайгүй байдаг бол аялал жуулчлал манайд хөгжиж уул уурхайгаасдутахгүй ашиг олох боломж харагдаж байна” хэмээн онцолсон нь бий. Байгалийн чулуу, модоор барьсан тус баазын бас нэгэн онцлог нь 90 хүн хүлээн авах чадалтай Хүннү хийцийн хүзүүт тоонотой 45 гэр юм. Баганагүй мэт атлаа тооноосоо ханаа дагаж буусан найман тулгууртай нь гэрийн дотор талд цэлийсэн зай гаргаж өгчээ. Мөн гадна талбайдаа говийн



нарыг өдөртөө “хураан”, оройдоо асдаг гэрэлтүүлгүүдтэй. Аян замдаа алжааж ядарсан аянчин гийчид гүн нойронд автаж өглөө нь сэвхийтэл сэргэг босдог нь тухайн газар орон ер бусын энергитэй гэгддэгийн учир биз ээ.

Шавхагдашгүй нөөц нараар ажилладаг усан халаагуур суурилуулах ажилдаа тэд өнөөдөр орчихсон байгаа аж. Цөлжилттэй тэмцэж, хашаан дотроо бүйлс, жигд, хайлаас, агч гэх мэт дөрвөн төрлийн 100 гаруй суулгац тарьсан бөгөөд тэднийг хэт хүйтэн усаар усалж болдоггүй учир дээрх технологийг нэвтрүүлэхээр болжээ. Нөгөө талаас говь цөлийн бүсэд хамаарагдах хэдий ч алсдаа ой модоор хүрээлэгдсэн бааз болохоор зорьж байгаа нь энэ юм байна. 2012 он “Онгийн нууц”-ынхны хувьд их бүтээн байгуулалтын жил байх бололтой. Учир нь, тэд энэ жилдээ багтаад гэрэл цацарсан усан оргилуур хийж, дуусгахаар зорьж буй аж.

Тус баазын бетон ханан дээр том бас тодоор “I love Gobi” хэмээн бургасаар бичсэн нь хэн хүний нүүрэнд инээмсэглэл тодруулна.





Азийн сувд /Ашихай /

Алсаас бараа нь үзэгдэж эхэллээ. Чийг, ногоо үнэртэж, усны шувууд даллан дуудах мэт ганганалдах дуу нь ойртсоор. Эцэс төгсгөлгүй мэт овойж товойсон чулуу ихтэй зам яарсан сэтгэлийг хясна. Өөрийн эрхгүй сэтгэл догдолж, өөрийн мэдэлгүй урт амьсгаа авна. Азийн сувд хэмээн нэрийддэг номин цэнхэр Хөвсгөл далайг зорих тоолонд тэсч ядаж, очих тоолонд сэтгэл уужирдаг нь энэ удаад ч ав адилхан.

Хөвсгөл аймгийн Хатгал сумын Доод модот хэмээх үзэмж төгөлдөр хэсэгт байрладаг “Ашихай Травел” компанийн жуулчны баазыг “Ашихай” гэнэ. Мартаж зүрхлэмгүй тус баазын нэрийг анх сонссон хүмүүс япон үг гэж тааварлах нь бий. Гэвч энэ нь хотгойд ястан үүсэхэд хамгийн анхны Засаг ноён байсан эрхэм хүнийг ийн нэрийддэг байснаас үүдэлтэй аж. “Ашихай” баазын төв барилга дотор гаднагүй модоор сийлж урласан сонирхолтой зохиомжтой. Дотоод, гадаадын жуулчид байгалийн үзэмжинд нь хошуурдаг Хөвсгөл аймгийн жуулчны баазууд дундаа харьцангүй залууд тооцогдох “Ашихай” энэ жил таван нас хүрч байна.

Хатгал сумын төвийн эрчим хүчтэй шууд холбогдсон хоёрхон баазын нэг нь эднийх. Жуулчны баазуудын шүдний өвчин халуун ус, тогны асуудал тус баазад байхгүй ээ. Технологийн хувьд эрс шинэчлэл хийж, 2010 онд бүх гэрээ шалнаасаа халаалттай болгожээ. Алжааж ядарсан жуулчид шөнө дундын амттай зүүдэнд нь саад хийж гал түлж, тас няс хийлгэх баазын галчид даарч зутрахгүйн эрхэнд орох эрх өгдөг. Харин уг шалнаас халдаг систем нь тогоор ажиллах бөгөөд 50 градус хүртэл халах боломжтой. Ажиллуулахад ч хялбар. Тохируулсан градуст тогтмол халуунаа барьдаг энэхүү систем нь дулаанаа амархан алддаг монгол гэрийн хувьд нүдээ олсон шийдэл. Мөн шалны халаалт нь нүүрстэй харьцуулахад тог их зарцуулдаг, өртөг өндөртэй боловч хаягдалгүй, утаагүй гэх мэт онцлогоороо байгаль орчинд ээлтэй.

Тус баазын дэргэд өтгөн ой дүнхийх ч “Ашихай” баазынхан 2011 онд 5000 хайлаас мод тарьжээ. Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газраас 2010 онд тус баазыг Эко баазаар тодруулж байв. ■



ШИДЭТ МЕНЕЖМЕНТ

“ӨНГӨРСӨН ЖИЛ МОНГОЛ АЯЛЛЫН ӨСӨЛТИЙН ЖИЛ БОЛСОН”

Одоогийн байдлаар монголчууд Хайнан, Чежу гэсэн арал руу хамгийн их явж байна. 2011 он манай компанийн хувьд монгол аяллын өсөлтийн жил болсон. Монголчууд аялж сурч байна.

Х.ХУЛАН

“Нью Жуулчин” компанийн захирал Ш.Нэргүйг “Шидэт менежмент” буландаа урилаа. Аялал жуулчлалын арав гаруй охин компанитай “Нью Жуулчин” группын үндсэн үйл ажиллагаа нь жуулчин болон олон улсын тээврийн үйлчилгээ юм.

-Та салбарынхаа өнгөрсөн оны онцлог хийгээд амжилтын талаар товчхон сонирхуулахгүй юу?

-Өнгөрсөн онд гадаадын 30 гаруй орноос жуулчин хүлээж авсан. Мөн өөрийн орны иргэдийг мөн тооны оронд аялууллаа. Өнгөрсөн оны хувьд Монголд ирсэн жуулчдын тоо ялимгүй өссөн. Харин гадагшаа явж байгаа монголчуудын тоо огцом нэмэгдсэн. Ингэж нэмэгдэх болсон шалтгаан нь нэгдүгээрт, бид МИАТ компанитай хамтарч шууд нислэгүүд зохион байгуулсан. Түүнчлэн онцлон тэмдэглэхэд шинээр бий болсон нэг зүйл бол өнгөрсөн онд аялал жуулчлалын ижил төстэй компаниуд хамтарч аялал зохион байгуулсан явдал. 12 удаагийн аялалд “Жуулчин”, “Женко тур”, “Эир маркет” гэсэн гурван компани хамтарч нислэг хийсэн.

-Хамтарч нэгдэн үйлчилгээ үзүүлэх нь ямар ач холбогдолтой байсан бэ?

-Ингэж хамтарсан нь ихээхэн давуу талыг авчирсан. Нэгдүгээрт, сурталчилгааг дөрвөн компани зэрэг хийсэн учир хүнд хүрэхийн хувьд хүртээмжтэй байсан. Мөн нэг компанид ногдох сурталчилгааны зардал багассан. Хоёрдугаарт, компаниудын эрсдэл буурсан. Жишээ нь нэг компани дангаараа хуваарьт онгоц авна гэхэд 200 хүн явуулна. Тэгэхээр эрсдэл нь харьцангуй өндөр байдаг. Арван хувийг нь хоосон явуулахад алдагдалд орно. Тэгвэл энэ үйл ажиллагаагаар бид Монголын аялал жуулчлалын компаниуд хамтарч ажиллах ёстой гэсэн олон жилийн яриаг ажил хэрэг болох эхлэлийг тавьж чадсан.

-Монголчууд сүүлийн үед Азийн орнуудаар их аялдаг боллоо. Манайхан аяллын соёлтой болж байна гэж ойлгож болох уу?

-Одоогийн байдлаар монголчууд Хайнан, Чежу гэсэн арал руу хамгийн их явж байна. 2011 он манай компанийн хувьд монгол аяллын өсөлтийн жил болсон. Монголчууд аялж сурч байна. Одоогоос гурав, дөрвөн жилийн өмнө аяллаа тулгаж сандардаг байсан бол одоо гурав дөрвөн сарын өмнөөс зохион байгуулдаг болж байна. Энэ үнэхээр том соёл. Аялах нь хэд хэдэн давуу талтай. Нэгдүгээрт, юм үзэж нүд тайлна. Хоёрдугаарт, тухайн орны түүх соёлтой танилцана. Гуравдугаарт, аялах явцад олон түншtэй болдог. Шинэ бизнесийн санаа ч олж авах нь бий. Эцэст нь эрч хүч авдаг. Монгол хүн далай дээр амарна гэдэг бол үнэхээр их эрч хүч өгдөг. Аялж ирсний дараа тэгчихмээр, ингэчихмээр юм байна гэсэн санаа ундардаг юм.

-Монголд ирэх жуулчдын тоог 2015 он гэхэд нэг саяд хүргэнэ гэж 2006 оноос ярьж байгаа. Энэ зорилтод хүрэх магадлал хэр байгаа вэ?

-Сүүлийн арав гаруй жилийн турш нэг сая жуулчин авна гэж ярьсан. Одоо байдал нэлээд өөр болж байна. Монгол руу аялахад гол бэрхшээлтэй асуудал нь агаарын тээвэр. Өрсөлдөөн бий болж байж л дээрх зорилтод хүрнэ. Өмнө нь хоёрхон онгоцтой байж нэг сая жуулчин авна гэдэг байсан. Одоо бол харин 2015 он хүртэл нэг сая жуулчин авах магадлал биелэх нь өндөр боллоо. Агаарын тээврийн өрсөлдөөн бий болсон. Үүнийг дагаад багтаамж сайжирна. Мөн үйлчилгээний түвшин нөлөөлнө. Олон улсын зэрэглэлтэй зочид буудлууд бий болж эхэллээ. Энэ утгаараа төлөвлөсөн тоонд хүрэх магадлал байгаа.

Мэдээж Монгол орны ерөнхий сурталчилгаа зайлшгүй шаардлагатай. Энэ тал дээр төр, засгаас дэмжээд эрчимтэй, зөв, оновчтой хийх асуудал тулгарч байна. Одоогоор бид олон улсын үзэсгэлэнд оролцохыгоо л аялал жуулчлалын сурталчилгаа гэж ойлгоод буй. Сурталчилгааны менежментийг цоо шинээр гаргасан тохиолдолд зорилгодоо хүрэх боломж бий.

-Уул уурхай эрчимтэй хөгжихийн сацуу аялал жуулчлалын салбар юун дээр анхаарах хэрэгтэй вэ?

-Уул уурхайн хөгжилтэй холбоотой сайн, муу зүйл олон. Хөрөнгө оруулалт, бизнесийн чиглэлийн жуулчин нэмэгдэх нь сайн талтай. Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр олон улсын зэрэглэлийн буудлууд, барилга объектууд баригдаж байна. Энэ нь сайн хэрэг. Гэхдээ



Фотог Э.Зоригт

зарим нэг бодох хэрэгтэй сөрөг үзэгдлүүд байгааг хэлэх хэрэгтэй. Монгол нүүдлийн соёл иргэншлээ хэт үгүйсгэх, мартах асуудалд орж магадгүй хандлага ажиглагдаж байна. Гурваас таван одтой буудал барих бодолтой бизнесийн хүн олон байна. Хэрвээ бид нүүдлийн соёл иргэншлийг үгүйсгээд суурин соёл рүү шилжээд бүх бааз дөрөв, таван одтой буудал болчих юм бол бусад орноос ялгагдах мөн чанар нь юу байгаа юм бэ? Балансаа барихгүй бол нэг өдөр бүгдээрээ Монголоо үгүйсгээд дуусах вий гэсэн болгоомжлол өөрийн эрхгүй төрж байгааг нуух юун.

Өөр нэг зүйл нь бол уул уурхай ажиллаад эхэлчихлээ. Үүний ард Монголд өөр нэг том уурхай байгаа. Тэр нь манай нүүдлийн соёл иргэншил юм. Энэ уурхайгаа бид яаралтай хамгаалж, сэргээж, үнэд хүргэх асуудал хамгаас чухал билээ.

Дэлхий нийтийн шинжлэх ухаан, техникийн хөгжлийн үед өнөөдрийн хөгжил хүний эрүүл мэнд, байгальдаа нөлөөлөөд эхэлчихлээ. Дэлхий даяар дулаарал, байгаль хамгаалалын асуудал яригдаж байна. Энэ үед манай Монголын нүүдлийн соёл иргэншлийн загвар улам нэр хүндтэй болно. Манай энэ загвар нь байгаль орчиндоо ээлтэй, хүлэмжийн хий гаргадаггүй технологи тул үнэ цэнэ нь нэмэгдэж байна. Үүнээс гадна манайд ирж байгаа жуулчдын үзэх үзвэрийн гол нь нүүдлийн соёл иргэншил байх ёстой. Бид үүнийгээ мартаад, Европ маягаар шууд түүх үзүүлэх эсхүл хялбарчлаад малчин айлд орох гээд байдаг. Уламжлал зан заншлаа сэргээгээд тэрнийгээ бүтээгдэхүүн болгож хүмүүст үзүүлэх асуудал гарч байна.

Тогтвортой, нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал, эко-туризм гэж яригдаж байна. Энэ чиглэлд бид хамтарч ажиллах ёстой. Хятад улс сүүлийн арваад жилд энэ асуудлаар маш хүчтэй хөгжлөө. Үндэстнүүдийнхээ зан заншлыг төрөөс дэмжээд, түүнийгээ үзвэр болгоод зан заншлыг нь сэргээхээр тэр нь өөрөө бүтээгдэхүүн болоод хувирчихаж байгаа.

-Та аялал жуулчлалын салбарыг шүүмжилж чадах уу?

-Жуулчны баазууд байгаль хамгаалах асуудал дээр шаардлага хангахгүй байна. Дээрээс нь соёл иргэншлийн тухайд бид нартай хамтарч ажилладаггүй компаниуд нэлээд шүүмжлэл хэлдэг болсон. Юу гэж байна вэ гэхээр, одоогоос арван жилийн өмнө Монголд малчин хүн гэж байсан. Одоо байхгүй болж байна. Малчин гэхээр сайхан уужуу тайван сэтгэлтэй, алсыг харсан бодолтой, шуналын нүдгүй байсан. Харин орчин үеийн монгол малчид европ хувцас өмссөн, сархад үнэртүүлсэн, нүдэнд нь мөнгө л эргэлдсэн хүмүүс болоод хувирчихжээ гэж байна.

Эко-туризмын асуудалтай холбоотой нэг зүйлийг хэлье. Гадаадад монгол гэр моодонд орж байна. Гадаадын өндөр зэрэглэлийн эко-бааз гэвэл дандаа монгол гэрийн загварууд болсон байх жишээтэй. Таван одтой гэр бааз гээд хүртэл гарсан байна лээ. Манай өвөг дээдсийн олон зуун жилийн туршид авч явсан технологийг үгүйсгэж болохгүй. Одооноос эхэлж энэ тухай ярих хэрэгтэй байна.

-Та жуулчны баазууд байгаль хамгааллын асуудал дээр шаардлага хангахгүй байна гэлээ. Танай компанийн хувьд байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ямар арга хэмжээ авч байгаа вэ?

-Бид эко-туризмын үзэл бодлыг бий болгохын тулд сүүлийн хоёр жил сурталчилгаа хийж байна. Олон хүн оролцож байгаа. Орон нутгийн иргэд, орон нутаг, бизнесийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын гэсэн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих учиртай. Өнөөдөр жуулчид хог хаяхгүй байх сэтгэлгээнд суралцлаа. Одоо бидэнд дээр хэлсэн талуудын уялдаа холбоог яаж сайжруулах вэ, яаж хамтарч оролцох вэ гэдэг асуудал гарч ирж байна.

Манайх Тэрэлжид “Гуру” нэртэй загвар эко-бааз байгуулсан. Үүнийг эко-цогцолбор гэж нэрлэсэн байгаа. Бид байшин барихгүйгээр, гэр-хотхон маягийн загварыг сонгосон. Нийт 12 гэр барьсан. Эхний гэр казах зан заншлынх, хоёр дахь нь цагаан идээний үйлдвэрлэл гэх маягаар байрласан. Малын гаралтай эко бүтээгдэхүүнээр гар урлалын бүтээгдэхүүн хийсэн байх жишээтэй. Сүү цагаан идээг малчдаас авч байдаг. Хүүхдүүдийг сургаж дадлагажуулж байна. Энэ загвар нь гэгээлэг, цаашдаа ч гэсэн хэрэгжүүлэхэд боломжийн зүйл юм. Нэр нь эко-цогцолбор, байгальд ээлтэй технологиор хийе гэсэн санаа гарч байгаа.

Энэ жил Тэрэлжид бохирын системийг хэрхэн шийдэх, дулаан эрчим хүчээ яаж багасгах талаар холбогдох газруудтай ярьж байгаа. Мэргэжлийн олон хүний тооцоо хэрэгтэй болдог юм байна. Эхлүүлсэн төслөө таван жилд хэрэгжүүлнэ. ■

ТЭЭВЭР

ШИНЭ НАР МАНДАЖ ЭХЭЛЛЭЭ

Аялал жуулчлалын тээврийн салбарт шинэ нар мандаж эхэллээ гэж хэлж болох нь. Зах зээлийн өрсөлдөөн, шидэт менежмент, хөгжлийн ноу хау тус салбарт шинэ өнгө төрхийг бий болгож байна.

Б.БАЯРТОГТОХ

Урьхан салхи, анхны бороо, усны шувуудтай хамт аялал жуулчлалын салбар сэрж байна. Ханзрах цас, хаврын шинэ ногоотой тус салбарынхан үүдээ дэлгэж, өрхөө татлаа. Ярайтал нь дэлгэсэн Монголын аялал жуулчлалын хаалгаар дэлхийн жуулчид нэвтрэх "оргил цаг" айсуй. Харин үндэсний өв соёл, өргөн уудам нутаг усныхаа үзэмж гоог жуулчинд "тольдуулах" тээврийн салбарынхан бэлэн үү. "Манай улс 2015 онд нэг сая жуулчин хүлээн авахаар төлөвлөсөн. Гэтэл дэд бүтцийн хөгжил дэндүү сул хэвээр нөхцөлд нэг сая жуулчин хүлээн авах нь эргэлзээтэй" хэмээн Аялал жуулчлалын үндэсний төвийн дэд захирал Н.Молор хэллээ. Тэрбээр "Өнөөдөр манайд төмөр зам, агаарын тээврийн хүрэлцээ хангалтгүй байна. Тээврийн салбарынхан хүчин чадлаасаа давсан үйлчилгээг үзүүлж байна. Гэхдээ сүүлийн үед энэ салбарт том ахиц дэвшил гарч байгаа" гэв.

Тав тухтай, өөрийн дураар аялах сонирхолтой жуулчинд Монголын зорчигч тээврийн үйлчилгээ тун ч зүрхшээмээр бэрхшээлтэй санагддаг нь мэдээж. Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлалын салбарынхан тээврийн үйлчилгээнээсээ болоод өчнөөн жуулчинг үргээсэн нь үнэн. Тэгвэл аялал жуулчлалын тээврийн салбарт шинэ нар мандаж эхэллээ гэж хэлж болох нь. Зах зээлийн өрсөлдөөн, шидэт менежмент, хөгжлийн ноу хау тус салбарт шинэ өнгө төрхийг бий болгож байна. Тухайлбал, саяхан Төв аймгийн "Хөшигийн хөндий"-д олон улсын нисэх буудал байгуулахаар шав тавьсанд зөвхөн монголчууд төдийгүй Монголд аялах сонирхолтой гадаадын жуулчдын сэтгэлд ч баярын мишээл гийгээ биз ээ. Ийнхүү орчин үеийн үйлчилгээнийн шаардлага, дэлхийн жишигт нийцсэн онгоцны буудалтай болох нь дамжин өнгөрөх тээвэрлэлтийн хурд энэ хэрээр олон улсын стандартад ойртож байгааг тус салбарынхан онцолж байна.

Шинэ нисэх буудлын онгоц хөөрч буух зурвас нь 3600х45 метр хэмжээтэй. Хоёр талаасаа онгоц хөөрч, буух боломжтой бөгөөд зорчигч үйлчилгээний терминал нь нэг цагт 1100 зорчигч хүлээн авах хүчин чадалтай байх аж. Эхний ээлжинд онгоц хүлээн авах зургаан хүзүүвчтэй байна. Иж бүрэн барилга байгууламжаас бүрдсэн олон улсын шинэ нисэх буудал 2016 онд ашиглалтад орсноор аэродромын хяналтын код 40-өөс 4Е-д шилжих бөгөөд 2019 он гэхэд олон улсын болон дотоодын нислэгээр жилд 1,6 сая зорчигчид үйлчилж, 11900 тонн ачаа тээвэрлэдэг болох зэрэг чихэнд чимэгтэй мэдээг дурдахад таатай байна.

Агаарын тээвэр амсхийх нь

Цаг хугацаа хэмнэх, ая тухтай »

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй агаарын тээврийн компани:


- МИАТ ХК
- Аэромон
- Голиа ХХК
- Изинис эйрвэйз ХХК
- Блю-скай авиашн ХХК
- Тэнгэрийн улаач ХХК
- Геосан ХХК
- Томас эйр ХХК
- Ажэт авиашн ХХК
- МАК ХХК
- Чингис эйрвэйз ХХК
- Монголиан эйрлайнс групп ХХК

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын агаарын тээврийн компани:

- Аэрофлот /ОХУ/
- Эйр чайна /БНХАУ/
- Кореан эйр /БНСУ/
- Тянжинь эйрлайн /БНХАУ/

2012 онд үйл ажиллагаа явуулж эхлэх:

- Эйр астана / /Казахстан улс /
- Туркиш эйрлайн /БНТУ/



зорчих хамгийн таатай тээвэрлэлт бол агаарын тээвэр учраас жуулчдын олонхи нь агаарын тээврийг сонгодог. Нөгөө талаас жуулчин гэдэг мөнгөө үрэх гэсэн адгаж яваа хүн биш, хуримтлуулж, хураасан хөрөнгөнөөсөө өөртөө зарцуулж буй үйлчлүүлэгч юм. Тиймээс үйлчлүүлэгч хэзээд хямд өртөгтэй байхыг хүсэх нь мэдээж. Тэгвэл Монгол Улсад зочлох жуулчдын тоо тодийлэн нэмэгдэхгүй байгаагийн гол шалтгаан нь манай агаарын тээврийн хэт өндөр үнэ өртөг гэдгийг Молор захирал хэлсэн. Тэгвэл аялал жуулчлалыг уул уурхайтай эн зэрэгцүүлж хөгжүүлэхийн тулд агаарын тээврийн үйлчилгээний үнийг бууруулах боломж байна уу гэдэг дээр хэн хүнгүй төвлөрч бодох цаг болжээ.

Уг нь агаарын тээврийн үйлчилгээнд сүүлийн үед том хөгжил гарч буй. Яаж тэр вэ гэж үү. Өмнө нь чөдрийн ганц морь гэгддэг МИАТ компани л гадаад руу нислэг үйлддэг байв. Харин одоо жуулчид Монгол руу хүссэн үедээ нисэх боломж бүрдэж байна.

Үүнтэй холбоотой сайхан мэдээ дуулгахад зөвхөн өнгөрсөн онд л гэхэд агаарын тээврийн хувь, хувьсгалын компаниуд нийтдээ 13 хөлөг оруулж иржээ. Үүний зургаа нь “АН-858”, “Аэробус 319”, “Боинг 767” маркын хөлгүүд аж. “Боинг 767” онгоц нь бизнес ангиллын 18, энгийн 245 суудалтай. Харин “Аэробус 319” нь 108 энгийн, 12 бизнес зэрэглэлийн суудалтай аж.

Үндэсний тээвэрлэгч МИАТ хувьцаат компани парк шинэчлэлийн хүрээнд АНУ-ын “Боинг” компаниас ирэх онд “Бионг 767-300”, 2015 онд “Бионг 737-800” загварын цоо шинэ агаарын хөлөг худалдан авч, олон улсын нислэг үйлдэнэ. Эндээс үзэхэд манай улсын агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж эрс нэмэгдэхээр байгаа нь харагдана. “Удахгүй манайх Европ, АНУ-ын зүүн, баруун эрэг рүү нисэхээр бэлтгэж байна. Ер нь бүх тив рүү нислэг үйлдэх цаг ойртлоо. Агаарын тээвэрлэгч компаниуд үүд хаалгаа нээхийн хэрээр нислэг хүртээмжтэй, өрсөлдөөнтэй болж үр дүнд нь үнэ



тариф буурна” хэмээн Иргэний нисэхийн ерөнхий газрын ерөнхий захирал С.Батмөнх онцоллоо.

Агаарын тээврийн үйлчилгээнд шинэ компани, шинэ хөлөг нэмэгдэхийн хэрээр зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ сайжирч буй нь энэ. Баримт сонирхуулахад, өнгөрсөн оны байдлаар олон улсын зорчигч эргэлтийн тоо 33, дотоодын зорчигч эргэлт 26 хувиар өссөн бол энэ оны эхний улиралд л гэхэд олон улсын зорчигч тээврийн эргэлт 50 орчим хувиар нэмэгдэж, орон нутгийн зорчигч 30 гаруй хувиар өсөх дүнтэй гарчээ.

Төмөр замаар дэлхийг тойрохсон, гэтэл

Монгол оронд ирж буй жуулчдын олонхи нь төмөр замаар үйлчлүүлдэг гэсэн судалгаа бий. Төмөр замын салбарт монополь болох “Улаанбаатар төмөр зам” компани энэ онд 19.2 сая тонн ачаа, дөрвөн сая зорчигч тээвэрлэх юм байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад зөвхөн зорчигчийн тоо л гэхэд 200 гаруй мянгаар нэмэгдэж байгаа аж. “Манайх Москва, Иркутск, Хөх хот, Эрээний чиглэлд аялж буй зорчин явагч гадаадын жуулчдыг тээвэрлэж байна. Зуны улиралд Москвагийн чиглэлд долоо хоногт хоёр галт тэрэг, Эрхүүгийн чиглэлд өдөр бүр, Бээжингийн чиглэлд долоо хоногт гурван галт тэрэг, Хөх хотын чиглэлд долоо хоногт хоёр галт тэрэг, Эрээний чиглэлд долоо хоногт дөрвөн галт тэрэг аялуулж байна” хэмээн Улаанбаатар төмөр замын зорчигч тээврийн албаны дарга С.Бат-Очир хэлсэн. Өнгөрсөн онд



төмөр зам дагуух аялал жуулчлалыг хөгжүүлэхээр дотоод гадаадын аяллыг зохион байгуулснаар тус аялалд 6322 жуулчин оролцжээ. Тухайлбал, жуулчны галт тэрэг өнгөрсөн онд 15 удаа аялсан байна. “Төмөр замын зорчигч тээврийн бүх тариф алдагдалтай байдгаас шалтгаалан УБТЗ зорчигч тээврээс тодорхой алдагдал хүлээдэг. Иймд төрөөс жил бүр 21 тэрбум төгрөгийн татаас олгох хэрэгтэй байна” хэмээн Бат-Очир учирлалаа. Тэрбээр “Зорчигчийн вагон хуучирсан. Жуулчид агааржуулагчтай, зурагттай, интернэттэй, усанд орох шүүршүүр, баннтай гал тэргээр аялахыг хүсэх болсон. Одоо манайд УБ-Бээжин чиглэлд аялдаг галт тэрэгнээс бусад нь дээрх шаардлагыг хангахгүй байна. Тиймээс үйлчилгээний чанартаа анхаарах шаардлагатай байна” гэлээ.

Төрөөс татаас олгож, алдагдлаа нөхсөн тохиолдолд воганы тоогоо нэмэх, үйлчилгээгээ сайжруулах боломжтой аж. “БНХАУ-ын 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр төмөр замын салбарын хөдлөх бүрэлдэхүүнийг сайжруулах, шинэчлэх, Замын-Үүдэд ачаа шилжүүлэн ачих байгууламж барих төслийг хэрэгжүүлжээ. Энэхүү төслийн хүрээнд найман зүтгүүр, 245 ачааны вагон, шилжүүлэн ачих байгууламжид зориулж чингэлэг шилжүүлэх техник аваад, ашиглаж байна. Одоогоор ганц босоо тэнхлэгийн буюу Орос-Монголын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам л энэ үүргийг гүйцэтгэж байна. Тус компанийн нийт хүчин чадал нь 23 сая тонн. Өнөөдөр дээрх хүчин чадал нь дээд цэгтээ тулчихсан байгаа аж. Нөгөө талаас төмөр замын дамжин өнгөрөх чадавхийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах нь чухал байгааг ЗТБХБ-ын сайд Ц.Дашдорж ярьсан юм. Төмөр замаар дэлхийг тойрохын тулд Монголын төмөр зам сунах шаардлагатай болж байна.

Манайд зочлоорой

Бид ингэж жуулчдыг дуудах дуртай. Гэтэл манай орон нутгийн тээвэр, тэр тусмаа жуулчны тээвэрлэлтийн асуудал анхаарлын тэмдэгтэй байсаар. Хэдийгээр сүүлийн жилүүдэд уул уурхайгаас олох манай улсын орлого огцом өссөн ч жуулчдын тав тухыг хангах авто тээвэр, зам дэд бүтэц энхэл донхолтой хэвээр.

Авто тээврийн газраас жуулчны тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, жуулчид, аялагчдын баталгаатай, найдвартай зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай хэмээн үзэж байна. Жуулчин тээврийн байгууллагын жолооч нь мэргэшсэн үнэмлэхтэй, тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй байна гэж хуульд заасан байдаг аж. Хамгийн ойрын шаардлага нь энэ. Тэгвэл, энэ бэлээхэн заалтаа авто тээврийн салбарынхан, аялал жуулчлалын компани өөрсдөө мөрдөж чаддаг болов уу. Жуулчны “оргил цаг”-аар ихэнх жуулчны бааз, аяллын компанийнхан хөлсний жолооч түрээслэнэ. Жуулчны тээвэрт арваас дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг үйлчилгээнд явуулахгүй гэдэг ч байдал эсрэгээрээ байдаг.

Одоогийн байдлаар авто тээврийн үйлчилгээний гэрээтэй 40 шахам байгууллагын 500 орчим нийтийн тээврийн хэрэгсэл жуулчдад үйлчилдэг тойм тоо бий. Хамгийн эрсдэлтэй аялал гэж жуулчид үзэх ч авто тээврийн үйлчилгээг аргагүйн эрхэнд сонгож байна. Монгол орныг үзэхийн тулд, монголчуудыг танин мэдэхийн төлөө тэд ийм амь дүйсэн сонголттойнүүртулдаг. Хэдий Монгол тайван орон хэдий ч тал нутгийн зам харгуй түгшүүртэй. Аяллын компани нь хүний эрүүл мэнд, амь насыг нь дааж явах баталгаатай жолооч, найдвартай техникээр үйлчилж байгаа нь ч эргэлзээтэй. Ийм байхад яаж жуулчин хөдөөг зорьж, холын аяллаа сэтгэл амар үргэлжлүүлэх вэ. Харилцааны соёл маруухан, хэнэггүй нь дэндсэн жолоочийн атганд багтах гэж үү. Харамсалтай нь ийм жолоочид манай аяллын компаниуд жуулчнаа даатгаад мартах нь энүүхэнд.

-Аялал жуулчлалын тээврийн салбарын өнөөгийн төрх иймэрхүү. Нэг сая жуулчин хүлээн авах Төв Азийн Монгол хөсөг нүүдлийн замтайгаа тэднийг угтах уу. Ташуурдаад ч урагшаа явж өгөхгүй, хүчин чадлаа дээд цэгт нь хүртэл ашиглаж буй төмөр замын салбараа хэрхэн өөд нь татах вэ. Өчигдөр өрөвдөлтэй байсан тээврийн салбар өнөөдөр ч өр өвдмөөр хөөрхий л байна. Ганц мандаж буй нар нь агаарын тээвэр. Тэд зах зээлийн зарчмаар ажиллаж, компанийн засаглал нь сайжирч, хөрөнгө оруулалт эрж хайж байгаа учраас гялтайх зүйлтэй сууна. ■

ҮЗЭЛ БОДОЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ



Гадаад сурталчилгаа, агаарын тээврийн хурдацтай хөгжилд тулгуурласан Монголын аялал жуулчлал суурь бүтэцдээ хөрөнгө оруулагчдыг татсанаар дараагийн боломжууд гарч ирнэ.

Н.ЭРДЭНЭБАТ /Монголын аялал жуулчлалын холбооны тэргүүн/

Монголын аялал жуулчлалын салбар 2000-2011 онуудад жилийн 10 хувийн өсөлттэй явж ирлээ. Ирэх жилүүдэд дээрх өсөлтийг хоёр дахин өсгөж чадвал 2015 он гэхэд гадаадаас ирэх зорчигч 1.5 саяд, жуулчдын тоог нэг саяд хүргэн Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтоо биелүүлэх боломжтой болох юм. Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгаснаар зөвхөн 2015 онд жуулчдын тоог нэг саяд хүргээд зогсохгүй 2020 онд Монгол Улсын хүн амын тоотой тэнцэхүйц хэмжээнд аваачиж өсгөх зорилттой. Энэхүү том зорилтод хүрэхэд бидэнд ямар бэрхшээл тулгарч байгаа, бид юу хийх, юунд зорих учиртайг одоо товч тоймлохыг оролдъё.

Монголын аялал жуулчлалын холбоо нь Гадаад хэргийн яам, БОАЖЯ-тай хамтран ажиллаж, 2010 онд Японы жуулчдыг Монголд 30 хүртэл хоногийн хугацаагаар визгүй зорчуулах шийдвэрийг Засгийн газраас гаргасан. Мөн МИАТ ХК-тай хамтран Японы томоохон тур операторууд, телевиз, хэвлэл мэдээллийнхэн оролцсон FAM TOUR, PRESS TOUR-ыг зохион байгуулж, Монголыг аялж болох орон гэдэг талаас нь сурталчилсан

Авиа компани	Марк	Сүүдлын тоо	Онгоцны тоо
МИАТ ХК	BOEING767-300	262	2
Изинис Эйрвэйз	Avro RJ85	93	2
	Saab 340B	34	2
Аэромонголиа ХК	FOKKER-50	50	1
Монголиан Аэрлайнес Групп	FOKKER-50	50	2
	AIRBUS-A-319	120	2

	Одоо оруулаж буй хөрөнгө оруулалтын хэмжээ		Ирэх жилүүдэд оруулах хөрөнгийн оруулалтын хэмжээ	
Зочид Буудал	1-3 одтой	1-5 тэрбум төгрөг	1-3 одтой	5-100 тэрбум төгрөг
Жуулчны Бааз	1-2 цэцэгтэй	100 сая-1 тэрбум төгрөг	1-2 цэцэгтэй	1-100 тэрбум төгрөг

нь зохих үр дүнгээ өгснөөр 2009 онд Японоос 11.359 жуулчин ирсэн бол 2010 онд 13.450 болж 20 хувиар өссөн. Мөн өнгөрсөн онд ХБНГУ-ын Берлин хотноо болсон ITB-2011 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс Соёлын түнш орноор оролцож, аялал жуулчлалын салбарын түүхэнд анх удаа төрөөс 500 сая төгрөгийг гадаад сурталчилгаанд зарцуулсан нь Европоос ирэх жуулчдын тоог өсгөж байна. Эндээс үзэхэд бид эх орноо Төв Азид судлагдаагүй баялагтай тэдийгүй, танигдаагүй өвөрмөц соёл, унаган байгальтай орон гэдгээ уул уурхайн дайтай сурталчилж чадвал дээрх зорилтууд биелэх болно. Ингээд зогсохгүй ойрын ирээдүйд уул уурхайн ашгийг аялал жуулчлалд зориулж амжилтад хүрч буй Канад, Австрали, Чили, Малайз, Арабын орнуудын түвшинд очиж чадах юм.

Монголын Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 2010-2011 онд иргэний агаарын тээврийг либеральчлах талаар хийсэн судалгаагаар ойрын ирээдүйд агаарын тээврийг либералчилснаар нэг бус авиа компани байгуулагдаж, нислэгийн давтамж нэмэгдэн, үнэ буурч, үйлчилгээ сайжрах тухай дурдсан байв. Тэгвэл тус судалгаанд дурдагдсан агаарын тээврийн ойрын ирээдүйн зорилт нь сүүлийн хэдхэн сарын дотор шийдэгдсэн. Сүүлийн жил хүрэхгүй хугацаанд үндэсний тээвэрлэгч МИАТ ХК, “Изинис Эйрвэйз”, “Аэромонголиа” мөн шинээр

байгуулагдсан “Монголиан Эйрлайнс” групп парк шинэчлэлтээр орон нутаг, олон улсын нислэгт дээрх хүснэгтэд үзүүлсэн онгоцуудыг үйлчилгээнд ашиглаж эхэлсэн.

Ингэснээр ганцхан жилийн дотор иргэний агаарын тээвэрт даруй 1000 суудал нэмэгдэж, нислэгийн давтамж өсөж, үнэ буурлаа. Энэ бол аялал жуулчлалд бас л том боломж олгож байна.

Бид өнгөрсөн гуравдугаар сарын 23-нд болсон “Аялал жуулчлал-XXI зуун” үндэсний чуулганы үеэр тус салбарын гадаад сурталчилгаанд төрөөс зарцуулах хөрөнгийг таван тэрбумд хүргэх асуудлыг төрд санал болгосон билээ. Гадаад сурталчилгаагаа дэлхийн түвшинд хүргэж, агаарын тээврийн боломжийг ашигласнаар жуулчдын тоо өсөж, тэр хэрээр Монголын аялал жуулчлалын суурь бүтэц болох зочид буудал, жуулчныбааз,туроператоруудынашиг нэмэгдэж хамгийн гол зорилт болох гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг аялал жуулчлалын суурь бүтцэд хөрөнгө оруулах итгэл үнэмшлийг бий болгох явдал юм. Ингэснээр жуулчдад зориулсан 1-3 одтой томоохон зочид буудлууд бий болж, өнөөгийн жуулчны баазуудыг аялал жуулчлалын цогцолбор болгож хөгжүүлэх юм.

Энд мөн бүх аймгийг нийслэлтэй авто замаар холбох ажил аялал жуулчлалын салбарт том боломж олгох болно. Үүнийг шуурхай ажил хэрэг болгоход бид бас анхаарах учиртай. Гадаад сурталчилгаа, агаарын тээврийн хурдацтай хөгжилд тулгуурласан Монголын аялал жуулчлал суурь бүтэцдээ хөрөнгө оруулагчдыг татсанаар дараагийн боломжууд гарч ирнэ. Энэ нь Монгол Улсад хөдөө аж ахуйн салбараас мах, ноос, ноолуур, чацаргана зэргийг кластерийн хэмжээнд хөгжүүлж, түүнийг аялал жуулчлалтай холбон био, органик бүтээгдэхүүнүүд бүхий онгон байгальтай, нүүдэлчдийн өвөрмөц соёлыг орчин үетэй зөв хослуулсан шинэ монгол брэндийг дэлхийн аялал жуулчлалын тавцанд нэр хүндтэйгээр гаргаж чадна.

Энэхүү бидний зайлшгүй бүтээх учиртай зорилтыг биелүүлэхэд хууль тогтоогчид, гүйцэтгэх засаглал, хэвлэл мэдээллийнхэн, үйлдвэрлэгчид аялал жуулчлалын салбартай уялдаа холбоотойалсыгхарсанбодлоготойгоор хамтран ажиллах шаардлагатай байна. ■



ХӨГЖИЛ

БИД ӨСӨЛТИЙГ ХӨГЖИЛ ГЭЖ АНДУУРААД БАЙНА. ХӨГЖИЛ НЬ БИДНИЙ ӨӨРСДИЙН УГ ҮНДЭС ДЭЭР ЦЭЦЭГЛЭХИЙГ ХЭЛДЭГ ЮМ



Фотог Э.Зоригт

Өнөөдөр биднийг үзэл бодол, хүн чанар биш, ердөө л уул уурхай нэгтгэж байна. Хэрвээ уул уурхайн баялаг дуусвал яах вэ. Тэр судлаачид яг манайх шиг байдлыг Нигери улсад ажигласан байна. Тэнд нефть л тухайн улсын оршин тогтнох эх үүсвэр болж, нефть дагаж улс төр, эдийн засаг тэр ч бүү хэл, сонгууль нь явагддаг байна.

Д.БЭХЭЭ

УИХ-ын гишүүн Д.Энхбаттай ярилцлаа. УИХ-д нэр дэвшихийн төлөө улайран тэмцэлдэж буй үед тэрбээр нэр дэвшихээс татгалзсан юм. Намынхаа жагсаалтын хувьд С.Оюун гишүүний дараа хоёрт бичигдэж, мөн УИХ-д дахин сонгогдох магадлал өндөр байсан Энхбат гишүүн нэрээ татсаны учир юу юм бол.

Нөгөөтэйгүүр миний бие түүнийг улстөрд орохоос өмнө олонтаа ярилцлага хийж байлаа. Улс орны хөгжил дэвшил, шинэ санаа оноо, мэдээллийн технологийн талаар бидний ярилцлагын сэдэв өрнөдөг байсан бол түүний суулийн дөрвөн жилд сонин хэвлэлд өгсөн ярилцлага нь тулхүү улс төр, намын тухай ярьжээ. Энэ удаа түүний улс орны хөгжлийн төлөө юу бодож явдаг талаар голлон сонирхохыг хичээлээ. Төрийн ордонд дөрвөн жил суусан УИХ-ын гишүүн Д.Энхбат "Монголчууд хуурамч багаа хуулж хаясан цагт хөгжил ирнэ" хэмээн ярьлаа.

Монгол хүн гэж хэн бэ гэдгээ мэдэхгүй хямрах аюултай тулах вий

-Өнөөдөр манай улс хөгжлийн гараан дээр ирчихээд байна. Хурдацтай хөгжих үү, эсвэл ангал руу унах уу. Сонголт бидний өмнө байна. Таны бодлыг сонсъё?

-Өнөөдөр манайд оршин буй төр, ардчилал гээд бүх зүйл нь хүнийх байна. Гаднын улс төр, тэр ч бүү хэл хүмүүс хоорондын маргааныг ажиглахад соёлын ялгаа ихэд харагддаг. Товчхон хэлэхэд, хөгжил мөнгөний, эдийн засгийн ч асуудал биш. Гаднын орнууд өөрсдийн уг үндэс, ёс заншил дээр тулгуурлаж хөгжиж буй болохоос биш, уул уурхайгаас гэнэт мөнгөтэй болоод хөгжчихсөн юм байхгүй. Өнөөдөр Африкын улсуудад 100 тэрбум ам.доллар өгөөд ч хөгжихгүй. Учир нь, тэр улс орнуудын төр, шүүх засаглал, хууль гээд бүх зүйл нь хүнийх. Тэгэхээр хөгжлийн талаарх миний дүгнэлт бол хэлбэр, агуулга хоёр давхардаж, өөрийн соёл дээр тулгуурласан тэр үед л хөгжил ирнэ. Гэхдээ би хөгжилд уул уурхай, эдийн засаг, мөнгө чухал бус гэж хэлэх гэсэнгүй. Харин уул уурхай, эдийн засгийн өсөлтийг даваад харвал нийгмийн асуудал байгаа. Тэр нийгмийн асуудлын цаана нөгөө соёл иргэншил бий. Тэгэхээр соёл иргэншил хэмээх уг гарвалаа мэдэхгүй бол бид хэзээ ч хөгжихгүй.

Өнөөдөр улс төр, эдийн засгаараа хямрахаас илүүтэй монгол хүн гэж хэн бэ гэдгээ мэдэхгүй байх том хямралтай нүүр тулах вий. Бид яг юу хүсэж буйгаа хэлж чадах хүн өнөөдөр ховор. Алисиа гайхамшгийн оронд гэдэг кино байдаг даа. Тэр кинонд Алисиа найзуудтайгаа явж байгаад зам дээр нэг хүнтэй таарч энэ зам хаашаа хүрэх вэ гэж асуудаг. Нөгөө үл таних хүн чи хаашаа явж байгаа юм бэ гэхэд Алисиа мэдэхгүй гэнэ. Нөгөө хүн тэгвэл энэ зам хаашаа явах нь танд ямар хамаатай юм бэ гэж хариулдаг. Яг л үүнтэй адилхан монголчууд бид хаашаа явж байгаагаа мэдэхгүй бол энэ зам хаашаа явах нь ямар хамаатай юм бэ. Ийм нөхцөл замбараагүй байдлыг үүсгэдэг.

-Уул уурхай, эдийн засгаас илүү Монгол Улс, монгол хүн гэдэг мөн чанараа ярих нь чухал гэсэн үг үү?

-Бид өнөөдөр уул уурхай, эдийн засаг их ярьж байна. Харин өөрсдийн мөн чанараа яагаад ярихгүй байна вэ. Хөгжихийн тулд үүнийг л ярих хэрэгтэй. Чи гараад захын монгол хүнээс амьдрал ямар байна вэ гэхэд өө сайхан болж байна гэдэг. Харин дотны найзтайгаа цай уугаад суухаараа өө ёстой хэрэг алга, бараг л үхмээр байна гэнэ. Ийм л худлаа царайлж байна ш дээ.

Улс төрийг аваад үзье. Монгол ардын нам гэж юу гэсэн үг вэ. Толь бичиг бариад харсан ч болно, ард гэдэг үгийг. Тэнд эд хөрөнгөгүй, угсаа гаралгүй хүнийг ард гэнэ гэсэн байгаа. Тэгвэл МАН харц ардын нам байх ёстой болж байна аа даа. Тэгвэл өнөөдөр ямар нам билээ. Бас нэг жишээ дурдахад монголчууд их савладаг ард түмэн. Намайг Статистикийн үндэсний хороонд ажиллаж байхад манай нэг найз саалийн хэдэн үнээтэй болж, сүүгээ зарж мөнгөө цуглуулаад машин авч уналаа. Тэгсэн хувийн өмчтэй боллоо гээд найзыг маань намаас хөөсөн.

Харин өнөөдөр бүгдээрээ зах зээлд орчихсон явна. Урьд нь нийтийн юмыг л дээдэлдэг байсан бол өнөөдөр нийгмийн, нийтийн эд хөрөнгийг юман чинээ бодохгүй байна. Бүгдийг л хувьчлах бодлого явуулж ирлээ. Хууль нь хүртэл тийм байна. Тухайлбал, танай нутгийн гол хордчихлоо. Шүүх танаас “Та өөрөө хордсон уу” гэж асууна. Хэрвээ хордоогүй бол шүүх таныг хохирогч биш гэж үзээд хэргийг авч хэлэлцэхгүй. Та хохироогүй л бол шүүхээр явах эрх байхгүй гэсэн үг. Тэгвэл бидэнд Туул гол ширгэх, Богд уул түймэрт автах хамаагүй юм байна л даа. Эндээс харахад хамтын, нийтийн эрх ашиг гэх зүйл алга. Энэ нийгэмд амиа л бодвол тэргүүний мундаг хүн юм байх. Бид ийм байдлаар савлаж байна. Хамгийн аймаар нь өөрийн үзэл бодолгүй хүмүүс ингэж савладаг юм.

-Тэгвэл Монгол Улс өөрчлөгдөхийн тулд энэ бүх хуурамч байдлаасаа л гарах хэрэгтэй юм байна. Хэрхэн яаж энэ хуурамч зангаа хаях вэ. Юунаас болоод алхам тутамдаа ийм хуурамч зан гаргаад байгаа гэж Та бодож байна вэ?

-Хоёр шалтгаан байх шиг байна. Эхнийх нь бид өөрсдөө хуурамч байгаагаа мэдэхгүй явна. Социализмын үеэс л хуурамч амьдарсаар сурчихаж. Тухайлбал, чи нэг машинтай болох гэтэл коммунист үзэл суртлаар болж чаддаггүй. Тэгэхлээр хуурамч дүр эсгэж эхэлнэ. Ингэж явсаар өөрийн мэдэлгүй хуурамч амьдралд сурчихсан хэрэг. Угтаа монгол хүний төрөлх мөн чанар юу билээ. Билэг танхай, дуу шуутай хүмүүс.

Нэг жишээ дурдахад, япончууд хүүхдээ билэг танхай болгох гэж яаж ч хичээгээд чадахгүй. Тэдний цаад ясанд нь биднээс өөр бүрэг, даруу зан байдаг. Харин монгол хүн эсрэгээрээ. Гэтэл монголчууд хүүхдүүдээ япон хүүхдүүд шиг болгох гээд зүтгэдэг. Монголчуудыг яаж ч даруухан болгох гээд чадахгүй. Тэгэхээр монголчуудад зориулсан арга барил хэрэгтэй байна. Монголчууд шиг дураараа хэрэлддэг хүмүүст зориулсан хурлын арга хэрэгтэй гэсэн үг. Энэ бол муу зүйл ерөөсөө биш. Хүн дураараа билэг танхай байх нь орчин үеийн хэллэгээр лидер, манлайлагч хүний хамгийн том араншин шүү дээ.

Гэхдээ үүндээр нэмээд боловсрол, хувь хүний соёл байх хэрэгтэй. Яг л үүн шиг жирийн иргэнээсээ аваад төр хүртлээ өөрийнхөө төрөлх мөн чанар дээр суурилж аливаа нийгмийн үе шатуудыг өөрийн оронд зохицуулан бүтээж чадвал бид өөрийнхөөрөө хөгжиж, хөгжлийн шинэ шатанд гарч ирж чадна. Харин одоо бид хурал дээр герман маягаар үг хэлж, гэртээ монгол хэлбэрээр амьдарч байна. Хэлбэр, агуулга нь энэ мэт зөрөөд буй үед хэзээ ч мөнгө тус болохгүй. Дэмий үрээд л дуусна. Тиймээс өөрсдийнхөөрөө байж чадах тэр орчин л бидний хуурамч байдлыг алга болгох учиртай.

Бид хурал дээр герман маягаар үг хэлж, гэртээ монгол хэлбэрээр амьдарч байна

-Тэгвэл хэлбэр, агуулга хоёр хэзээ зөв голдиролд орох вэ?

-Өнөөдөр бүгд уул уурхай ярих эсвэл бүгд алт ухах хэрэггүй. Монгол Улсын Ерөнхийлөгч, дээд давхаргын тэр сэхээтнүүд л өөрийн төрөлх мөн чанартаа ойртох хэрэгтэй. Алт ухах нь ухаг хамаагүй. Харин Ерөнхийлөгч нь уурхайчин байх хэрэггүй. Хэрвээ Ерөнхийлөгч уурхай яриад уурхайчин болчихвол Монгол Улс хөгжиж эс чадна.

-Өсөлт хөгжил мөн үү?

-Бид өсөлтийг хөгжил гэж андуураад байна. Хөгжил нь бидний өөрсдийн уг үндэс дээр цэцэглэхийг хэлдэг юм. Хоёр сар гарны өмнө Швед улсын хэдэн судлаач манайд судалгаа хийгээд буцлаа. Тэд манай залуучуудтай уулзаад их сонин зүйл надад хэлсэн. Танай орны ихэнх залууст шударга зан, үндэсний соёл, ажилсаг байх талаар нэгдсэн ойлголт алга. Танай залуучууд том дарга таньдаг эсэх, ганган хувцас, унасан машинаараа хуваагдчихсан байна. Түүнээс биш, үзэл бодлоороо хуваагдсан нь цөөхөн. Энэ юуг харуулаад байна гэхээр бид өөр хоорондоо хэрэглээгээрээ ялгараад байгаа болохоос биш хүн чанараараа ялгарч чадахгүй байгаагийн илрэл юм.

Мөн судалгааны явцад манай залуучуудын хувьд секс бол хайр дурлал, харилцаа огт биш гэж гарсан байна. Зүгээр л хэрэглээ болчихож гэсэн үг. Яг үүнийгээ дагаад улс төрийн намууд мөн адил үзэл бодлоороо бус хэрэглээгээрээ л сэтгэдэг болчихсон. Хаана очвол дарга болох вэ л гэж бодно. Эцэст нь Шведийн судлаачид энэ бол танай улсын сүйрэл гэсэн. Өнөөдөр биднийг үзэл бодол, хүн чанар биш, ердөө л уул уурхай нэгтгэж байна. Хэрвээ уул уурхайн баялаг дуусвал яах вэ. Тэр судлаачид яг манайх шиг байдлыг Нигери улсад ажигласан байна. Тэнд нефть л тухайн улсын оршин тогтнох эх үүсвэр болж, нефть дагаж улс төр, эдийн засаг тэр ч бүү хэл, сонгууль нь явагддаг байна. Тэгвэл манай орон өнөөдөр Нигериэс юугаараа ялгаатай юм бэ. Уул уурхайг л дээр, доргүй ярьж байна шүү дээ.

-Тэгвэл бид сүйрэл рүү гээ яваад байгаа хэрэг үү?

-Өнөөдөр өнгөцхөн харахад бид бүгдээрээ гар утастай, машинтай байна. Энэ бол XXI зууны гайхамшиг. Энэ зууны XI зуунаас ялгагдах онцлог нь хүмүүс турж биш таргалж сүйрдэгт байгаа юм. Швед эрдэмтдийн хэлснээр энэ зуунд улс гүрэн мөнгө дутаж биш, мөнгө нь илүүдэж сүйрдэг болжээ. Энэ үнэн. Харин манайхан үүнийгээ

Энэ зууны XI зуунаас ялгагдах онцлог нь хүмүүс турж биш таргалж сүйрдэгт байгаа юм. Швед эрдэмтдийн хэлснээр энэ зуунд улс гүрэн мөнгө дутаж биш, мөнгө нь илүүдэж сүйрдэг болжээ.

хөгжил гэж нэрлээд байгаа юм. Бид хөгжлийг хүртэл хэрэглээгээр дүгнэж байна. Хөгжлийг буруу гаргалгаагаар авч үзээд байвал нөгөө тал нь юу байх вэ. Тэр бол сүйрэл. Хөгжлийн гаргалгаагаа мэдэхгүй бол бид мөнгөө хэрэглээндээ зарцуулсаар яваад таргалж сүйрнэ. Хөгжлийг хөдөлгөгч нь мөнгө биш.

Хүмүүс намайг уул уурхай, эдийн засгийн өсөлтийн эсрэг нөхөр байна гэж бодож магадгүй. Миний хувьд эсрэг зүйл огт яриагүй. Харин ч эсрэгээрээ уул уурхайд баярлаж, мөнгө эдийн засагт их байгаасай гэж хүсдэг. Уул уурхайн хөгжилд баярлалаа гэсний шалтгаан нь бид эндээс мөнгөтэй болж, хөгжлийн талаар ярьж эхлээд байгаа явдал юм. Хэрвээ мөнгөтэй болоогүй бол хөгжлийн талаар яриа ч уу, үгүй ч үү.

-Жинхэнэ хөгжил өөрсдийн мөн чанар, соёл дээр тулгуурласан тэр зүйлийг л хэлэх ажээ. Харин хөгжлийн талаар нэгдсэн зөв ойлголттой байж чадаж байна уу гэдэг бас нэг асуудал юм биш үү?

-Энэ талаарх нэгдсэн нэг ойлголт чухал. Германчууд Монгол Улсад боловсролын чиглэлээр хэдэн жил дараалан хурал зөвлөлгөөн зохион байгуулжээ. Тэгээд бүр сүүлдээ хийсэн ажил нь нурахад хүрч. Гэтэл дөрвөн жилийн дараа нэг герман эрдэмтэн монголчууд яагаад хэл амаа ололцохгүй, хэрэлддэгийг ойлгосон гэнэ. Манайхан боловсролыг өөр өөрийнхөөрөө ойлгоод байдаг. Зарим нь боловсрол гэдгийг математик гэж ойлгодог бол нөгөө нь шударга, хүмүүжилтэй байх гэж бодох жишээтэй. Товчхондоо бид боловсрол гэж юу хэлдгийг мэдэхгүй, хар ухаанаар л ойлгодог шүү дээ.

Харин Германд аль эрт XVII зуунаас энэ талын нэгдсэн ойлголттой болчихсон ард түмэн. Бүх зүйл дээр герман хүн бүр яг л нэг тодорхойлолт хэлдэг, түүнийхээ дагуу маргадаг, хэлэлцдэг арга зам хайдаг. Монголд нэг хурал боллоо. Зааланд хорин монгол хүн байлаа гэхэд бүгдээрээ өөр өөр зүйл ярьж эхэлнэ. Үүний учир нь 200 гаруй жил манай улс Манжийн нэг хэсэг байсан, 80 гаруй жил Оросын хэсэг болсон. Тэр үед манжууд, эсвэл оросууд боловсролыг гэдгээ нэгдсэн нэг ойлголтоор мэддэг байсан байх. Харин манайд зүгээр л даалгавар өгчихдөг. Бид юу хийгээд байгаагаа мэдэхгүй дагаад л хийчихдэг байсан шүү дээ. Тэгэхээр бид өөрийн гэсэн нэгдсэн нэг ойлголт тодорхойлолтгүй бол юу ч хийгээд хөгжихгүй.

-Монголчуудын дунд ойлголтын зөрүү их байна. Ойлголтоо нэгтгэж байж хөгжих нь бас тодорхой юм. Яагаад ийм байдалд хүрчихэв ээ?

-Хэрэглээний нийгмийн аюул энэ юм. Өнөөдөр уул уурхай гэж юу



Д.Энхбат Монголын бэлчээрийн менежментийн холбоо, МҮОНТелевизтэй хамтран зохион байгуулсан "Ногоон аялал-2011"-д оролцсон юм. УБ-Өвөрхангай-Баянхонгор-Завхан-Архангай-УБ маршрутаар найм хоногт 2800 км зам туулсан аялал болсон аж.

хэлдгийг ч мэдэхгүй байна шүү дээ.

-Таны хэлдгээр мөн чанар руугаа ойртоод гэдэг ч юм уу сүүлийн үед улс орнууд байгаль дэлхийд ээлтэй органик, ногоон хөгжлийн тийш яваад хэдийнэ эхэлжээ.

-НҮБ-аас гаргасан хүний хөгжлийн 10 индексийн тав нь байгаль орчных байдаг. Яг үүнтэй адилхан соёл иргэншлийн тэн хагас нь байгалийн хуулиар явна. Хүн өөрөө байгалийн нэг хэсэг учраас тэр. Тиймээс ногоон хөгжил нь шинэ зүйл огт биш. Ирээдүйд манай уул уурхай тойрсон олон хот, бүтээн байгуулалт бий болно. Харин тэр үед бид тогтвортой хөгжлийг бий болгож чадаагүй бол миний тооцоолсноор 50 гаруй жилийн дараа Монгол Улс 200 орчим Налайх шиг хоттой л хоцорно.

Нэг бодит жишээ дурдахад Чойр хот руу явах замд орос цэргүүдийн амьдардаг үнэхээр тансаг хотхон байсныг мэдэх юм. Тэр хотхоны орос оршин суугчид хэрвээ нутаг буцвал монголчуудад амьдрах сайхан хот үлдэх нь дээ гэж боддог байлаа. Тэгсэн оросууд нутаг буцсан, тэр хотхон өдгөө балгас болсон. Учир нь, тэр хотхон тогтвортой хөгжлийг бий болгож чадаагүй хэрэг. Үүнтэй адилхан одоо ашиглаж буй уул уурхайн баялаг дуусахад дэргэд нь байсан зүйлс яах вэ. Үүнийг бид бодох хэрэгтэй. Тухайлбал, уул уурхай руу тавьж байгаа зам, өндөр хүчдэлийн шугам одоо зайлшгүй хэрэгтэй ч тэр уурхайн ашиглалт зогсвол эдгээр бүтээн байгуулалт юу ч биш болно. Үүнийг эртнээс тооцож, ирээдүйд хэнд ч хэрэггүй "хог" болохооргүй бүтээн байгуулалт хийх хэрэгтэй. Улс орны хөгжил эндээс л эхэлнэ.

Бид дэлхийн ердөө л нэг хэсэг. Тиймээс анхнаасаа аливаа зүйлийг хийхдээ зөв системтэй хийх хэрэгтэй. Тэр дундаа байгалийнхаа системтэй уялдаж чадвал алдаа бага гарна. Энэ бол Ерөнхий сайд асан Бямбасүрэн гуайн хэлдэгчлэн даацтай хөгжил юм. Манайхны томъёолж буйгаар тогтвортой, ногоон хөгжил. Байгалийн системтэй уялдсан бодлого явуулдаг, алдахаасаа өмнө арга хэмжээ авахыг зорьж буй улс төрийн хүчнийг Ногоон нам гэдэг. Харин тухайн үед нь л учрыг нь олох талаар боддог бол тэр өөр нам юм. Ялгаа нь ердөө л энэ.

-Өнөөдөр ногоон хөгжил гаднын орнуудын хувьд нэн тэргүүний чухал асуудал болсон байна. Аливаа орны улс төрийн болоод бусад бодлогын нэн түрүүнд ногоон үзэл баримтлал явж байна. Харин манай улсын ногоон бодлого хаана явна вэ?

-Миний бодлоор одоо байгаа дутагдлаа давуу тал болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, бид сохорсон биш, завшив гэдэг шиг хоцрогдсон бус азтай ард түмэн. Биднээс өмнө гаднын олон орон уул уурхай гээд баларсан түүх олон. Бидэнд тийм гашуун туршлагыг заавал амсах хэрэг алга. Бусдын алдаанаас суралцах хэрэгтэй. Өнөөдөр мэдээлэл, даяаршил бүх зүйл байна. Ийм сайхан нийгэмд амьдарч байж хүний унасан нүхэнд уначихаад аан энэ үнэхээр аймаар нүх байна шүү гэж мэдэх хэрэггүй биз дээ.

Бид ногоон хөгжлийн талаар ярьж байгаа нь ногоо тариад амьдралаа залгуулдаг жирийн иргэнд ойлгогдохгүй байж болно. Харин манлайлагч хүний хувьд ойлгох хэрэгтэй. Манлайлагч хүн усан онгоц хоёр метрийн цаана мөсөн уултай мөргөлдөж магадгүй гэдгийг урьдчилан харах чадвартай байх ёстой. Ингэж харж чадвал усан онгоцны залуурыг өөр тийш залж болно. Тэгвэл тэр залах чиг нь л өнөөдөр ногоон болсон хэрэг. Хэрвээ ногооноос өөр зүг залвал онгоц мөсөн уултай мөргөлдөх юм гэдгийг дэлхий дахинаа ухаарсан байна.

Манайхны хувьд хүн хэлэхээс нааш ухаардаггүй гэдэг үг байдаг шүү дээ. Хэлэх л хэрэгтэй. Яах вэ, урьд нь олж хараагүй юу гэвэл хараагүй. Харин өнөөдөр олж харах чадвартай олон хүн бидний дунд байна. Тэдэнд л хэлж ойлгуулах хэрэгтэй. Тийм учраас л танай сэтгүүлээс үлгэр дуурайлал авч хэвлэл мэдээллийн энэ олон хэрэгсэл ногоон хөгжлийн талаар бичих, ярих шаардлагатай байна.

-Таны хэлдгээр манлайлагчид ногоон хөгжлийг хамгийн түрүүнд ухаарах хэрэгтэй байна л даа. Дээрээс нь хүмүүс өөр хоорондоо тэдийгүй улс гүрнүүд хүртэл хамтран нэгдэж энэ хөгжлийг бий болгох талаар их ярьдаг болж.

Миний тооцоолсноор 50 гаруй жилийн дараа Монгол Улс 200 орчим Налайх шиг хоттой л хоцорно

-Энэ зөв. Гэхдээ эхлээд өөрсдийнхөө нүдийг нээх хэрэгтэй. Өнөөдөр бидэнд уул уурхай л харагдаад байна. Харин уул уурхайг даваад харвал цаана нь ногоон хөгжил байгаа. Нэг ийм үг байдаг. Хэрвээ чи буруу замаар яваа бол хурдан удааны ялгаа юу байгаа юм бэ гэж.

Тиймээс буруу замаар хэт хурдан явбал өндөр эрсдэл өмнө хүлээж байна. Яг үүнтэй адил механик өсөлт ч эрсдэл дагуулдаг.

-Сүүлийн үед шинэ хөгжил, шинэ эдийн засгийн талаар ярьж байна. Энэ чухам ямар ойлголт вэ?

-Хүмүүс ялгаа л гаргахын тулд шинэ нэр томъёо өгдөг болов уу. Түүнээс биш, огт байхгүй зүйлийг бий болгочихдог юм биш. Тухайлбал, Таталцлын хуулийг Ньютон нээхээс өмнө бид мэдээгүй байсан. Гэхдээ Таталцлын хууль оршин байж л байсан шүү дээ. Түүнээс биш Ньютон уг хуулийг шинээр бий болгоогүй харин нээсэн. Яг л үүнтэй адилхан шинэ эдийн засаг гэдэг байсан л зүйл. Одоо байгаа зүйлийн сайн тал ч байж магадгүй.

Угаас хорвоо дэлхий дээр сайн, муу хоёр тэнцүү буй учраас л хүн төрөлхтөн оршин байгаа. Түүнээс биш, муу тал нь ялчихсан бол өдийд бид оршин байхгүй. Бид уул уурхайг муу хэлээд байна. Гэхдээ энэ олон уурхайн дунд усаа гамнадаг, аль болох байгальд хор уршиг бага тарих талаар хичээдэг нэг хэсэг бас бий. Харин бид энэ сайн талыг нь л улам олон болгох хэрэгтэй. Эндээс эргээд ойлголтын зөрүү гэдэг дээр буцаад очих хэрэг гарч байна. Одоо байгаагаас илүү сайхан зам байдаг юм аа гэдэг ойлголтыг хүмүүст суулгаад өгвөл тэд энэ зүг рүү явах нь тодорхой. Тиймээс ногоон хөгжил, шинэ эдийн засаг ч бай одоогийнхоос илүү сайхан шинэ зам бий болгоод энэ нь үнэхээр сайнд хүрэх зам мөн гэдэг ойлголтыг л бүгдэд төрүүлэх нь чухал.

-Та өнгөрсөн дөрвөн жил УИХ-д ажиллалаа. Чухам юу ойлгосон бэ?

-Би нэг л зүйлийг үнэхээр сайн ойлголоо. Сүүлийн 20-иод жил монголчууд зах зээл, эдийн засаг, ардчилал, эрх чөлөө гээд олон зүйлийг ойлгохын төлөө явсан. Үүнийгээ дагаад өөрчлөгдөж, тодорхой хэмжээнд хөгжсөн. Харин ганцхан зүйл л өөрчлөгдөөгүй үлджээ.Тэр нь улс төрийн намууд. Социалист дэглэмийг үндэслэсэн Ленин гэдэг нөхрийн бий болгосон тэр улс төрийн систем өнөөдрийн манай улс төрд явсаар л байна. Өнөөдөр хэлж мэдэхгүй ч дотроо хамгийн хэрэггүй зүйл бол улс төр гэж боддог болчихсон байгаа. XXI зуун гарчихаад байхад өнгөрсөн зууныхаараа оршин буй улс төр Монгол Улсад өнөөдөр яваад байна.

Сул мөнгө тэдэнд морфин тасралтгүй тариад байна л даа. Тэд морфиноор амьдраад байна гэсэн үг. Тэгээд түүнээсээ гарч чадахгүй байгаа юм. Угаасаа мансууруулах зүйлд донтсон хүн гарах хэцүү байдаг гэдэг шүү дээ. Яг л үүнтэй адил юм.

-Тэгвэл манай нам, улс төрийн хүчнүүд яагаад өөрчлөгдөж, хөгжихгүй байна вэ?

-Сул мөнгө тэдэнд морфин тасралтгүй тариад байна л даа. Тэд морфиноор амьдраад байна гэсэн үг. Тэгээд түүнээсээ гарч чадахгүй байгаа юм. Угаасаа мансууруулах зүйлд донтсон хүн гарах хэцүү байдаг гэдэг шүү дээ. Яг л үүнтэй адил юм.

-Тэгвэл энэ мансуурлаас яаж гарах вэ?

-Маш том улс төрийн шинэчлэл хийх ёстой. Үүний тулд хамгийн түрүүнд намыг улс төрийн хэдэн дарга нарын биш гишүүдийн, олон нийтийн байгууллага болгох хэрэгтэй. Намууд олон гишүүнтэй л гэж байна. Гэвч тэдний үүрэг юу вэ. Өнөөдөр гишүүд зүгээр л тоо төдий болчихсон. Ийм зүйл ярихаар хүмүүс улс төр гээд байж магадгүй юм. Яг үнэндээ энэ чинь улс орныг авч явах уураг тархины зохион байгуулалт. Харин өнөөдөр биднийг авч явах уураг тархи сонгуульд ялахын тулд л эдийн засгийн бодлого явуулж байна. Ийм нөхцөлд хэзээ ч бодит үр дүн гарахгүй. Эндээс эргээд л миний ярилцлагын эхэнд хэлсэн хуурамч байна гэдэг дээр очно. Чехийн Ерөнхийлөгч асан Бацелавь Хавель хэлэхдээ “Улс орноо шинэчлэх тухай ярихын тулд эхлээд бүгд хуурамч байхаа л болих хэрэгтэй. Бусад нь бүгд бидэнд бий” гэсэн байдаг. Бидэнд үнэхээр л бүх зүйл байна. Хуурамч байгаагаасаа болоод л бүх зүйл худлаа болоод байгаа юм.

-Бусад улс орны Ногоон намууд хариуцлагатай, өөрийн гэсэн өндөр үүрэг хүлээсэн байдаг нь ажиглагддаг. Тухайлбал, Германы Ногоон нам ногоон хөгжлийн төлөө тун хариуцлагатай ажилладаг юм билээ. Харин танай намын тухайд хэр байна вэ?

-Германы ганцхан жишээг хэлье. Германы Ногоон намын зохион байгуулалт хариуцсан баг манайд хоёр удаа ирж, нам ямар байх талаар манай гишүүдэд хичээл заасан. Гэтэл намын гишүүд маань сэтгэлээр бүр уначихсан. Бидний мэдэхээс шал өөр зүйлийг нам гэж хэлдгийг ойлгосон болохоор тэр. Заримдаа нь их энгийн. Германы Ногоон нам жилд хоёр удаа хурлаа хийдэг бол манайх дөрвөн жилд ганц удаа хийдэг. Германы Ногоон намын их хуралд намын бүх гишүүн тэр ч бүү хэл нам бус хүн ч орж болно. Би нэг удаа тэр хурал дээр нь очсон л доо. Гишүүд нь бүр эхнэр, хүүхэдтэйгээ ирчихсэн, гадаах талбайдаа мах шараад л. Энэ бол хэлбэр тал нь. Харин агуулга нь тэр хурлаар намын бүх гишүүний саналыг нэгтгэж, дүгнээд Парламентад буй гишүүддээ төрийн бодлого гаргахад

нь нөлөөлөх үүднээс хүргүүлдэг.

Хамгийн сонирхолтой нь Та Ногоон намын гишүүн биш байж болно. Магадгүй Ардын намын гишүүн байлаа гэхэд Та манай намын гишүүдээс өөрийгөө дэмжсэн 40 гаруй хүний гарын үсэг зуруулж чадвал манай намын хурал дээр илтгэл тавих эрхтэй. Тухайн илтгэлд дурдагдсан санаа үнэхээр зөв бол намын бодлого болгоод ч явж болно. Эндээс нам бол төрийн эрхийг барих цөөнхийн бүлэглэл биш гэдэг тодорхой болж байна. Нам бол иргэдийн төрд оролцох гүүрийн үүрэг гүйцэтгэгч. Ленины тодорхойлсноор нам төрийн эрхийг барих цөөнхийн бүлэглэл гэх хоцрогдсон ойлголт өдгөө үеэ өнгөрөөжээ.

Дээрээс нь Германд сонгууль их энгийн зарчмаар явдаг. Та намын бодлогыг дэмждэг бол тодорхой хэмжээний татвар төлнө. Харин нам таны сонгуулийн бүх зардлыг даах учиртай. Яагаад гэвэл сонгууль мөнгө биш. Иймээс нам хамгийн итгэлтэй, нэр хүндтэй гишүүнээ сонгуульд нэр дэвшүүлдэг. Харин манайд эсрэгээрээ шүү дээ. Мөнгөтэй нь л сонгуульд нэр дэвшдэг. Ингээд ирэхээр төрд цөөнхийн бүлэглэл үүсдэг юм байна.

-Та өнгөрсөн дөрвөн жилд Парламентад сууснаараа ямар ажил амжуулсан бэ?

-Би их зүйл хийсэн. Ногоон намыг анх удаа Парламентийн нам болголоо. Иргэний зориг-Ногоон намыг байгууллаа. УИХ дотор ногоон хөгжлийн талаар их ярьдаг боллоо. Ногоон гэдэг чинь байгаль хамгаалсан хэдэн нөхөр гадаа жагсахыг хэлдэггүй, харин улс төрийн маш том асуудал гэдгийг хүмүүс ухаарлаа. Энэ бол сайн мэдээ. УИХ-ын зарим гишүүн нэг хурал дээр ногооныг цэцэг тарьдаг хүмүүсийн холбоо гэж ярьдаг байсан. Тэгвэл одоо улс төрийн том хүчин болж байх шиг байна гэсэн юм. Үнэхээр тийм юм.

-Таныг Монголд интернэтийг үүсгэн байгуулсан эцэг гэдэг. Мөн өнөөдөр Twitter-ээр ч Монголдоо "байлдан дагуулагч" гэж ярьж байна.Таныг хэчнээн Twitter-чид дагаж байна вэ?

-Одоогоор 15 мянга гаруй хүн байх шиг байна. Гэхдээ сүүлийн 10 гаруй хоног нэг ч удаа Twitter-т орсонгүй. Энэ нь хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, хүмүүс улс төр ярихаар дургүйцээд байна. Хоёрдугаарт, намын даргын хувьд өөрийн байр сууриа Twitter-ээр хэлж болохгүй байна. Тэгэхээр би гадаа бороо орж байна гээд бичээд байлтай биш. Дээрээс нь өнөөдөр манайд Twitter арай буруу хөгжөөд байна. Уг нь Twitter бол чат биш ямар мэдээлэл хаана болж байгаа талаарх дохио юм. Гэтэл хоёр хүний хоорондын чат болчихож. Гэхдээ энэ энгийн үзэгдэл л дээ.

-Та тэгвэл facebook-ээр хэр зэрэг зочилдог вэ?

-Facebook-ийг сонирхож үзсэн.

Хэрвээ бид интернэтийг далайтай зүйрлэх аваас бидний дунд далайчин хүн алга. Далайн эрэг дээр нар өөд саравчлан харж зогсоо хүмүүс байна. Далайчин болохын тулд ядаж нэг модон завинд суугаад далай руу орох хэрэгтэй шүү дээ.

Гэхдээ тэнд юмны учрыг олох гэсэн бус маш олон янз бүрийн юм сонирхсон хүмүүсийн нэгдэл байсан. Тиймээс Facebook-ийг ажлын талбар биш гэж үзэх болсон. Магадгүй ирээдүйд энэ хандлага өөрчлөгдөх байх аа.

-Монгол Улсын мэдээллийн технологи, интернэтийн хөгжлийг та өдгөө хэрхэн дүгнэж байна вэ?

-Мэдээллийн технологийн талаар миний бодол тийм ч сайн биш байгаа. Адаглаад цахим хуудас руу ороход тэнд ердөө л сонины хуулбар байх. Уг нь интернэт нь задгай далай юм. Чи юу ч хийж болно. Өөрийн дураар. Сонинг аваад үзэхэд хэдийгээр мэдээллийг чөлөөтэй нийтэлдэг ч Эрхлэгчийнхээ зөвшөөрөлгүй ямар нэг мэдээ нийтлэх эрх сэтгүүлчид байхгүй. Энэ нь нэг талаараа хувьчлагдчихсан орон зай гэсэн үг. Харин интернэт бол өөр. Манайхан энэ талаар сайн мэдэхгүй байх шиг. Интернэтийг зүгээр л сонинг цахим хэлбэрээр унших хэрэгсэл гэж ойлгоод байна. Яваандаа энэ байдал өөрчлөгдөх болов уу.

Дээрээс нь бид уншихыг хүсдэг ч бичдэггүй. Энэ нь нэг талаар бидний соёлтой холбоотой. Манай ард түмэн аман соёл ихтэй харин бичгийн соёл бага. Би хувьдаа блог хөтөлдөг. Учир нь би интернэтийг хэлбэр бус мөн чанар гэж боддог учраас тэр. Би тэнд өөрийнхөөрөө байж, өөрийнхөө үргэлжлэлийг тэнд үлдээж чаддаг. Хэрвээ интернэтийг далайтай зүйрлэх аваас бидний дунд далайчин хүн алга. Далайн эрэг дээр нар өөд саравчлан харж зогсоо хэдэн хүн л байна. Далайчин болохын тулд ядаж нэг модон завинд суугаад далайн ус руу орох хэрэгтэй шүү дээ.

-Хүмүүс УИХ-д нэр дэвших гэж улайрч байх үед та нэр дэвшихээс татгалзсан. Энэ нь нийгэмд олон таамаг үүсгэж байна. Тухайлбал, улс төрөөс урвасан, дахин нэр дэвшээд сонгуульд ялахгүй гэж үзсэн, хуйвалдсан гэх мэт. Улс төрд нэгэнт орсон хүн гарч чаддаггүй гэдэг. Яагаад гэсэн асуулт Танд тавьж байна?

-Би дараагийн дөрвөн жилд УИХ-д сууж ажиллахаар төлөвлөгөөгүй гэж л хэлж байна. Энэ удаагийн УИХ-ын сонгуульт хугацаа дуусч хүн бүр дараачийн сонголтоо хийлээ. Би ч бусад гишүүний нэгэн адил сонгогчдынхоо өмнө авсан амлалтаа биелүүлж, үүрэгт хугацаагаа дуусгаад одоо шинэ сонголтоо хийх цаг ирж буй учир сайтар эргэцүүлэн бодсон. Монгол Улс зөвхөн УИХ биш шүү дээ. Тэгээд ч бараг хүн бүр УИХ-д орж хууль тогтоогч болох гэж зүтгэх нь өнөө цагийн л давалгаа гэж хардаг. Яваандаа энэ бүх хандлага өөрчлөгдөнө. Бүх хүн энэ зүгт хошуурч байна гэдэг чинь тэр сонголт зөв гэсэн баталгаа огт биш. Би ийм давалгаагаар биш, харин өөрийн хүсэл зорилтоо дагаж сонголтоо хийсэн.

Өнгөрсөн жилүүдэд би олон чухал зорилт хэрэгжүүллээ. Одоо дараачийн зорилт руугаа явна. Миний энэ шийдэл нь Монголын улс төрд байх энгийн утгатай, эрүүл үзэгдэл гэж харж байна. Харин олон хүнийг гайхшруулж байгаа нь энэ цаг үеийн үнэн дүр төрх юм болов уу даа. ■

ОЮУТОЛГОЙН БУЛАН

ХӨГЖЛИЙН ТАСАЛБАР



Б.БАЯРТОГТОХ

Хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй. Хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй. Удирдаж чадахгүй бол боловсронгуй болгож чадахгүй" гэдэг мэргэн үгийг Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх П.Цагаан гуай хэлэх дуртай юм билээ. Өнөөдрийн нийгэмд үнэ цэнэтэй сонсогдох энэ үгийг сэтгүүлийнхээ хуудсанд мөнхлөхөд гэмгүй санагдав. Учир нь, Монголын эдийн засагт өнгөрсөн хугацаанд чамлахаар чанга атгах амжилт багагүй гарсан. Харамсалтай нь бид амжилтын үнэ цэнэ, эдийн засгийн үр ашиг, түүний ач холбогдлыг улс төржүүлээд амьдралынхаа тойргоос хасчихсан сууна.

Өнгөрсөн онд манай улсын ДНБ 17.3 хувиар өсөж, хөгжиж буй улсуудын хөшүүн эдийн засгийг нэг жилийн хугацаанд тэргүүлж, хурдны тоосондоо булсан. Сүүл мушгиж байсан эдийн засгийн царцанги хөгжил тээр ард хоцров. Зээл тусламжийн эрэлд хатдаг байсан Монголын Засгийн газар зээлдэгч орны хэмжээнд хүрлээ. Эдийн засгийн өсөлт ч монголчуудад ердийн зүйл мэт сонсогдох болов. "Бага эдийн засагтай, хөрөнгө санхүүгийн чадамж, дотоод хуримтлал хэт хязгаарлагдмал Монгол орны хувд гадаадын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх чухал эх үүсвэр" хэмээн МУБИС-ийн багш, эдийн засагч Б.Нацагдорж өнгөрсөн онд онцолж байсан нь өнөөдөр биеллээ олжээ.

Үүний илэрхийлэл бол "Оюутолгой" төсөл. Хамтарсан Засгийн газрын үед хөрөнгө оруулалтын гэрээг үзэглэж, зах зээлийн зүг үдэж байсан "Оюу толгой" өнөөдөр монголчуудад ашгаа өгч эхэллээ. Амжилт үүгээр зогсохгүй нь. Зургаан жил шахам хэлэлцсэн төслийн хөрөнгө оруулалтын гэрээ баталгаажсанаас хойших өөрчлөлтийг Та анзаарч байна уу. Холоос бус ойроос амжилтыг хайя.

Нэг: "Оюутолгой"-н хөрөнгө оруулалтын гэрээ монголчуудад ашигтай хэмээн тус компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Камерон Макрей онцолж байв. Өмнөговийн Ханбогдод ил уурхайн хөрс хуулалтын ажил өндөрлөж, бутлуур ашиглалтад ороход бэлэн болжээ. Ил уурхайгаас хүдэр олборлох нь энэ оны наймдугаар сар. Үүцээ задалж буй говь нутагт 100 мянган тонн хүдэр боловсруулах уурхайн барилгын гүйцэтгэл 85 хувьтай явна. Тэгвэл 33 сарын хугацаанд барихаар төлөвлөсөн ч 27 сарын дотор барьж, цаг хугацааг товчилж байна. Монголчуудад наалдах өгөөжийн хэмжээ ч энэ хэрээр ойртож байна гэсэн үг. "27 сарын хугацаанд том бүтээн байгуулалт хийнэ гэдэг дэлхийн хэмжээний рекорд" хэмээн Камерон Макрей онцоллоо.

Хоёр: Нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт "Оюутолгой" төслийн үр өгөөж хүрч байна. Тухайлбал, боловсролын салбар. Монгол Улсын түүхэнд 168 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай сургалтын хөтөлбөрийг уул уурхайн компани хэрэгжүүлж байна. Мэргэжил сургалт үйлдвэрийн гурван ч төв барих (МСҮТ), дөрвөн МСҮТ-ийг сайжруулах ажлыг долоон хот, суурин газарт хийх юм. Мөн салбар яамтай нь хамтран улсын хэмжээнд 1200 багшийг сургахаар болжээ. Түүнчлэн дотоодын их сургуулиудад 200, гадаадын их сургуулиудад 30 оюутанд тэтгэлэг олгох аж.

Гурав: "Оюутолгой" компани энэ оны наймдугаар сараас хүдэр олборлоно. Харин 2012 оны төгсгөл гэхэд баяжуулах үйлдвэрээ нээж, бүтэн хүчин чадлаараа ажиллах юм байна. Ирэх онтой золгон хамгийн анхны алт, зэсийн баяжмалаа өөрсдийн худалдан авагчдаа хүргэх нь. Өөрөөр хэлбэл, зах зээлийн түншдээ бараа бүтээгдэхүүнээ нийлүүлнэ гэсэн үг. Ийм зарчмаар 2013 он гэхэд "Оюутолгой" ил уурхайгаа бүрэн олборлож эхлэх нь. Ил уурхайгаас өдөртөө 100 мянган тонн бүтээгдэхүүн олборлох бөгөөд 2016 оны төгсгөлд далд уурхайн хүдэр олборлолтод шилжихээр төлөвлөжээ. Далд уурхай эхний үедээ өдөрт 20 мянган тонн хүдэр олборлох бөгөөд цаашдаа 85-95 мянган тонн хүртэл хүчин чадалд хүргэхээр тооцжээ. Энэ нь ил уурхайгаас гарч буй хүдрийн хэмжээнээс 2-3 дахин их.

Дөрөв: Улс төр, нийгмийн шүлтүүрт тунгаагдсан "Оюутолгой" төсөл 2010 оны дөрөвдүгээр сард бүтээн байгуулалтаа эхэлж байв. Энэ үед төслийн хөрөнгө оруулагчид аль хэдийнэ нэг тэрбум ам.долларын хөрөнгийг өмнийн говьд оруулсан байлаа. Нэг тэрбум ам.доллараар эхэлж байсан хөрөнгө оруулалтын



хэмжээ өнөөдөр зургаан тэрбум ам.доллар болтлоо тэлжээ. Ирэх оноос далд уурхайг олборлох, баяжуулах үйлдвэрийг өргөтгөхөд ойролцоогоор дөрвөн тэрбум ам.доллар шаардлагатай байгаа гэж Камерон Макрей ярьсан. Тэрбээр, уурхайн үйл ажиллагаа жигдэрч, далд уурхайг ашиглах үед "Оюутолгой" дэлхийд гурав дахь том алт, зэсийн уурхай болохыг онцлон тэмдэглэсэн юм. Өнөөдөр Ханбогд сумын хаяанд буй дэлхийн төсөлд 10 орчим мянган монголчууд бүтээн байгуулалтад гар бие оролцож байна.

Тав: "Оюутолгой" компани хэдий бүтээгдэхүүнээ экспортолж эхлээгүй ч Монголын Засгийн газарт оны эцэст зөвхөн татвар хэлбэрээр 700 сая ам.долларын ашиг орж ирэхээр байгаа аж. Ирэх 2017 он гэхэд хөрөнгө оруулалтын хэмжээ 10 орчим тэрбум ам.доллар болох юм байна. Үүнийг дагаад Монголын Засгийн газарт төлөх татварын хэмжээ ч өссөөр. "Оюутолгой" компани өнгөрсөн онд 250.9 тэрбум төгрөгийн татвар, хураамжийг Засгийн газарт төлжээ. "Оюутолгой" төсөл хэрэгжээгүй бол манай улсын эдийн засаг 2013-2020 онд долоон хувийн өсөлт үзүүлэх байж. Харин төсөл хэрэгжсэнээр дунджаар 12.7 хувийн хувиар эдийн засаг тэлэх тооцоо гарчээ.

Зургаа: "Оюутолгой" компанийн 34 хувийг Монгол Улсын Засгийн газар эзэмшиж байгаа хэдий ч 55 хувийн ашиг хүртэх юм. Ирэх 2013 онд уг төслөөс манайд нэг тэрбум ам.доллар татварт орж ирнэ. Гурван жилийн дараа дээрх татварын хэмжээ хоёр дахин өснө. Таван жилийн дараа уг төслөөс Монголын Засгийн газар 15 тэрбум ам.долларын татварын ашгийг хүртэнэ хэмээн тооцоолжээ. Өнөөдрийн байдлаар "Оюутолгой" компани ашигт малтмал ашигласны төлбөр буюу роялти, нэмүү өртгийн татвар, гаалийн татварыг төлж байгаа. Ирэх 2020 он гэхэд "Оюутолгой" төсөл Монгол Улсын экспортын 50 хувийг бүрдүүлэхээр байна. Түүнчлэн ОУВС-гийн хямдруулсан мөнгөн урсгал аргачлал /төслийн эхэн үед олох орлогыг тооцохгүй буюу хамгийн багаар авч үзэх/-ыг ашиглан тооцоолсноор манай Засгийн газарт ногдох мөнгөн урсгалыг 71 хувь гэж тооцоолжээ.

Долоо: Дэлхийн зах зээлд зэсийн эрэлт хэрэгцээ 2020 он гэхэд 40 хувиар өсөж 27 сая тоннд хүрэх төлөвтэй хэмээн Олон улсын зэсийн холбоо үзжээ. Ирэх 15 жилийн хугацаанд Хятад улс 4-5 сая шинэ барилга, байгууламж барина хэмээн Олон улсын эрчим хүчний агентлаг мэдээлж байна. Өөрөөр хэлбэл, монголчуудад ашигтай зах зээлийн үүд хаалга нээлтэй байгаагийн дохио аж. "Оюутолгой" компанийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Камерон МакРей "Оюутолгой төсөл нь Хятад, Энэтхэг гэх мэт өсөн нэмэгдэж буй том зах зээлтэй ойр байгаа нь давуу тал" хэмээн тэмдэглэсэн юм.

Найм: "Оюутолгой" компани өнгөрсөн онд 1.7 их наяд төгрөгийн бараа үйлчилгээг үндэсний болон орон нутгийн ханган нийлүүлэгчээс авчээ. Өнөөдрийн байдлаар дотоодын 1000 гаруй компани "Оюутолгой"-н ханган нийлүүлэгчээр ажиллаж байна. Төслийн бүтээн байгуулалтад өдөр тутам 10.4 тэрбум төгрөгийг зарцуулж байгаа аж. Барилга корпорацийн дэд ерөнхийлөгч Ш.Эрдэнэбат "Оюутолгойн ханган нийлүүлэгч байх нь бидний бахархал. Манай бизнес өргөжин тэлсэн" гэв.

Түүнчлэн Өмнөговь аймгийн жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгох зорилго бүхий 1.5 тэрбум төгрөгийг ХААН болон Хас банкаар дамжуулан "Оюутолгой" компани олгоод эхэлсэн байна. Эдийн засгийн эдгээр амжилтыг мөн чанар талаас нь харж дүгнэх цаг хэдийнэ болжээ. Олж буй амжилт, хүртэж буй ашгаа байнга үгүйсгэж, хараар будаж таарахгүй. Монголын эдийн засагт гарч буй өсөлтийн өгөөж бүхэн хөгжлийн тасалбар аж. ■

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨРС ШИНЭЧЛЭГДЭНЭ

Ер нь том төсөл хөтөлбөр, төр хоёр асар том захиалагч байдаг гэж хэлж болно. Тавантолгой, Оюутолгой, төмөр зам, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөр гээд яриад байгаа. Тэгэхээр эдгээрийг дагаж жижиг, дунд үйлдвэрлэлээ босгох энэхүү боломжоо ашиглаж төр, засгаас дэмжих хэрэгтэй.

Б.УУГАНБАЯР

Төрөөс сүүлийн жилүүдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр нэлээд хөрөнгө хүч хаяж байгаа билээ. Мөн энэ жилээс хоршоог хөгжүүлэхээр багагүй анхаарч байна. “Хоршоолох аян”-ыг ч орон даяар зарлав. Жижиг, дунд үйлдвэрлэл-хоршоо хоёрыг нэг толины хоёр тал гэж ойлгож бас болох. Тийм ч учраас эдгээр салбарын хөгжил ямар явааг харуулах “Хоршоо-жижиг, дунд үйлдвэр-2012” үзэсгэлэн, худалдаа өнгөрсөн сарын 31-нээс энэ сарын 6-нд улсын хэмжээнд болж байна. Үүнтэй холбоотой Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ц.Ням-Осор, ХХААХҮЯ-ны дэд сайд П.Баянмөнх нараас зарим зүйлийг тодруулаа.

Хүнсний хэрэгцээгээ дотооддоо хангах боломж нэмэгдсээр байна

“Хоршоо-жижиг, дунд үйлдвэр-2012” улсын хэмжээний үзэсгэлэн болж байна. Нэлээд хөрөнгө мөнгө зарцуулан зохион байгуулж буй тус үзэсгэлэнгийн онцлог юу вэ?

-2009 оноос “Хоршоо-жижиг, дунд үйлдвэрлэл” болон “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнг зохион байгуулж эхэлсэн. Энэ жил “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнд 400 гаруй аж ахуйн нэгж оролцож чадаагүй гомдолтой үлдсэн. Тиймээс “Хоршоо-Жижиг, дунд үйлдвэрлэл-2012” үзэсгэлэн ихээхэн хүлээлттэй байсан. Тэр хэмжээгээрээ ач холбогдол өндөртэй болж байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчид өөрсдийн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд танилцуулж, хоорондоо харилцаа холбоо тогтоох, бусдаасаа суралцаж, шаардлагатай шинэ тоног төхөөрөмжтэй танилцахын зэрэгцээ ЖДҮГ-аас тэдэнд зориулсан сургалт сурталчилгааг явуулдгаараа ихээхэн үр дүнтэй. Түүнчлэн 21 аймаг, нийслэлийн төлөөлөл аж ахуйн нэгжүүд оролцдог учир хэрэглэгчдийн хувьд хаана, хэн юу хийдгийг мэдэж авч, сонирхсон бараа, бүтээгдэхүүнээ худалдаж авах боломж ч гардаг. Дараагийн давуу тал нь үзэсгэлэнд оролцогчдод банкууд зээлд хамрагдах чиглэлээр, сургалтын байгууллагууд ч шинэлэг сургалт мэдээллийг өгдөг. Ингээд аваад үзэхээр



Ц.Ням-Осор



хот, орон нутгийн үйлдвэрлэгчид, төрийн бус байгууллагынхан, хэрэглэгчид нэг дор цугладгаараа ихээхэн ач холбогдолтой. Энэ жилийн хувьд аж ахуйн нэгжүүд нэлээд өргөн оролцох шинжтэй байна. Дотоодын үйлдвэрлэгчдээс гадна "Дэлхийн зөн" олон улсын байгууллага, "Тогтвортой амьжиргаа", "Монголд үйлдвэрлэв-II" зэрэг төслөөс оролцох саналаа өгсөн. Байр савныхаа багтаамжаас хамааралд 250 орчим аж ахуйн нэгж оролцох боломжтой. Бидний зүгээс тэргүүний техник технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, орон нутгийн онцлогийг шингээсэн импортыг орлох чанартай бараа бүтээгдэхүүнийг чухалчилж үзэж байгаа юм.

-ЖДҮ эрхлэгчдийн толгойны өвчин болсон барьцаа хөрөнгийн асуудлыг шийдэхээр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталсан. Хуулийн хүрээнд Зээлийн батлан даалтын санг байгуулахаар байгаа. Тус сангийн хөрөнгийг хэрхэн бүрдүүлэх вэ. Бизнес эрхлэгчид бодит үр дүнг нь хэзээнээс хүртэж эхлэх юм бэ?

-Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг өнгөрсөн хавар баталсан. Гэхдээ миний харж буйгаар энэ хууль хэрэгжиж, бодит амьдрал дээр үр дүнгээ өгтлөө багагүй цаг хугацаа шаардана. Энэ хуулийг гаргахдаа мэргэжлийн байгууллага, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийн саналыг тун бага тусгасан. Зээлийн батлан даалтын сангийн хуультай болсон нь сайн хэрэг. Гэхдээ хуулийг хэрэгжүүлэхэд хугацаа, удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр гээд олон зүйл шаардагдана. Одоогоор тус хууль албан ёсоор хэрэгжиж эхлээгүй байна. Учир нь, тус хуулийг хэрэгжүүлэх журмыг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран гаргах ёстой байгаа. Хууль батлагдаад дөрвөн сар орчим болж буй ч журам гараагүй байгаа нь харамсалтай.

Дараагийн нэг чухал зүйл нь дээрх журам гарсны дараа Зээлийн батлан даалтын сангийн хуулийг голлон хэрэгжүүлэх байгууллагыг бий болгох юм. Одоогоор тэр байгууллага нь ямар бүтэцтэй байх, орон даяар ямар сүлжээгээр иргэдэд хүрэх нь тодорхойгүй байгаа. Зээлийг банкуудаар дамжуулж өгөхөөр яригдаж байгаа гэсэн. Энэ нь эргээд банкны үзлээр л шийдэгдэх асуудал болон хувирч, иргэдэд хүндрэл гарах магадлалтай юм. Бид уг нь тухайн үед жижиг, дунд үйлдвэрийн одоо байгаа бүтцийг ашиглаж, санг байгуулъя гэсэн санал тавьсан боловч хэрэгсээгүй. Хуульд гадаад, дотоодын хамтарсан хөрөнгө оруулалттай байгууллагууд нэгдэж, санг бүрдүүлнэ гэж томьёолсон байгаа нь урьдчилсан байдлаар харахад хүндрэл их гарахаар байна.

Зээлийн батлан даалтын санд төвлөрүүлэх хөрөнгө мөнгөний асуудал ЖДҮ-ийн санд тусгагдаагүй. Түүнчлэн төрөөс тухайн зээлийн 60 хувийг нь батлан даана гэсэн байгаа ч яг хэчнээн төгрөгийн дотор гэдэг нь тодорхойгүй байна. Миний бодлоор 100 сая төгрөгнөөс доошхи хөрөнгөтэй буюу жижиг, дунд үйлдвэрийг батлан даавал, олон хүнд хүрч, хүртээмжтэй болох юм. Миний төсөөлж буйгаар Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль энэ оны сүүлчээр, ирэх оноос л хэрэгжиж эхлэх болов уу.

-ЖДҮ-ийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар байгаа. Ямар өөрчлөлт орохоор байна вэ. Хууль гарснаар малчид, ЖДҮ эрхлэгчдийг хэрхэн дэмжих вэ?

-Манай салбарын НӨАТ-тай холбоотой гурван хууль болон ЖДҮ-ийн тухай хуулийг шинэчлэхээр Засгийн газарт өргөн барьсан. Хамгийн түрүүнд ЖДҮ-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгаа. Тус хуульд үндсэн дөрвөн чиглэлийн асуудлыг шийдэж байгаа юм. Үүнд малчин өрхийг үйлдвэрлэгч гэж хүлээн зөвшөөрөх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч гэж хэн бэ гэсэн томьёолол, тодорхойлолтыг гаргах болон жижиг, дунд үйлдвэрлэлд олгож буй зээл, санхүү, лизингийн дэмжлэгийг Засгийн газрын тусгай журмаар зохицуулдаг болгох юм. Тэгэхгүй бол ЖДҮ-ийн салбар уул уурхай, банк, мөрийтэй тоглоом, архи, тамхинаас бусад салбарыг хамардаг учир аль нэг салбар хоорондын эрх ашгийн төлөө ажиллаж байна гэсэн маргаан их гардаг. Тиймээс үүнийг Салбар хоорондын дундын комисс байгуулж зээл олгодог байхаар зааж өгсөн.

Дараагийн асуудал нь аймаг, сум, дүүрэг, сан, яам, тамгын газар бүгд л эрх мэдэлтэй болсон. Гэхдээ чиг үүрэг нь тодорхой бус давхацсан тохиолдол бий. Зарим нь зээлийг сум, дүүрэг, аймаг олгоно гэх мэтээр янз бүрээр ярьдаг. Өнөөдрийн мөрдөж буй хуулиар жижиг, дунд үйдвэрлэлийн томьёолол нь маргаан үүсгэдэг, тодорхой биш байгаа. Тиймээс шинэ хуулиар үйлдвэрийг дараах байдлаар томьёолохоор ярилцаж буй. Үүнд жижиг үйлдвэрлэгч гэдгийг тэрбум хүртэлх төгрөгийн орлоготой, 50 хүртэлх ажилтантай, харин дундад нь бол 3-5 тэрбум хүртэлх төгрөгийн орлоготой, 99 хүртэлх ажилтантайг нь хамруулж, үүнээс дээшихийг нь дундаас дээш гэж үзэхээр байгаа.

-ЖДҮ эрхлэхэд ялангуяа борлуулт худалдааг тэлэх, зах зээлийг нь дэмжихэд төрөөс ямар зохицуулалт хийж байна вэ?

-Намайг гурван жилийн өмнө ЖДҮ-ийн салбарыг хүлээж авахад хэн ч мэддэггүй, сонирхдоггүй байсан. Тухайн үед аль нэг орон нутагт очоод

жижиг, дунд үйлдвэрийг нь сонирхъё гэхэд хоёр цагийн дотор явж үзээд танилцаж болохоор байсан. Өнөөдөр эргээд харахад жишээ нь, Дархан, Эрдэнэт мэтийн томоохон аймгийн жижиг, дунд үйлдвэртэй танилцахад доод тал нь тав хоног зарцуулж байх жишээтэй. Энэ бол үйлдвэрлэл хөгжсөнийг харуулж буй хэрэг. Ер нь юм хийддэггүй хүний нүдэнд ажил ажил болж харагддаггүй. Харин юм хийдэг хүний нүдэнд бол харагддаг. Би салбарынхаа гарт баригдаж, нүдэнд харагдахаар жишээг бодитоор нь хэлье. Манайх тоосгоо импортолж эсвэл аймаг, сумд нийслэлээс зөөдөг байсан. Одоо бүх аймаг, зарим сум хүртэл тоосго үйлдвэрлэдэг болсон. Мөн 2008 он гэхэд бид 83 сая ширхэг өндөг буюу хэрэглээнийхээ 80 хувийг импортолдог байсан бол одоо 80 сая ширхгийг өөрсдөө үйдвэрлэж, 20 хувийг нь л импортоор авч байна. Түүнчлэн хөнгөн цагаан блог дүүргэгч гэж бий. Энэ нь импортын бүтээгдэхүүн байсан бол одоо бүх аймаг өөрсдөө үйлдвэрлэх хэмжээнд хүрээд буй.

Мөн барилгын хавтанг Хятад, Оросоос зөөдөг байсан бол өдгөө бүгдийг нь л дотооддоо үйлдвэрлэж байна. Дээр нь хөдөө, орон нутаг цэвэр ус, талх, нарийн боовоо Улаанбаатараас зөөдөг байсан цаг ард хоцорлоо. Монгол хиам, өргөст хэмхийг импортлохоо огт больсон. Саяхан Дарханд ургамлын тосны үйлвэр ашиглалтад орсон гэх мэтээр өөрсдийн хүнсний хэрэгцээгээ дотооддоо хангах алхам нэмэгдсээр байгаа юм.

-Дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн түлхүү хэрэглэдэг болох сэтгэлгээг иргэдэд хэрхэн бий болгох вэ?

-Дотоодын зах зээлээ хамгаалахын тулд Засгийн газрын 103 дугаар тогтоолоор зөвхөн дотоодоосоо худалдаж авах 37 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүний жагсаалт гаргасан. Энэ сайн хэрэгжихгүй байгаа болохоор ЖДҮ-ийн тухай хуулийн шинэ найруулгад хуульчилж тусгаж өгсөн. Ингэхдээ дээрх хуульд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах заалт нэмж өгсөн. Энэ нь ямар ач холбогдолтой вэ гэвэл, ямар ч яам, тамгын газар, байгууллага төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээг авахдаа зөвхөн дотоодоосоо худалдаж авахаар зааж өгч буй. Тэгэхээр ЖДҮ-ийн тухай хууль батлагдвал дээрх заалт ч хэрэгжиж эхэлнэ.

Түүнчлэн уул уурхайн томоохон хөрөнгө оруулалтыг дагасан кластерийн системийг хөгжүүлэх заалт ч байгаа. Жишээ нь, Японы “Тоёота” корпорацийг дагаж шил, толь, гишгүүрийн гэх мэт жижиг эдлэл хэрэгслийг хийх, орон нутгийн 23 мянга орчим жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байгаа юм. Үүнийг бүр хуульд тусгаж өгсөн байдаг. Ер нь том төсөл хөтөлбөр, төр хоёр асар том захиалагч байдаг гэж хэлж болно.

Тавантолгой, Оюутолгой, төмөр зам, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөр гээд яриад байгаа. Тэгэхээр эдгээрийг дагаж жижиг, дунд үйлдвэрлэлээ босгох энэхүү боломжоо ашиглаж төр, засгаас дэмжих хэрэгтэй. Хэрэглэгчиддээ хандаад хэлэхэд, дотооддоо үйлдвэрлэж буй цэвэр экологийн бүтээгдэхүүнээ голоод лаазалсан, химийн аргаар хадгалсан бүтээгдэхүүнд хошуурч эрүүл мэндээ хордуулахаа болиочээ гэж уриалмаар байна. Дэлхий нийтээр эрүүл, цэвэр, экологийн хүнсийг илүүд үзэх болсон. Гэхдээ үндсэн хэрэглэгчид сүүлийн үед дотоодын бүтээгдэхүүнээ худалдаж авах хандлагатай болж байгаа. Тиймээс манай хэрэлэгчид сэтгэхүйдээ өөрчлөлт хийж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, эрүүл мэндээ ч, улсынхаа хөгжлийг бодсон ч аль болох дотоодын бүтээгдэхүүнээ илүүд үзэх хэрэгтэй.

Түүхий эд бэлтгэлийн үндэсний сүлжээтэй болно

-Засгийн газраас “Хөдөөг хоршоолох аян” зарласан



П.Баянмөнх /ХХААХҮЯ-ны дэд сайд/

нь улсын эдийн засагт ямар үр өгөөж, чадамжийг бий болгох вэ. Нөгөө талаас малчид, иргэдийн амьдрал, орон нутгийн хөгжлийг сайжруулахад ямар үр өгөөж өгч чадах вэ?

-Улсын хэмжээнд өнгөрсөн оны жилийн эцсээр 155 мянган малчин өрх тоологдсон байгаа. Эдгээр нь жилдээ 17-18 мянган тонн ноос, 200 гаруй мянган тонн мах, 5.5 мянган тонн орчим ноолуур, 10 сая орчим ширхэг арьс шир үйлдвэрлэж байгаа юм. Үүнийг мөнгөн дүнгээр аваад үзвэл мал аж ахуй 1.6 их наяд төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулж байдаг үр өгөөжтэй салбар л даа. Бид хөдөө, аж ахуйн салбарын уламжлалт, тогтвортой хөгжих хэлбэрийг хоршоо гэж үзэж байгаа.

Төрөөс малчид болоод хоршоог дэмжсэн бодлого хөтөлбөрийг 2008 оноос явуулж эхэлсэн. Үүнд “Монгол мал” хөтөлбөр, Хөдөө, аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн Биржийн тухай хууль, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын 30 дугаар тогтоолоор хоршооны гишүүн малчдад илүү давуу эрх, урамшууллыг олгохоор зааж өгсөн байгаа. Хоршоо байгуулагдсанаар гарах бас нэг давуу тал нь бүтээгдэхүүн олон шат дамжлага дамжин иргэдийн гар дээр өндөр үнээр очдог байдал арилах ёстой. “Хөдөөг хоршоолох аян” гурван жилийн хугацаанд үргэлжилнэ. Энэ хугацаанд бид түүхий эд бэлтгэлийн үндэсний сүлжээгээ бий болгож, зах зээлийн системээр



явуулах хэмжээнд хүргэхийг зорьж байгаа.

-“Хөдөөг хоршоолох аян”-ыг явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээл нь юу байна вэ?

-Иргэд хоршооныхоо үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, удирдлагуудаа шахаж, үйл ажиллагаандаа хяналт тавьж байх хэрэгтэй. Энд иргэдийн хүчин чармайлт, хичээл зүтгэл, оролцоо хамгаас чухал гэсэн үг. Мөн хоршооны удирдлага төрөөс олгож буй тусламж дэмжлэгийг завших, буруу замаар ашиглах тохиолдол ч гардаг. Тэгэхээр үүнд иргэдийн хяналт болон чадварлаг боловсон хүчний хэрэгцээ шаардлага бий. Тиймээс бид ирэх оноос ХААИС-д хоршооны боловсон хүчин бэлтгэх чиглэлээр анги нээх гэж байна.

Монголын ихэнх хоршоо өнөөдрийг хүртэл эзэн төвтэй хөгжиж ирсэн. Энэ хандлагыг бүх гишүүдийнх болгохоор зорьж байна. Тиймээс энэ сэтгэлгээнээсээ хаа хаанаа салж, хоршооны үр шимийг ойлгох хэрэгтэй. Мөн малчдын хувьд хоршооны гишүүн болсноор малчин нийгмийн амьдралд идэвхтэй оролцохын зэрэгцээ бүтээгдэхүүнээ 100 хувь ашиглах боломж бүрдэх юм. Түүнчлэн хоршооноос иргэн шаардлагатай санхүүгийн дэмжлэгээ авах, бараа бүтээгдэхүүн авч, харилцан уялдаа холбоотой ажиллах нь чухал.

-Хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль батлагдсан. Тус хуулийн хэрэгжилт өнөөдөр ямар бодитой зүйлээс эхэлж байгаа вэ?

-Биржийн тухай хууль энэ сарын 1-нээс хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлнэ. Гэхдээ хууль хэрэгжсэний маргаашаас нь биржийн үйл ажиллагаа эхлэх боломжгүй. Бид бэлтгэлээ базааж байна. Манай яамны зүгээс “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” төслийн нэгжийг ажиллуулахын зэрэгцээ Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж байгаа. Биржийн тухай хуультай холбоотой дагалдах хуулиудад өөрчлөлт оруулах мөн үүнтэй холбоотой 15 журмыг бэлтгэж байна. Түүнчлэн биржийн ТЭЗҮ-ийг мөн хийсэн. Биржийн зохицуулах зөвлөлийг удахгүй байгуулна. Энэ мэтчилэн саваа бэлдэхээр саалиа бэлд гэгчээр бирж байгуулах бэлтгэл ажлаа базааж л байна.

Дэлхийн олон оронд сүүлийн 20 жилийн хугацаанд дотооддоо болон гадаадад үйл ажиллагаа явуулдаг түүхий эдийн бирж олноор байгуулах болсон. Манай улсад малчдад малын гаралтай түүхий эдээ худалдаалах, үйлдвэрлэгчид түүнийг худалдаж авах хэрэгцээ байсаар байгаа ч тэр бүр нэгдсэн системтэй байж чадахгүй байна. Тиймээс малчдын амьжиргааны түвшин тогтворгүй байх, үндэсний үйлдвэрүүд түүхий эдээр дутагдах, түүхий эдийн бэлтгэлийн нийт зардал харьцангуй өндөр байна. Энэ байдлаасаа бид гарах арга хэмжээ яаралтай авахгүй бол гадаад улсын түүхий эдийн бааз болох эрсдэл ч бий.

-Түүхий эдийн бирж байгуулахад малчид, бэлтгэн нийлүүлэгчид, төр, засгийн зүгээс ямар байдлаар оролцох вэ?

-Төрөлжсөн бирж нь нэг ёсондоо малчин, үйлдвэрлэгч хоёрыг холбож өгөх гүүр болно. Ингэхдээ малчин салбарын яамнаас гаргасан жагсаалтад багтсан түүхий эд, бүтээгдэхүүнээ сумандаа байгуулагдсан хоршоогоороо дамжуулж биржид гаргаж худалдаалах юм. Харин үйлдвэрлэгчид, худалдан авагчид нь мөн биржээрээ дамжуулж хэчнээн хэмжээний ямар түүхий эд авахаа захиална гэсэн үг. Нэг үгээр хэлбэл, бирж нь зориулалтын байртай байх бөгөөд арилжааг зохион байгуулах программ хангамж, цахим сүлжээтэй байх юм. Түүгээр дамжуулж орон нутгийн малчид арилжаанд орно гэсэн үг.

Хөдөө, аж ахуйн бирж малчид, үйлдвэрлэгчид цаашлаад улс орны эдийн засагт ихээхэн үр дүнгээ өгнө. Юун түрүүнд түүхий эд бэлтгэлийн тогтсон тогтцолцоотой болно. Ингэснээр оролцогчдын зах зээлд нэвтрэх боломжийг нээж өгч тэдний хариуцлагыг өндөржүүлж, тэгш байдлыг хангана. Мөн бараа түүхий эдийн чанар сайжирч, агуулах, тээврийн үйлчилгээ нэмэгдэн, түүхий эдийн зах зээлийн ил тод байдал сайжирна. Брокер, банк санхүү, даатгал, мэдээллийн технологийн салбарт ч сайн нөлөө үзүүлнэ. Түүхий эд бэлтгэлийн чиглэлээр энэ салбарт удаан ажиллаж буй хүмүүс бидний туршлага, эдийн засгийн боломж болон агуулах савны боломжийг ашиглаач гэсэн саналыг тавьсан. Тэгэхээр тэд өөрсдөө брокер диллерийн компани болж, төрийн сүлжээнд орж, хамтран ажиллахаар болж байгаа юм. ■

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

АМЬ НААНА, ТАМ ЦААНА

Долдугаар сарын 1 гэхэд шинэ хуульд нийцүүлэн компанийнхаа дүрмээ өөрчилж, Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлэх өөр нэг даалгавар ч нэмэгдсэн байгаа. Тиймээс олон жил данс тооцоо нь зуун задгай явсан компаниуд хурлаа хийж, дүрмээ шинэчилнэ гэдэг амаргүй ажил.

Б.УУГАНБАЯР

Компанийн захирлууд юун сонгуультай манатай, амьсгаа дээр явна. Учир нь, өнгөрсөн өвөл шинэчлэгдэн батлагдсан Компанийн тухай хууль захирлуудыг ийн аг маггүй адгаж сандрахад хүргэжээ. Монгол Улсын хөгжил дэвшилтэй холбоотойгоор Компанийн тухай хууль удтал дуншиж, нийгэмд их хүлээлт үүсгэн байж шинэчлэн батлагдсан билээ. Нэг үгээр хэлбэл, нийгмийн захиалгаар хийгдсэн гэж үзэж болно.

Тийм болохоор манай эдийн засаг, санхүүгийн хөгжил, харилцаанд ихээхэн ач тус авчрах сайн хууль болсон гэж батлагдсаных нь дараахан бизнесийнхэн болоод холбогдох албаныхан ам сайтай байсан. Энэ тухай ч манай сэтгүүл өмнө нь бичиж байсан билээ. Тэгвэл одоо бахдан хүлээж авсан хуулиа хэр уриалгахан хэрэгжүүлж байгааг харах цаг хугацаа болжээ. Ийм хурдан хэрэгжилтийг нь шалгаад эхэлдэг хууль гэж байдаг байх нь ээ гэж уншигч Та гайхаж магад. Энэ бол зөвхөн Компанийн тухай хуулийн онцлог гэх үү дээ.

Шинэчлэл 1

Хамгийн нэгдүгээр асуудал хуучин хуульд ч байсан заалт л даа. Хувьцаат компани хувь эзэмшигчдийн хурлаа жил бүрийн тавдугаар сарын 1-ний дотор багтаан хийж, улмаар Төрийн өмчийн хороо, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх ёстой гэсэн заалттай. Гэвч хуулийн энэ заалтыг компанийнхан нохой хуцахын чинээ боддоггүй байсан учраас өмнөх Компанийн тухай хууль цаасан дээр л хэрэгждэг байсан хэрэг. Ямар сайндаа л 130-аад компани бүр хаана байрлаж, ямар үйл ажиллагаа явуулдаг нь тодорхойгүй ор сураггүй байх вэ дээ. Тэгвэл шинэ хууль ногдол ашиг тараадаггүй, санхүүгийн тайлангаа гаргадаггүй, хувь нийлүүлэгчдийн хурлаа зарладаггүй том толгойтой захирлуудын хандыг хага дарах хэмжээний чанга болжээ. Нэг үгээр хэлбэл, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг илүү хамгаалж, ТУЗ-ийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж өгснөөрөө тус хууль тун догь болсныг хууль боловсруулахад оролцсон хүмүүс болоод холбогдох албаныхан онцлон тэмдэглэж буй юм.

Түүнчлэн хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа буюу ТУЗ, гүйцэтгэх захирал ажлаа хэр сайн хийж байгаа болон өөрийнх нь хөрөнгийг юунд зарж, хэр ашиг олж буйг мэдэх, ногдол ашиг хүртэх эсэхээ мэдэх боломжийг хувьцаа эзэмшигчдийн хурал олгодог. Гэвч өмнө нь энэ хурал нэр төдий л явагдаж, хурлаа хийж буй эсэх нь тодорхойгүй, хувьцаа эзэмшигчдээ ч бүрэн хамруулахгүй, хурлын үр дүнг мэдээлдэггүй байсан.

Шинэ хуулиар энэ байдлыг бүрэн таслан зогсоож, жил бүрийн тавдугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж, зургадугаар сарын 1 гэхэд хурлаар хэлэлцсэн материалаа Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо болон Төрийн өмчийн хороонд ирүүлэх ёстой аж. Урьд нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар юу хэлэлцэж, ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй байдаг байсан бол шинэ хуульд хэлэлцэх асуудлыг нь ч нарийвчлан зааж өгчээ. Үүнд, компанийн ирэх жилийн төсөв, төлөвлөгөө, ТУЗ-ийн гишүүдээ сонгосон байх 3/1 хараат бус байна/,компанийнхаа үйл ажиллагааны дүрмийг шинэ хуульд нийцүүлэн батлах, жилийнхээ үйл ажиллагааны тайланг ТУЗ-аар хэлэлцүүлсэн, Аудитын байгууллагын дүгнэлт, Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчддээ тараах эсэх, үгүй бол яагаад тараахгүй байгаа зэргийг нэг бүрчлэн хэлэлцсэн байх гэнэ.

Шинэчлэл 2

Хувьцаат компани бүрт ТУЗ гэж нэгэн орон тоо бий. Тухайн компанийн хувьд хөгжил дэвшил, ил тод, хариуцлагатай байдал, санхүү сайн, муу байх нь уг нь бол энэ гурван үгнээс хамаарах учиртай санж. Гэтэл манай компаниудын өнөөдрийг хүртэл явж ирсэн замналаар хамгийн хариуцлагагүй, тоо гүйцээсэн, бэлгэ тэмдгийн шинжтэй зүйл нь ТУЗ байсаар ирсэн билээ. Хуульд ТУЗ-ийн гишүүдийн тоо есөөс дээш байна гэж заасан учраас тоо гүйцээх гэж ТУЗ-д ах дүү хамаатан садан, эхнэр хүүхдээ хүртэл оруулах нь бий. Тийм болохоор тэднээс ажил амжилтын талаар юу ч хүлээгээд нэмэргүй. ТУЗ-ийн гишүүд өөрсдөө ч албан



тушаалынхаа учир утгыг мэдэхгүй давхиж явдаг байв. Тэгвэл шинэ хуулиар ТУЗ-ийн үүрэг хариуцлага, хийх ажлыг нь маш тодорхой болгожээ. ТУЗ-ийн нийт гишүүдийнх нь 3/1 нь хараат бус гишүүн байх аж. Тэгээд зогсохгүй ТУЗ-ийн дор хараат бус гишүүдээс бүрдсэн Аудитын, Нэр дэвшүүлэх, Урамшууллын гэсэн гурван дэд хороог ажиллуулахаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, хий хоосон нэр зүүчихээд, хийх ажлаа мэдэхгүй, ямар ч үүрэг хариуцлагагүй явдаг байсан нөхдүүд дороо гурвын гурван дэд хороотой болчихож байгаа учраас булталт газаргүй. Тэдний ажилд хяналт тавих Аудитын дэд хороо, урам хийгээд сэтгэлийн дэм өгөх Урамшууллын дэд хороо, мөн ТУЗ-д хэний нэрийг дэвшүүлэх вэ гэдэг асуудал захирал биш, тусгай дэд хорооны мэдэлд очиж байгаа нь олзуурхууштай зүйл юм.

Шинэчлэл 3

Мөн долдугаар сарын 1 гэхэд шинэ хуульд нийцүүлэн компанийнхаа дүрмээ өөрчилж, Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлэх өөр нэг даалгавар ч нэмэгдсэн байгаа. Тийм ээс олон жил данс тооцоо нь зуун задгай явсан компаниудын хувьд хурлаа хийж, дүрмээ шинэчилнэ гэдэг амаргүй ажил. Гэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойш тав, зургаан сар өнгөрч байгаа учраас тэдний хувьд асуудалд анхнаас нь мэрийлттэй хандсан бол бас ч гэж тийм ч их адгаж тэвдээд байхгүй байсан. Гэхдээ тоомжиргүй хэнэггүй хандвал аюултай. Хуулиар хүлээх үүрэг хариуцлага өндөр. Хэрвээ товлосон хугацаанд хуульд нийцүүлэх зүйлүүдээ хийгээгүй байх юм бол ТУЗ нь эрх зүйн чадамжгүй болж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөөр торгох хатуухан шийтгэлтэй нүүр тулж буй.

Одоогоор албан ёсоор үйл ажиллагаа явуулж буй, хурлаа хийж, тайлангаа ирүүлэх ёстой 200 компаниас өнгөрсөн сарын 20-ны байдлаар 140 нь СЗХ-нд мэдэгдлээ ирүүлжээ. Харин үлдсэн 60 орчим компанийн хувьд хуулиараа бол байдал эвгүйдэх тийшээгээ хандсан яваа гэсэн үг. Ёстой нөгөө амь наана там цаана яваа хэрэг. Холбогдох албаны хүний мэдээллээр дээрх 60 компанийн зарим нь хувьцаа эзэмшигчдийн хурлаа хугацаа хожимдуулан тавдугаар сарын дундуур хийсэн сурагтай. Уг нь тухайн компаниуд хурлаа хугацаа хожимдуулж хийсэн тохиолдолд компанийнх нь үйл ажиллагааг зогсоох хүртэл хатуу арга хэмжээ авах ёстой. Харин СЗХ-ныхон захирлуудыг шинэ хуультайгаа танилцаж, учрыг нь олж, хужрыг нь тунгаах гэж адгаж яваач нь сонсоод өршөөнгүй хандаж байгаа аж. Хууль л бол хууль баймаар. Шинэ хууль гээд толгойг нь илээд байвал толгой томтой компанийн захирал, ТУЗ шинэчлэгдэнэ гэж найдахад юу л бол.

Манай улсад өнгөрсөн онд Үндэсний стастикийн хорооноос гаргасан судалгаагаар 65 мянга орчим аж ахуйн нэгж байгаагаас 330 орчим нь хувьцаат компани /ХК/ хэлбэртэй байдаг байна. Тэдний 20 орчим нь төрийн өмчит аж. Гэтэл эдгээр компани хувь эзэмшигчийн хурлаа хийхгүй, санхүүгийн тайлангаа гаргахгүй, ногдол ашгаа тараахгүй байх нь энүүхэнд. Өөр нэг хэцүү асуудал нь ХК-ийн ихэнх нь “гэр бүлийнх” /цөөн хүний эрх мэдэлд байдаг/ учир жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг уландаа гишгэж, өөрсдийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргаж дураараа аашилж, дунд чөмгөөрөө жиргэдэг болохыг Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаяр онцолсон.

Нөгөө талаас жижиг хувьцаа эзэмшигчдэд ч эрхээ хамгаалуулах тогтолцоо байдаггүй учир нүдээ аниад өнгөрч, том хувьцаа эзэшигчдийг өөгшүүлсээр иржээ. Түүнчлэн төрийн өмчит ХК-ийн хувьд тендерийн асуудал маргаантай байдаг, танил талаа хардаг гэсэн шүүмжлэл ч тасардаггүй. Энэ нь ХК-иудын засаглал муу, хяналтын тогтолцоо байхгүй, эхнээсээ зөв голдиролоор яваагүйтэй холбоотой гэдгийг ч тэрбээр хэлсэн.

Сорондох хүч

Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх нь компанийн засаглалыг сайжруулна гэж ойлгож болох юм. Манай компанийн захирлуудын дотор хууль хэрэгжүүлэх нь байтугай, компанийн засаглал гэдэг томьёоллоо ч ойлгохгүй өнөөдрийг хүрсэн нь бий л байх. Гэхдээ хуулиа сайн дагаж мөрддөг засаглал сайтай компани

ч өнгөрсөн хугацаанд цөөнгүй төрж гарсан. Тэр дундаа банк, санхүүгийн салбарынхан компанийн сайн засаглалыг манлайлан хэрэгжүүлж буй талаар Компанийн засаглалын үндэсний төвийн тэргүүн Ж.Үнэнбат өнгөрсөн сарын 9-нд болсон "Монголын компанийн засаглал V" форумын үеэр сайшааж байсан. Тэрбээр хэлэхдээ "Компаниуд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байж л хөрөнгө мөнгө татаж чадна. Харин энэ нөхцөлийг компанийн засаглал бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хөшүүрэг болдог" хэмээв.

Харин "Тэнгэр" санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал М.Болд "Зөв ашиглаж чадвал чадварлаг боловсон хүчин, хөрөнгө, мөнгийг сороонздох хүч" гэсэн бол мөн л Монголдоо компанийн засаглалаараа дээгүүрт бичигдэх "Ньюком" компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан "Сайн засаглалтай компани гэдэг хариуцлагатай, өрсөлдөх чадвартай байхын нэр" гэсэн юм. Тэгвэл сайн засаглалын үр дүнг гайхуулж яваа компанийн жишээгээр "Ремикон"-ыг дурдаж болох. Тус компани бетон зуурмагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дотоодын болон гадаадын зах зээлд хувьцаа гарган гурван жилийн дотор хоёр сая төгрөгийн хувьцааг 14 тэрбум болтол нь өсгөж амжилттай яваа юм.

Компанийн засаглалын талаар Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болд "Монголын эдийн засгийн эргэлтэд байгаа нийт салбарын 90 хувь нь хөрөнгийн зах зээл дээр гараагүй байна. Тиймээс компаниудад хөрөнгө мөнгөө арвижуулах боломж их бий. Гэхдээ манай хувийн хэвшлийн салбар шинэ байгаа учир юун түрүүнд засаглалаа сайжруулах шаардлага тулгарч байна" гэв. Нөгөө талаас манай эдийн засгийн эрчимтэй өсөлтийн энэ үед гадаадын томоохон компани, корпорациуд Монголын зах зээлийг өлөн нүдээр харж, аль болох ахиухан ашиг олохыг анаж буй нь нууц биш. Энэ тохиолдолд монголчууд компанийн засаглалаа сайжруулж байж тэдэнтэй өрсөлдөх хөрөнгө мөнгөө өсгөж, эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэж чадна гэдгийг ч Монголын банкуудын холбооны гүйцэтгэх захирал Л.Төр-Од онцолсон юм.

Тэгэхээр өнөөдөр манай компаниудад засаглалаа сайжруулж, нийтийн эрх ашгийг бодон, хөрөнгө мөнгөө нэмэгдүүлж, улс орондоо хөрөнгө оруулалт хийх уужим сэтгэл, урт ухааныг цаг үе шаардаж байна. Хувиа бодож, довоо шарлуулдаг аминчхан бодол, туйлбаргүй сэтгэлгээнээсээ салж, шинэ хуулиа хэрэгжүүлэх хоншоортой байхыг компаниуддаа уриалъя. ■

ЭРТЭЧ МОНГОЛ

ӨГЛӨӨ ҮГҮЙ ХҮНД АМЖИЛТ, ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛЬ НЬ Ч БАЙХГҮЙ

"Эртэч Монгол"-ын 48 дахь уулзалт хотоос 100 км орчим зайтай Төв аймгийн Борнуур сумын Далын ам гэдэг газар байрлалтай Бурханч лам Г.Пүрэвбатын "Аглаг" бүтээлийн хийдэд болсон юм.

Б.ОТГОНБАЯР

Нар мандаж их хотод нэгэн шинэ өглөө эхэллээ. Нийслэлчүүдийн олонхи нь ажилдаа яарч, замын түгжрэлд уураа барж, адгаж явахад нэг хэсэг нь "Улсын их" дэлгүүрийн зургаадугаар давхарт өглөөний цай уунгаа, шинэхэн мэдээллээр оюунаа тэлж сууна. Энэ бол "Монгол тэмүүлэл" төрийн бус байгууллагаас зохион байгуулдаг "Эртэч Монгол" өглөөний уулзалтынхан юм. Монгол хүний хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг тус төрийн бус байгууллагыг "Номин холдинг"-ийн зөвлөх, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан А.Шагдарсүрэн гуай үүсгэн санаачилсан байна. 14 хоног тутамд нэг удаа 07.30-08.30 цагийн хооронд болдог уг уулзалтаар сурсан мэдсэнээрээ бусдад үлгэр дууриал болохуйц хүмүүсийг урьж лекц сонсдог аж.

Шуугиант амьдралын хэмнэлд хөл нийлүүлэн, өөрийгөө ч анзаарах сөхөөгүй ажиллаж, амьдарч буй нийслэлийн иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг уриалж буй "Монгол тэмүүлэл" төрийн бус байгууллагын энэ үйл ажиллагааг "Mongolian Economy" сэтгүүл дэмжиж, хамтран ажиллах болсондоо таатай байна. Монгол хүний оюуны хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа нь манай сэтгүүлийн бодлогод нийцэж буй учраас бид сэтгүүлийнхээ энэ дугаарааас эхлээд "Эртэч монгол"



Бурханч лам Г.Пүрэвбатын “Аглаг” бүтээлийн хийд

Фотог Э.Зоригт

гэсэн булан нээлээ. Манайхан нэг удаагийнх нь уулзалтыг сонирхож очих үеэр түүхийн ухааны доктор, академич Ж.Болдбаатар илтгэл тавьж таарсан. Тэрбээр “Монголчууд ялангуяа монгол залуус хөгжлөө дагаад сүүлийн үед шөнийн амьдралтай болж байна. Тэд интернэтээр шөнөжин хэсэж, хэрэгтэйгээсээ хэрэггүй нь их мэдээлэл сонирхож, кино ший үзэж, баар цэнгээний газраар тэнүүчилж байгаа нь буруу дадал юм. Иймэрхүү шөнийн амьдралд умбаж умбаж, амарсан хүмүүс өглөө орноосоо босох тэнхэлгүй, бага үдээс хойш босдог. Тийм хүмүүст ажлын бүтээмж байхгүй. Тиймээс залуусыг өглөөний амьдралтай болгох хэрэгтэй” хэмээн уриалсан. Түүний үзэж буйгаар XIII зууны үед Монгол Улс хүчирхэг байсны шалтгаан нь хүлэг мориор салхи татуулан хурдлан давхидаг нөгөө талаас иргэд нь эртэч, хурдтай амьдралын хэв маягтай байсантай холбоотой аж. Тэгвэл шинэ цагийн монголчуудад хурд дутагдаж байна гэдгийг тэрбээр онцолсон.

Бурханаас хүн бүхэнд ижилхэн сайхан хувь тавилан заяадаггүй ч харин өөрийгөө хөгжүүлж, амьдралаа цогцлоон бүтээх цаг хугацааг ижил тэгш өгдөг. Харин цагаа хэр үр дүнтэй өнгөрүүлж буйгаас тухайн хүний амьдрал ямар байх нь шалтгаална. Японы эрдэмтэн Сайшо Хирошигийн хийсэн судалгаагаар сүүлийн арваад жилийн дотор япон иргэдийн өглөө босох хугацаа 30 минутаар урагшилсныг тогтоожээ. Манай өвөг дээдэс ч эрт дээр үеэс хүүхдүүдээ нойронд сэргэг байж, ихийг хийж бүтээх ухааныг багаас нь заадаг байсан.

Мөн 05.00-07.00 цагт хүний тархи хамгийн сэргэг идэвхтэй байдгийг “Өглөөний хүн” номонд дурджээ. Тиймээс дээрх цагт хэл сурах, үг цээжлэх төлөвлөгөө гаргах зэрэг сэтгэл хөдлөл багатай зүйлийг хийхэд тохиромжтой байдаг аж. Түүнчлэн амжилтад хүрсэн хүмүүсийн олонхи нь өглөө эрт босч, цагийг үр дүнтэй өнгөрүүлэхийн төлөө шаргуу хөдөлмөрлөсөн байдгийг санахад илүүдэхгүй биз ээ. Хэрэв Та өглөөг алдах юм бол ажлын амжилт эрч хүчээ алдаад зогсохгүй эрүүл мэндээ ч гээх юм.

“Эртэч Монгол”-ын 48 дахь уулзалт хотоос 100 км орчим зайтай Төв аймгийн Борнуур сумын Далын ам гэдэг газар байрлалтай Бурханч лам Г.Пүрэвбатын “Аглаг” бүтээлийн хийдэд болсон юм. Тус хийд хэвлий дороо найман өндөг дарсан хангарьдын толгойтой арслангаар үүдээ мануулж, дотроо бурхад болон тэнгэр, газар, тамын орныг уран зургаар дүрслэн харуулжээ. “Аглаг” бүтээлийн хийд гэсэн нэрэндээ таарсан ой модоор хүрээлэгдсэн, өндөр уулын оройд орших. Алсаас харахад сүмийн орой гялалзаад сүр жавхаатай. Их хөрөнгө мөнгө гаргаж бүтээсэн нь илт тус хийд гаднын жуулчдад ч тун сонирхолтой байхаар юм билээ.

Цэвэр цэнгэг агаар, хараа булаам байгаль, ариун сүм хийдэд лекц сонсохоор ирсэн эртэч монголчууддаа Бурханч лам гурван зүйлийг онцгойлон захисан юм. Нэгдүгээрт, хаана ч байсан мөргөж байхын учир утгын тухай тайлбарлав. Учир нь, мөргөлөөр хүний хилэнц арилж, надаас илүү хүн байхгүй гэх омог нь дарагддаг байна. Биднийг ч сүмд ирсэнийх Ганжуурын 108, Данжуурын 226 ботид мөргөөд, адис аваад явахыг захисан. Хүн өдөрт 108 удаа мөргөхөд цусны эргэлт сайжирч, хор гадагшлан, биеийн илүүдэл жингээсээ амархан ангижирч болох нь ээ.

Солонгосын эмч нар мөргөлөөр эдгэхгүй өвчин байхгүйг тогтоосон гэдгийг тэрбээр онцолсон. Хоёрдугаарт нь, хоол унд идэхдээ сайн залбирч байх тухай ярьсан. Ингэхдээ хоол цайныхаа дээжийг уул усандаа өргөөд “Ирээдүйд хамаг амьтан самадын идээг идэх болтугай” гэж хэлэх ёстой аж. Мөн шинийн найман, 15, битүүнд мацаг барьж байвал ходоод гэдэс цэвэршиж, нүдний хараа сайжирдаг байна. Гуравдугаарт, хүн оройд зөв унтаж сурах хэрэгтэй. Унтахын өмнө бясалгаж, сайн зүйлийг бодож тайван унтах бөгөөд аль болох хатуу ор сонгох нь зүйтэй гэсэн. Байгалийн үзэсгэлэнт сайхан газар сонирхолтой, сургамжтай лекц сонсож, буян хурсан тус арга хэмжээнд “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон оролцсондоо баяртай байна. ■